

Хууль зүй, дотоод
хэргийн яам

Олон улсын
санхүүгийн корпораци

**ТӨЛБӨРИЙН ЧАДВАРГҮЙДЛИЙН ТУХАЙ
ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨ ТООЦОХ
СУДАЛГААНЫ ТАЙЛАН**
(Захиалгат судалгаа)

2019
Улаанбаатар хот

АГУУЛГА

НЭГ. ТАЙЛАНГИЙН БҮТЭЦ, ҮР НӨЛӨӨ ТООЦОХ СУДАЛГААНЫ ҮНДСЭН ШАЛГУУР	2
1.1. Шалгуур үзүүлэлтийг сонгосон үндэслэл, хуулийн төслийн үр нөлөө тооцох хэсгийг тогтоосон байдал	2
1.2. Урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох	3
1.3. Үр дүнг үнэлж, зөвлөмж өгөх	3
ХОЁР. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН ДАГУУ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ТООЦСОН НЬ	4
2.1. Шалгуур үзүүлэлт: Зорилгод хүрэх байдал	4
2.1.1. Дотоодын хэрэгцээ, шаардлагын дагуу тодорхойлсон зорилгод хүрсэн байдал	4
2.1.2. Олон улсын бизнесийн эрх зүйн зохицуулалтын хүрээнд зорилгодоо хүрсэн байдал	6
2.2. Шалгуур үзүүлэлт: Ойлгомжтой байдал	12
2.3. Шалгуур үзүүлэлт: Практикт хэрэгжих боломж	22
2.3.1. Хуулийн төслийг хэрэгжүүлэх боломжтой эсэх	22
2.3.2. Хуулийн төслийг хэрэгжүүлэх субъект байгаа эсэх	25
2.3.3. Хэрэгжүүлэгч субъектэд тухайн хуулийн зохицуулалтыг хэрэгжүүлэх боломж, бололцоо /санхүү, хүний нөөц зэрэг/ байгаа эсэх:	29
2.4. Шалгуур үзүүлэлт: Зардал	31
2.5. Шалгуур үзүүлэлт: Харилцан уялдаа	32
2.5.1. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуультай харилцан уялдсан байдал.	32
2.5.2. Бусад хууль тогтоомжтой харилцан уялдсан байдал	43
2.5.3. Олон улсын эрх зүйн хүрээнд харилцан уялдсан байдал буюу Үндэстэн дамнасан төлбөрийн чадваргүйдлийн загвар хууль	56
ГУРАВ. ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГӨХ НЬ	57
3.1. Шалгах хэрэгслийг хэрэглэсэн үр дүнг баримтжуулах	57
3.2. Судалгааны үр дүнг үнэлэх нь	58
3.2.1. Зорилгод хүрэх байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлэх нь	58
3.2.2. Ойлгомжтой байдал ба практикт хэрэгжих боломж шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлэх нь	59
3.2.3. Зардал тооцох шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлэх нь	61
3.2.4. Харилцан уялдаа шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлэх нь	61
3.3. Үнэлгээний үндсэн дээр зөвлөмж гаргах нь	65

ТӨЛБӨРИЙН ЧАДВАРГҮЙДЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨ ТООЦОХ СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Нэг.Тайлангийн бүтэц, үр нөлөө тооцох судалгааны үндсэн шалгуур үзүүлэлт

Хуулийн төслийн зүйл, заалтад тодорхой шалгуур үзүүлэлтийн дагуу дүн шинжилгээ хийх, үр нөлөөг тооцож, дотооддоо болон хүчин төгөлдөр үйлчилж байгаа бусад хууль тогтоомжтой зөрчилдөх, давхардал, хийдэлтэй эсэхийг тодорхойлж, арилгах, төслийн зүйл, заалтыг ойлгомжтой, хэрэгжих боломжтой байдлаар боловсруулах, улмаар төслийн чанарыг сайжруулахад энэхүү судалгааны ажлын гол зорилго оршино.

Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийн төслийн үр нөлөө тооцох судалгааг “Хуулийн төслийн үр нөлөө тооцох аргачлал”-д /цаашид аргачлал гэх/ дурдсаны дагуу дараах үе шаттайгаар хийлээ:

1. Шалгуур үзүүлэлтийг сонгох
2. Хуулийн төслөөс үр нөлөө тооцох хэсгээ тогтоох
3. Урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох
4. Үр дүнг үнэлэх, зөвлөмж өгөх.

1.1.Шалгуур үзүүлэлтийг сонгосон үндэслэл, хуулийн төслийн үр нөлөө тооцох хэсгийг тогтоосон байдал

Тус судалгааны ажлыг хийж гүйцэтгэхдээ хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан, аргачлалд дурдсан нийт 6 шалгуур үзүүлэлтээр судалгааг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

1. Зорилгод хүрэх байдал
2. Ойлгомжтой байдал
3. Практикт хэрэгжих боломж
4. Зардал
5. Харилцан уялдаа зэрэг болно.

Эдгээр шалгуур үзүүлэлтийг тухайлан сонгох болсон үндэслэл нь Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийн төслийн үндсэн зорилго, зохицуулах харилцааны онцлогтой холбоотой. Олон улсын бизнесийн эрх зүйн жишигт нийцсэн төлбөрийн чадваргүйдлийн цогц эрх зүйн зохицуулалтыг бий болгосноор өр төлбөр, санхүүгийн хүндрэлтэй байдалд орсон аж ахуй эрхлэгчийг дахин зохион байгуулж, бэрхшээлтэй байдлыг мэргэжилтнүүдийн тусламжтай даван туулахад туслалцах, улмаар олон арван ажилтнуудыг тогтмол ажлын байраар хангах, орлогын эх үүсвэрээ алдах, үргэлжилсэн хүндрэл бий болохоос урьдчилан сэргийлэх давуу талтай.

Хуулийн төсөл энэхүү үндсэн зорилгоо хангаж буй эсэхийг тодорхойлоход дээрх шалгуурууд шаардлагатай гэж үзэн сонгосон бөгөөд энэхүү зорилгыг анхаарч хуулийн төсөл нь төлбөрийн чадваргүйдлийн харилцааны дотоодын эрх зүйн системд шинэлэг зохицуулалтыг нэвтрүүлсэн байдал, хоёрдугаарт эдгээр нь өнөөгийн практикт хэрэгжих боломжтой эсэхэд дүн шинжилгээ хийх нь зүйтэй гэж үзлээ.

“Практикт хэрэгжих боломж”, “Зардал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг хэрэгжүүлэх боломж, хуулийн төслийг хэрэгжүүлэх субъектын санхүүгийн болон бусад чадавхи, хуулийн зохицуулалтыг хэрэгжүүлэх бодит боломж түүнд бий эсэх, хуулийн төсөл батлагдсанаар төсөвт нэмэгдэх зардлыг тооцон судлав.

“Харилцан уялдаа” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг бүхэлд нь Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, Иргэний хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомжуудтай харьцуулан судаллаа.

1.2 Урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох

Үр нөлөө тооцох тус судалгааг хийж гүйцэтгэхдээ “Аргачлал”-ын 4 дэх хэсэгт заасанчлан холбогдох шалгуур үзүүлэлтүүдэд тохирсон, зорилгод дүн шинжилгээ хийх, бүртгэл хөтлөх чиг үүрэг бүхий байгууллагуудтай тодорхой хугацаанд хамтран ажиллах замаар практикт турших, зардлын тооцоо хийх, хуулийн төслийг хүчин төгөлдөр хуулиудтай харьцуулан уялдаа холбоог шалгах гэсэн үндсэн шалгах хэрэгслүүдийг ашиглалаа.

1.3 Үр дүнг үнэлж, зөвлөмж өгөх

“Аргачлал”-д дурдсаны дагуу үр дүнг үнэлж, зөвлөмж өгөх үе шат нь дараах дарааллаар явагдана:

1. Шалгах хэрэгслийг хэрэглэсэн үр дүнг баримтжуулах;
2. Үнэлэх;
3. Зөвлөмж өгөх.

Зорилгод хүрсэн байдал, практикт хэрэгжих боломж, зардал, харилцан уялдаа холбоо гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд төсөлд дүн шинжилгээ хийхдээ гадны зөвлөхүүдийн бичсэн үзэл баримтлалын баримт бичиг¹, эрх бүхий байгууллагуудаас батлан гаргасан журам, стандарт, статистик тоон үзүүлэлтүүд, тайлан мэдээлэл, холбогдох хууль тогтоомж, тэдгээрийн албан ёсны болон албан бус тайлбарууд зэрэг олон нэмэлт материалыг ашигласан билээ. Эдгээр материал, баримт бичгийг үнэлэлт, зөвлөмжийн хэсгийн нэгдүгээр үе шатанд баримтжуулан дурдаж судалгааны ажилд хавсаргасан болно.

Шалгуур үзүүлэлтийн дагуу хийсэн тус судалгааны ажлын хэсэг бүр өөрийн санал, дүгнэлтийг агуулсан бөгөөд тэдгээрийн дагуу судалгааны ажлын үнэлэлт, зөвлөмжийн хэсгийн боловсрууллаа. Ингэхдээ өмнөх хэсгүүдэд дэлгэрэнгүй дурдагдсан, санаа давхардсан дүгнэлтийг дахин нуршилгүйгээр товч тодорхой, зарчмын болоод агуулгын ач холбогдолтой саналуудыг нэгтгэн багтаахыг зорилоо.

Хоёр. Шалгуур үзүүлэлтийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг тооцсон нь

2.1. Шалгуур үзүүлэлт: Зорилгод хүрэх байдал

Хуулийн төслийн үзэл баримтлал², хуулийн төслийн бүтэц, зохицуулах зүйлийн хүрээ, агуулгад дүн шинжилгээ хийж үзвэл төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийн төслийн үндсэн зорилго нь төлбөрийн чадваргүй хуулийн этгээдийн

¹ EBRD Frederique Dahan and Ronald Harmer, Improving secured transactions regime in Mongolia (Concept paper), 2006.10.

²Хууль зүй, дотоод хэргийн сайдын, 20... оны ... дүгээр сарын ... -ны өдөр баталсан Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийн төслийн үзэл баримтлал.

үйл ажиллагааг дахин сэргээх, төлбөрийн чадваргүйдлийг эрт үе шатанд илрүүлэн эвлэрлийн арга хэмжээг авч цаашид дампуурах, татан буугдах үр дагаварт хүргэхээс сэргийлэх, хэрэв энэ нь зайлшгүй тохиолдохоор байгаа бол хамгийн боломжит арга замаар үүрэг гүйцэтгүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах, шаардлагыг хангахад чиглэгдсэн байна.

Энэ зорилгын хүрээнд хэд хэдэн зарчмын шинжтэй зорилтуудыг дэвшүүлэн тавьсан бөгөөд эдгээрийн биелэлтийг хангах үүднээс төлбөрийн чадваргүйдлийн харилцааг нарийвчлан зохицуулсан эрх зүйн дэлгэрэнгүй орчинг бий болгосон бие даасан хууль батлах хувилбарыг сонгожээ.

Хуулийн төслийн зорилгод хүрэх байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд дараах хоёр дэд хэсгээр үнэлгээ өгөх нь зүйтэй гэж үзлээ. Үүнд:

- 2.1.1. Дотоодын хэрэгцээ шаардлагын дагуу тодорхойлсон зорилгод хүрсэн эсэх
- 2.1.2. Олон улсын бизнесийн эрх зүйн зохицуулалтын хүрээнд зорилгодоо хүрэх шалгуур үзүүлэлтийг хангасан эсэх болно.

2.1.1. Дотоодын хэрэгцээ, шаардлагын дагуу тодорхойлсон зорилгод хүрсэн байдал.

Өнөөдөр хүчин төгөлдөр үйлчилж буй Дампуурлын тухай хууль нь 1997 онд батлагдсан бөгөөд тус хууль өнөөдрийн хэрэгцээ шаардлагыг хангаж байгаа эсэх талаар 2018 онд Дампуурлын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийсэн байна. Энэхүү судалгааны ажлын хүрээнд “уг хууль нь өөрийн тавьсан зорилгодоо бүрэн дүүрэн хүрч чадаагүй бөгөөд хүлээн зөвшөөрөгдөх байдал хангалтгүй, практикт хэрэгжиж байгаа байдал бэрхшээлтэй, шийдвэрлэвэл зохих олон асуудлыг зохицуулалтгүй орхисон тул зорилгодоо хүрсэн гэж үзэхэд учир дутагдалтай”³ гэсэн ерөнхий дүгнэлт гарч, улмаар “Дампуурлын тухай Монгол Улсын хууль 1997 онд батлагдаж, тухайн цаг үеийн үүргээ гүйцэтгэж, хуулийн этгээдийн дампуурлын үндсэн харилцааг зохицуулж ирсэн боловч уг хуулийн зохицуулалтыг улам боловсронгуй болгох, өргөжин тэлж буй эдийн засаг, санхүүгийн харилцааны онцлогт тохирсон өргөн хүрээтэй цогц хэм хэмжээ бүхий хууль тогтоомж болгон шинэчлэн найруулах хэрэгцээ шаардлага бий болсон. Дампуурлын тухай хуулийг олон улсын чиг хандлагад нийцүүлэн шинэчилсэн боловсруулах шаардлагатай.” гэсэн саналыг дэвшүүлсэн байна.

Дээр дурдсан ерөнхий дүгнэлтийг задалсан байдлаас үзвэл Дампуурлын тухай хууль нь дараах байдлаар өнөөгийн Монгол Улсын хэрэгцээ шаардлагад эс нийцэж байгааг дурджээ. Үүнд:

1. Хууль нь нэхэмжлэгчийн эрх ашгийг хамгаалах, /хөрөнгийг нэхэмжлэгчдэд шударга хуваарилах/, өртэй этгээдийн эрхийг хамгаалах /төлбөрийн чадваргүй аж ахуйн нэгжийг дахин хөрөнгөжүүлэх замаар төлбөрийн чадварыг сайжруулан хэвийн үйл ажиллагааг үргэлжлүүлэх/ зорилго зохих түвшинд хангагдаагүй байна.
2. Дээрх зорилгоос шууд хамааралтайгаар нийт эдийн засаг, нийгмийн ашиг сонирхол /татварын орлогыг нэмэгдүүлэх, санхүү, зээлийн харилцааны ил тод байдал, хариуцлагыг дээшлүүлэх, ажилгүйдлийг нэмэгдүүлэхгүй байх, бизнес эрхлэлтийг дэмжих, нийт эдийн засгийг цэвэршүүлэх, хөгжүүлэхэд

³Дампуурлын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварын үнэлгээ, 2018 он, 24 дүгээр тал

чиглэгдэх/-ыг хангах зорилго мөн хангалттай биелээгүй гэсэн дүгнэлт гарч байна.

3. Хуулийн зохицуулалт бодит байдал зөрүүтэй, хэрэгжүүлэхэд хүндрэл үүссэн, тэдгээр нь сөрөг үр дагавар үүсгэсэн зэрэг нь практикт нийцэж байгаа байдал тааруу.
4. Хууль нь нийгмийн харилцааны өөрчлөлт, хөгжлөөс хоцорсон, дотоодын судалгааны байгууллагууд болон олон улсын байгууллагуудын зүгээс шүүмжлэлтэй, иргэд, хуулийн этгээд хэрэгжүүлэхээс зайлсхийдэг зэрэг нь нийгэм хүлээн зөвшөөрч, сайн дураар сахин биелүүлэхгүй байна гэж үзэх үндэслэл болж байна.

Энэхүү дүгнэлтийг дампуурлын эрх зүйн үүднээс авч үзвэл олон улсын жишигт нийцсэн, төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаанд оролцогчдод тодорхой, ойлгомжтой, өөрийн байр суурь, үр дагаврыг таамаглан мэдэх боломжтой, үүрэг гүйцэтгүүлэгчдийн эрхийг үр дүнтэй, тэгш хангах зарчмыг хангасан нийгмийн бодлого, улс орны эдийн засгийн тогтвортой хөгжлийг дэмжсэн хуулийн төсөл бий болгохыг зорьсон гэж үзэхээр байна. nn

Төлбөрийн чадваргүйдлийн цогц эрх зүйн зохицуулалтыг бий болгохыг зорьсон дотоодын хэрэгцээ шаардлага нь өнөөгийн олон улсын жишигт төлбөрийн чадваргүйдлийн харилцааны хэм хэмжээг боловсронгуй болгох талаар баримталдаг чиг хандлагатай нийцэж байх тул дараагийн хэсэгт тайлбарлах зорилт тус бүрээр дотоодын хэрэгцээ шаардлага хуулийн төслөөр хэрхэн хангагдсан талаар илүү дэлгэрэнгүй ойлгох боломжтой байна.

Түүнчлэн дээрх хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээнд тусгагдаагүй боловч 1997 онд батлагдсан Дампуурлын тухай хуулийн боловсронгуй бус байдал Монгол Улсын шүүхийн практикт ихээхэн хүндрэлтэй байдлыг бий болгож буй явдал энэ хуулийг сайжруулах, цогц шийдэл шаардах нэгэн үндэслэл шалтгаан болж байна.

Худалдааны эрх зүй хангалттай хөгжөөгүй нөхцөл байдал нь энэ төрлийн хэрэг маргааныг хянан шийдвэрлэх шүүхийн практикт тод илэрдэг бөгөөд дампуурлын хэргийг хянан шийдвэрлэхэд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх хуулийг хэрэглэж байгаа нь ихээхэн бэрхшээлтэй байдлыг дагуулж байна. Монгол Улсын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд дампуурлын хэргийг хянан шийдвэрлэх, зарчим, зорилгод нийцсэн хэм хэмжээ байхгүй гэж дүгнэхэд төдийлөн буруутахгүйн зэрэгцээ Дампуурлын хууль ч нэгэн адил хэргийг шүүхэд хянан шийдвэрлэхэд чиглэгдсэн хэм хэмжээг хангалттай төвшинд агуулаагүй юм.

Энэ нөхцөл байдал Төлбөрийн чадваргүйдлийн хуулийг шинээр томоохон цар хүрээтэй харилцааг зохицуулах бодит шаардлагыг нөхцөлдүүлж байна. Иймд хуулийн төслийн нэгэн зорилго нь дампуурлын эрх зүйн энэ дутагдалтай байдлыг засаж, иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль тогтоомжоор зохицуулаагүй, зохицуулах боломжгүй харилцаанд тохирох хэм хэмжээг бүтээх явдал байв.

Энэ зорилгыг хуулийн төсөл харьцангуй сайн биелүүлсэн байх дампуурлын харилцааны материаллаг ба процессын эрх зүйн олон талт шинж байдлаас шалтгаалан орхигдуулсан, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуультай зөрчилдсөн зохицуулалт байсаар байна. Энэ талаар тус судалгааны ажлын харилцан уялдаа хэсэгт дэлгэрэнгүй авч үзсэн болно.

2.1.2. Олон улсын бизнесийн эрх зүйн зохицуулалтын хүрээнд зорилгодоо хүрсэн байдал

Аливаа улс орон үр дүнтэй төлбөрийн чадваргүйдлийн эрх зүйн хэм хэмжээг бүтээхийн тулд дараах зорилгыг хангасан байвал зохих талаар ЮНСИТРАЛ-ийн төлбөрийн чадваргүйдлийн эрх зүйн хэм хэмжээний гарын авлагад дурдсан байна.

Үүнд:

1. Эдийн засгийн тогтвортой байдал, хөгжлийг дэмжихийн тулд зах зээлд тодорхой байдал бий болгох
2. Хөрөнгийн үнэ цэнийг нэмэгдүүлэх
3. Дампуурсанд тооцож татан буулгах ажиллагаа болон дахин зохион байгуулах ажиллагааны тэнцвэрт байдлыг хангах
4. Адил төстэй нөхцөлд байгаа үүрэг гүйцэтгүүлэгчдтэй тэгш харилцах
5. Төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааны явцад үр дүнтэй, ялгаварлалгүй шийдвэрийг цаг алдалгүй гаргах
6. Хуваарилагдах хөрөнгийг үүрэг гүйцэтгүүлэгчдэд тэнцүү хуваарилах
7. Мэдээлэл олж авах, үнэлэх, тараах боломжтой, ойлгомжтой, ил тод, үр дагаврыг таамаглах боломжтой зохицуулалтыг бий болгох
8. Нэхэмжлэлийн шаардлагын дарааллын зарчим тодорхой байх, үүрэг гүйцэтгүүлэгчдийн эрхийн хүрээг зөв тодорхойлох
9. Хил дамнасан дампуурлын харилцааг зохицуулсан хэм хэмжээг бий болгох⁴

Нэгдүгээр зорилго: Эдийн засгийн тогтвортой байдал, хөгжлийг дэмжихийн тулд зах зээлд тодорхой байдал бий болгох

Эхний зорилго буюу зах зээлийн тодорхой байдлыг төлбөрийн чадваргүйдлийн тухай хууль тогтоомж бүтээх ёстой гэсэн ойлголтын ард эдийн засгийн тогтвортой байдал, өсөлт хөгжил яригдана. Үүний тулд энэ чиглэлийн хууль тогтоомж болон энэ салбарын институтууд нь аж ахуй эрхлэгчдийг дахин санхүүжүүлэх, эсхүл аль болох алдагдал багатай хаагдах, уналтад орсон бизнесийн нэг салбараас нөгөө салбарт хөрөнгө шилжих үр дүнтэй механизмыг бий болгох, гарааны бизнесийг дэмжиж санхүүжүүлэх, бизнесийг дахин зохион байгуулах, олон улсын болон дотоодын түвшинд зээлийн эрсдлийн дүгнэлтийг чухалчлахад чиглэгдсэн байвал зохино.

Дээр дурдсан бүхий л зорилгууд нь бүхэлдээ эдийн засгийн тогтвортой байдал, өсөлт хөгжилтийг дэмжихэд чиглэгдсэн тул эхний зорилго амжилттай хэрэгжих эсэх нь дараа дараагийн зорилго хэрхэн хангагдсанаас ихээхэн хамаарна.

Хуулийн төсөл нь дээрх зорилгын хүрээнд өнөөдрийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа Дампуурлын тухай хуультай харьцуулбал харьцангуй дэвшилттэй болсон бөгөөд үйл ажиллагаа нь зогсоод олон жил болж байгаа, огт хөрөнгөгүй компаниудыг дампууруулах ажиллагаа давамгайлсан өнөөдрийн шүүхийн практикаас илүү үр дүнтэй механизмыг санал болгосон байна. Тухайлбал, төлбөрийн чадваргүйд тооцох үндэслэлийг илүү тодорхой болгож, энэ ажиллагааны зардлыг нөхөх урьдчилсан төлбөртэй байхыг хариуцагч, эсхүл нэхэмжлэгчээс шаардаж байгаа нь төлбөрийн чадваргүйд тооцох ажиллагаа жинхэнэ утгаараа хэрэгжих, улмаар дахин санхүүжилт шаардлагатай болж, багахан хичээсний үр дүнд санхүүжилтээ сэргээж, эргэж хөл дээрээ босохыг хүссэн компаниудад илүүтэй

⁴ UNCITRAL Legislative guide on Insolvency law

чиглэснээрээ хуулийн төсөлд суусан дахин зохион байгуулалтын ажиллагаа явагдаж эхлэх бодит боломжийг бүрдүүлсэн байна. Ингэснээрээ зах зээлийн тодорхой байдлыг хангах зорилгод 1997 онд баталсан Дампуурлын тухай хуультай харьцуулбал илүүтэй дөхөж очсон гэж дүгнэхээр байна.

Хоёр дахь зорилго буюу хөрөнгийн үнэ цэнийг нэмэгдүүлэх

Төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааны оролцогчид хөрөнгийн үнэ цэнийг нэмэгдүүлэх сонирхол маш өндөр байх нь ойлгомжтой бөгөөд ингэснээр төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааны явцад бий болох аливаа дарамтыг багасгаж, үүрэг гүйцэтгүүлэгчдийн ашиг сонирхлыг илүүтэй хангах боломж бүрдэх юм.

Энэ зорилгод хүрэхийн тулд төлбөрийн чадваргүйдлийн харилцаанд оролцогчдын хооронд эрсдлийг тэнцвэртэй хуваарилах шарадлагатай. Жишээ нь төлбөрийн чадваргүй болсон үүрэг гүйцэтгэгчийн өмнө нь байгуулсан хэлцлүүд сэжигтэй байвал түүнийг хүчин төгөлдөр бус болгох механизмыг ашигласнаар үүрэг гүйцэтгүүлэгчид адил тэгш хандах, ялгаварлуулахгүй байх нөхцөл бүрдэж байгаа юм. Ийм ажиллагааны үр дүнд хуваарилагдах хөрөнгийн хэмжээ ч нэмэгдэнэ.

Хүчин төгөлдөр бус байж болох хэлцэл нь үүрэг гүйцэтгэгчийн гэрээний харилцаанд ч сөрөг нөлөөтэй ба хөрөнгө оруулалтын аливаа шийдвэрт тодорхойгүй байдлыг бий болгож, төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааны зорилгуудын хооронд гацаа үүсгэх шалтгаан болно.

Үүний зэрэгцээ хурдан хугацаанд хэрэгжих боломжтой татан буулгалтын ажиллагаа болон урт хугацаанд хэрэгжих шинжтэй ч шинэ хөрөнгө татах боломж олгодог дахин зохион байгуулах ажиллагааны тэнцвэрт байдлыг хангах нь хөрөнгийн үнэ цэнийг нэмэгдүүлэх зорилгын хүрээнд анхаарч үзвэл зохилтой ойлголтууд юм.

Эдгээр чиглэлээр хуулийн төсөл олон талаар дэвшилттэй зохицуулалтыг бий болгосон байна. Тухайлбал, хэлцлийг хүчин төгөлдөр бус болгох нэхэмжлэлийг хянан шийдвэрлэх процесс ажиллагааг илүү тодорхой болгож, нарийвчлан оруулсны зэрэгцээ дахин зохион байгуулах ажиллагааны явцад шинэ санхүүжилт хийсэн бол тэдгээртэй холбогдох шаардлагад төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааны туршид хүү тооцох эрх зэргийг олгосон байна. Харин дахин санхүүжилт хийж байгаа үед нэхэмжлэлийн шаардлага хангах дараалалд энэ төрлийн үүрэг гүйцэтгүүлэгчид илүү давуу байр суурь олгосон зохицуулалт төсөлд үгүйлэгдэж байна.

Гуравдугаар зорилго: Дампуурсанд тооцож татан буулгах ажиллагаа болон дахин зохион байгуулах ажиллагааны тэнцвэрт байдлыг хангах

Хөрөнгийн үнэ цэнийг нэмэгдүүлэх зорилго нь татан буулгах ба дахин зохион байгуулах ажлын тэнцвэрт байдлыг хангах зорилготой нягт холбоотой. Төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааны хууль нь татан буулгах ажиллагааны богино хугацаанд хэрэгжих давуу тал нь урт хугацаанд хэрэгжиж хөрөнгийг нэмэгдүүлдэг дахин зохион байгуулах ажиллагааны давуу талаас ч дутахгүй ач холбогдолтой. Эдгээр ажиллагааны тэнцвэрт байдлыг хангана гэдэгт ажлын байрыг хамгаалах, интерпренер бүлгийг дэмжих зэрэг нийгмийн шинжтэй үзүүлэлтээр хэмжигдэх нь бий.

Дахин зохион байгуулах ажиллагааны үр дүнд үүрэг гүйцэтгүүлэгчид татан буулгах ажиллагааны үед хүлээн авдгаасаа сайн дураараа бага төлбөр хүлээн авдаг хэдий ч үүрэг гүйцэтгэгчийн нийгмийн өмнө болон үүрэг гүйцэтгүүлэгчдийн өмнө хүлээсэн үнэ цэнийг нэмэгдүүлж байдгаараа анхаарал татдаг тул энэ ажиллагаа нь татан буулгах ажиллагаатай нэгэн адил чухалчлагдах учиртай.

Ерөнхийдөө аливаа бизнесийг задлан салгаж үгүй хийхээс илүүтэй үндсэн бүрдэл хэсгүүдийг хамтад нь байлгаснаар илүү үнэ цэнэтэй байна гэсэн эдийн засгийн суурь ойлголт ч энэ тохиолдолд нэгэн адил үйлчлэх юм.

Иймд төсөл нь дээрх хоёр үндсэн ажиллагааны аль нэгд илүү ач холбогдол өгөлгүй тэнцвэрт байдлыг нь хангасан хэм хэмжээг бүтээхийн зэрэгцээ нэг ажиллагаанаас нөгөөд шилжих боломжийг хангалтай анхаарч уян хатан зохицуулах нь зүйтэй.

Төсөл энэ зорилгын хүрээнд шаардлагатай элементүүдийг хангалттай суулгасан байна. Тодруулбал, дахин зохион байгуулах төлөвлөгөөг боловсруулах, батлах, хэрэгжих, хяналт тавих, амжилттай ба амжилтгүй дуусгавар болох үйл явцыг нарийвчлан зохицуулж ямар тохиолдолд татан буулгах ажиллагаанд шилжих ямар тохиолдолд төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаа бүрэн туусгавар болсон гэж үзэх тэдгээрийн үр дагавар зэргийг нэмж оруулснаараа одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Дампуурлын хуулиас ихээхэн дэвшилттэй болжээ.

Дөрөвдүгээр зорилго:Төстэй байр сууринд байгаа үүрэг гүйцэтгүүлэгчдэд тэгш хандах

Дампуурлын ажиллагааны тэгш, ялгаварлалгүй хандах гэсэн зарчим бүлгээр нэхэмжлэл гаргах буюу class action гэх ойлголтод суурилсан бөгөөд энэ тохиолдолд адил бүлэгт байгаа субъектүүд адил тэгш харилцааг шаардах эрхтэй. Адил төстэй нөхцөл байдалд байгаа үүрэг гүйцэтгүүлэгчдэд тэгш хандах явдал төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааны олон үе шатанд, тодруулбал, аливаа ажиллагааг түдгэлзүүлэх, нэхэмжлэлийн шаардлагыг ангилах, дахин зохион байгуулах төлөвлөгөөг батлах, хуваарилалтын ажиллагаанд санал өгөх зэрэгт илрэлээ олдог, өндөр ач холбогдолтой ойлголт.

Энэ зорилгын гол санаа бүх нэхэмжлэгчид адил тэгш харилцаа шаардах эрхтэй гэсэн утга бус, харин тухайн үүрэг гүйцэтгэгчтэй харилцаж байгаа тухайн ижил төрлийн бүлэг дотор адил тэгш харилцаа шаардах эрхтэйг илэрхийлсэн ойлголт юм. Гэвч энэ харилцаанд татварын байгууллага, нийгмийн бодлогод хамаарах шарадлагатай холбоотой асуудлууд илүү онцгой байдлаар дараалалд орох тохиолдол байдгийг дурдах нь зүйтэй.

Төсөлд үүрэг гүйцэтгүүлэгчидтэй тэгш харилцах асуудлаар харьцангуй нарийвчилсан зохицуулалт нэмэгдсэн боловч татварын харилцаа, нийгмийн бодлоготой холбоотой онцлог зохицуулалт хараахан тусгагдаагүй байна.

Хуулийн төсөлд үүрэг гүйцэтгүүлэгчдийн дахин зохион байгуулах төлөвлөгөөнд санал өгөх процессыг үүрэг гүйцэтгүүлэгчдийн бусад хуралд саналын эрхээс ялгамжтай зохицуулахыг зорьсон байх боловч төслийн зарим заалтууд өөр хоорондоо зөрчилтэй, дутуу дулимаг болжээ. Төсөлд нэхэмжлэгчдийн саналын

эрхийг илүү бодитой үнэн зөв тогтоох механизмыг бий болгож, баталгаажуулах хурлын үе шатыг нэмсэн нь өмнөх төслөөс зарчмын давуу тал болжээ.

Тавдугаар зорилго: Төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааны явцад үр дүнтэй, ялгаварлалгүй шийдвэрийг цаг алдалгүй гаргах

Төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаа дэс дараалалтай, хурдан, үр дүнтэй, үүрэг гүйцэтгэгчийн бизнесд саад болохгүй, процесс ажиллагааны зардлыг шаардлагагүй өсгөхгүй байдлаар явагдах ёстой. Цаг хугацаандаа, үр дүнтэй явагдсан аливаа ажиллагаа нь эргээд хуваарилагдах хөрөнгийг нэмэгдүүлэх, талуудад ялгаварлалгүй тэгш хандах нөхцлийг бүрдүүлэх юм. Мэдээжээр бүхий л процесс ажиллагааны туршид цаг алдахгүй байх, үр ашигтай байх зарчмыг баримтлах нь чухал ч шийдвэр гаргахдаа уян хатан байх нөхцлийг ямагт анхаарах нь чухал гэж үздэг. Ингэснээр амьдрах чадваргүй нь тодорхой болсон үр ашиггүй бизнесийг хурдан хугацаанд татан буулгаж, харин эргэн төлжих боломжтой, үр дүнтэй байж болох бизнесийг дахин зохион байгуулахыг эрмэлзэх нь төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийн төслийн чухал зорилгын нэг байх ёстой.

Хуваарилагдах хөрөнгийг таних, цуглуулах, хамгаалах, хадгалах, хөрөнгийг нөхөн төлүүлэх арга, өр төлбөртэй холбоотой эрх, үүрэг гүйцэтгэгчийн хариуцлагын талаар тодорхой бөгөөд объектив шалгуурыг хуульчилсан төлбөрийн чадваргүйдлийн тухай хууль нь үүрэг гүйцэтгэгчийн санхүүгийн бэрхшээлийг даван туулах аливаа шийдлийг цаг алдалгүй зөв гаргахад ихээхэн тус дэм болно.

Энэ асуудлаар төсөл зарим талаар нилээд учир дутагдалтай болжээ. Өөрөөр хэлбэл хэрэг гүйцэтгэгчид тавигдах шалгуур, түүнийг томилох чөлөөлөх шалгуур нь харьцангуй тодорхой байх хэдий ч түүний эрх, үүргээ хэрэгжүүлэх процесс, энэ процесст шүүх, нэхэмжлэгчдийн хурал, нэхэмжлэгчдийн зөвлөл, хариуцагч, түүний хөрөнгөтэй харьцах харилцаанд эдлэх эрх үүргийн байдал тодорхой бус, өөр хоорондоо ихээхэн зөрчилтэй болсон байна. Тухайлбал, нэхэмжлэлийн шаардлагыг хангахаар хувиарлалтын ажиллагааг эхлүүлэх ба хөрөнгийг хамгаалах, худалдан борлуулах ажиллагааг бүхэлд нь сайтар анхаарч зөрчилтэй байдлыг сайжруулах алдааг нь засах нь зүйтэй байна. Энэ чиглэлээр төсөл тавьсан зорилгодоо хангалттай хүрсэн гэж дүгнэхэд хүндэрэлтэй байна.

Зургаадугаар зорилго:Хуваарилагдах хөрөнгийг үүрэг гүйцэтгүүлэгчдэд тэнцүү хуваарилах

Төлбөрийн чадваргүйдлийн тухай хууль нь аль нэг үүрэг гүйцэтгүүлэгчийн шаардлагыг дангаар нь хамтарсан бус байдлаар хангах зохицуулалтаас аль болох зайлсхийвэл зохино. Хэрэв ингэвэл энэ нь хуваарилагдах хөрөнгийн үнэ цэнийг бууруулж, дахин зохион байгуулах, үүрэг гүйцэтгэгчийн бизнесийг бүхэлд нь худалдах боломжийг алдагдуулахад хүргэнэ.

Үүрэг гүйцэтгүүлэгчийн шаардлагыг дангаар нь хангахаас зайлсхийх боломжийг үүрэг гүйцэтгэгчид олгосноор тэрээр санхүүгийн бүхий л боломжоо дахин сайтар нэгтгэн нягтлах, нөхцөл байдлаа зохих ёсоор үнэлж дүгнэх, хувиарлагдах хөрөнгийн үнэ цэнийг нэмэгдүүлэх, улмаар үүрэг гүйцэтгүүлэгчдийн шаардлагыг тэгш хангах боломжийг олгох юм. Зарим орнуудад ганцаарчлан шаардлагаа хангах ажиллагааг түдгэлзүүлэх механизм барьцаат нэхэмжлэгчид үйлчлэхгүй байхаар заасан байж ч болно.

Төсөлд үүрэг гүйцэтгүүлэгчид шаардлагаа дангаараа хангаалахгүй байхаар хэд хэдэн газарт тодорхой тусгасан байхын зэрэгцээ барьцаат нэхэмжлэгчдийн барьцааны зүйл хуваарилагдах хөрөнгөд хамаарахгүй байхаар зохицуулснаараа шаардлагаа хангах ажиллагааг түдгэлзүүлэх механизм барьцаат нэхэмжлэгчид үйлчлэхгүй мэт ойлголт төрүүлж байна.

Гэвч төслийн нарийвчилсан зохицуулалтаас үзвэл хэрэг гүйцэтгэгч барьцааны зүйлийг төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаа эхлүүлснээс хойш 6 сарын хугацаанд худалдан борлуулахгүй байхаар заасан нь энэ хугацаанд барьцаат нэхэмжлэгчийн шаардлага хангагдахгүй байх нөхцлийг бүрдүүлж байна.

Түүнчлэн өмнө дурдсанчлан төслийн хуваарилалтын ажиллагааны механизм бүхэлдээ учир дутагдалтай ойлгомж муутай болсон байна.

Долоодугаар зорилго: Мэдээлэл олж авах, үнэлэх, тараах боломжтой, ойлгомжтой, ил тод, үр дагаврыг таамаглах боломжтой зохицуулалтыг бий болгох

Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийн зохицуулалт, илэрхий, таамаглах боломжтой байх ёстой. Ингэснээр зээлдүүлэгч, үүрэг гүйцэтгүүлэгч нар дампуурлын ажиллагаа хэрхэн явагддаг талаар ойлголттой болох, төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааны явцад тэдгээрийн хооронд эрсдлийг хэрхэн хувиарлах, түүний байр суурь ямар байдалтай байхыг таамаглах бүрэн боломжтой болох юм. Энэ нь бизнесийн харилцаанд тогтвортой байдлыг ханаж, хамгийн бага эрсдэлтэй хөрөнгө оруулалтыг хийх нөхцлийг бүрдүүлэх, дэмжих эерэг үр дагавартай.

Хуулийн төсөл ойлгомжтой байснаар нэхэмжлэгч нар өөрсдийн шаардлага хангагдах дарааллыг мэдэх, эрхээ хязгаарлуулах нөхцөл бололцоог урьдчилан таамаглах, аливаа маргаанаас урьдчилан сэргийлэх ач холбогдолтой. Тодорхой бус, ойлгомжгүй дампуурлын хууль нь дампуурлын харилцаанд оролцогчдын хувьд таагүй үр дагаврыг авчраад зогсохгүй төлбөрийн чадваргүйдэл эхлэхээс өмнөх хөрөнгө оруулалтын шийдэлд ч сөрөг нөлөө үзүүлэх юм.

Төлбөрийн чадваргүйдлийн тухай хууль тогтоомжийн тодорхой байдал дан ганц тухайн төслөөс ч хамаарахгүй, бусад хууль тогтоомжууд болох Хөдөлмөрийн тухай хууль, гэрээний үүргийн харилцаа, үүрэг дуусгавар болох, тооцоо нийлэх, үүргийг тооцож дуусгавар болгохтой холбоотой харилцааг зохицуулсан хууль тогтоомж, гадаад худалдааны харилцаанд хамааралтай бусад хууль тогтоомжууд, тэрч байтугай гэр бүлийн хууль тогтоомжийн тодорхой байдалтай ч хамааралтай.

Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийн төсөл энэ зорилгод хүрсэн эсэх асуудал энэхүү судалгааны ажлын бие даасан шалгуур үзүүлэлтийн хэмжээнд үнэлэгдэнэ. Тус хуулийн төслийг дагаж нилээдгүй олон хуульд нэмэлт өөрчлөлт орж байгаагийн дотор дээр дурдагдсан хэд хэдэн хууль хамрагдаж байна. Гэвч хангалттай тодорхой хэмжээнд хөндөгдсөн гэж дүгнэх боломжгүй байна. Тухайлбал, хуулийн төсөл нь хөдөлмөрийн харилцааны талаарх зохицуулалтыг бүхэлд нь энгийн нэхэмжлэлийн хүрээнд шийдсэн тул энэ талаар тусгайлсан зохицуулалт Хөдөлмөрийн тухай хуульд хараахан бий болоогүй байна.

Хууль нь үүрэг гүйцэтгэгч өөрийн нөхцөл байдлаа бүрэн дүүрэн ойлгож, дүгнэлт өгөх боломжийг олгохуйц ойлгомжтой, тодорхой байх учиртай. Ингэснээр тэрээр өөрийн байр суурийн талаар үнэн зөв дүгнэлт өгч, хариуцлага хүлээж болохыг ойлгож, зөв шийдвэр гаргахад нөлөөлөх юм. Мэдээлэл ил тод байх нь төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааг удирдах, хянах эрх бүхий этгээдүүд болох шүүх, хэрэг гүйцэтгэгч, нэхэмжлэгч нь үүрэг гүйцэтгэгчийн санхүүгийн байдлыг цаг алдалгүй үнэлэх, зөв зохистой шийдвэр гаргахад туслах юм.

Наймдугаар зорилго: Нэхэмжлэлийн шаардлагын дараалал, үүрэг гүйцэтгүүлэгчдийн эрх тодорхой байх

Нэгэнт үүссэн шаардлагын дарааллын эрх, дахин санхүүжилтийн үед үүссэн шаардлагын дарааллын эрхийн тодорхой байдал төлбөрийн чадваргүйдлийн тухай хуульд чухал ойлголтуудын нэг мөн. Өөрсдийн дарааллын эрхийг зөв ойлгож мэдсэнээр ирээдүйд шийдвэрээ зөв гаргах, эрсдлээ хувиарлахад ихээхэн ач холбогдолтой. Хамгийн боломжит байдлаар эдгээр дарааллыг тогтоохдоо нийгмийн, улс төрийн хүчин зүйлсийг бус арилжааны буюу бизнесийн мэргэжлийн хүчин зүйлийг анхаарах шаардлагатай.

Энэ асуудлаар төсөл зарчмын хувьд харьцангуй зорилгодоо хүрсэн байх боловч шинэ санхүүжилтийн эрх буюу хожим үүссэн шаардлагын дарааллын эрхийг нэхэмжлэгчдийн дараалал хэсэгт орхигдуулсан нь алдаа болжээ.

Есдүгээр зорилго: Хил дамнасан дампуурлын харилцааг зохицуулсан хэм хэмжээг бий болгох

Улс орнуудын хоорондын хамтын ажиллагааг дэмжих, гадаад улс оронд үүссэн дампуурлын ажиллагаанд туслалцаа үзүүлэхийн тулд төлбөрийн чадваргүйдлийн тухай хууль нь хил дамнасан дампуурлын ажиллагааг, түүний дотор өөрийн оронд үүссэн процесс ажиллагааг гадаадад хүлээн зөвшөөрүүлэх, гадаадын шүүхийн процесс ажиллагааг дотооддоо хүлээн зөвшөөрөх зохицуулалтыг бий болгох нь зүйтэй.

Төсөлд энэ талаар аливаа зохицуулалт тусгагдаагүй байна.

2.2. Шалгуур үзүүлэлт: Ойлгомжтой байдал

Уг хуулийн төсөл нь хуулийг хэрэгжүүлэх, хэрэглэх субъектуудийн хувьд ойлгомжтой, тодорхой томъёологдон боловсруулагдсан эсэхийг тодруулах зорилгоор бүхэлд нь дүн шинжилгээ хийсэн болно. Энэ судалгааны хүрээнд ойлгомжгүй, хэрэглэхэд хүндрэлтэй гэж үзэж болохоор зүйл, заалт байгааг дараахь байдлаар хүснэгтлэн харуулж, тодорхой санал дэвшүүллээ.

№	Ойлгомжгүй байгаа хуулийн төслийн зүйл, заалт	Тайлбар	Санал
1.	4.1.4 “хүсэлт гаргагч” гэж төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаа эхлүүлэхээр шүүхэд хүсэлт гаргасан этгээдийг, 5.1 “...хариуцагч, нэхэмжлэгч, хэрэг гүйцэтгэгч нь төлбөрийн	5.1-д заасан хэргийн оролцогчид 4.1.4-т заасан хүсэлт гаргагч хамаарч байгаа эсэх нь ойлгомжгүй байна.	Иймд 5.1-ийн томъёололд 4.1.4-т заасан хүсэлт гаргагчийг нэмж заах нь зүйтэй байна.

*Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийн төслийн
үр нөлөө тооцох судалгааны тайлан*

	чадваргүйдлийн хэргийн оролцогч болно” гэжээ.		
2.	8.2. “Хуульд өөрөөр заагаагүй бол төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааны зардлын зохих хэсгийг урьдчилан төлөх үүрэгтэй”. 8.4. “Хариуцагч төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааны зардлыг төлөх төлбөрийн чадваргүй бол хүсэлт гаргагч, нэхэмжлэгч, эсхүл гуравдагч этгээд төлж болно гэжээ”.	Энэ заалтуудад байгаа “урьдчилсан төлбөр”-ийг хаана, хэнд төлөх нь тодорхойгүй байна. Мөн “гуравдагч этгээд” гэдэгт хэн байх вэ гэдэг тодорхойгүй байна, төслөөс хэргийн оролцогч биш хэн ч байж болохоор ойлгогдож байна.	Тиймээс 8.2-т уг урьдчилсан төлбөрийг хаана, хэнд төлөхийг тодорхой заах. Түүнчлэн гуравдагч этгээд гэдгийг тодорхой, ойлгомжтой заах.
3.	9.2-т “Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 7.1-д заасан хэмжээгээр улсын тэмдэгтийн хураамж төлнө” гэжээ.	Энэ заалтын “Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 7.1-д заасан хэмжээ” гэдэг нь ерөнхий тусгагдсан, уг хэсэгт байгаа 4 үндэслэлийн аль хэсгийг нь хамааруулж байгаа ойлгомжгүй.	Тиймээс Улсын тэмдэгтийн ёийн тухай хуулийн 7.1 дэх хэсгийн заалтуудыг нарийвчилан тусгах.
4.	9.4 “... нэхэмжлэлийн шаардлага маргаантай бол... маргааныг ИХШХШТХ-ийн дагуу шийднэ”. 25.2-т “энэ хуулийн 25.1-д заасан шүүх хуралдааныг ИХШХШТХ-д заасан журмын дагуу явуулна”, 40.3-т “нэхэмжлэгч нь энэ хуулийн 40.1-д заасан маргааныг ИХШХШТХ-д заасан журмаар шийдвэрлүүлэх эрхтэй”. 72.1-д “энэ хуулийн 71.1-д заасан хэлцлийн талаарх нэхэмжлэлийг хэрэг гүйцэтгэгчийн хүсэлтээр Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журмын дагуу шийдвэрлэнэ”. 72.5-д “хэлцлийг хүчин төгөлдөр бус гэж үзсэн шүүгчийн захирамжийг эс зөвшөөрсөн этгээд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны журмаар захирамжийг гардаж авснаас хойш 20 хоногийн дотор харьяалах шүүхэд	Эдгээр заалтуудын “ИХШХШТХ-ийн дагуу шийднэ”, “ИХШХШТХ-д заасан журмаар”, “ердийн журмаар шийдвэрлүүлнэ” гэсэн нь ойлгомжгүй байна. ИХШХШТХ-ийн дагуу аль шүүх харьяалан шийдвэрлэх, төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааг эхлүүлсэн шүүх эсхүл хариуцагчийн хаягийн дагуу өөр шүүх ИХШХШТХ-д заасан журмын дагуу шийдвэрлэх эсэх нь ойлгомжгүй байх бөгөөд уг заалтуудаас үзвэл төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаа, ИХШХША нь зэрэгцэж явагдахаар байна. Мөн хуулийн 3.4-т энэ хуулиар зохицуулагдаагүй харилцааг ИХШХШТХ-иар зохицуулахаар заажээ. Гэтэл уг заалтуудад байгаа ажиллагаануудыг ИХШХШТХ-иар, ИХШХША-ны журмыг	Иймд төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааны хэргийг шийдвэрлэх явцад маргаантай нэхэмжлэлийг шийдвэрлэх шүүхийн харьяаллыг тодорхой заах. Төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааны хэргийг хянан шийдвэрлэх шүүх хуралдааны дэг, журмыг хуулийн төсөлд тусгайлан зохицуулж заах.

*Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийн төслийн
үр нөлөө тооцох судалгааны тайлан*

	нэхэмжлэл гарган ердийн журмаар шийдвэрлүүлнэ” гэжээ.	хэрэглэхээр заасан байгаа нь хуулийн төслийн 3.4-т заасантай зөрчилтэй мэт харагдаж байна.	
5.	11.1-д “...шүүгчийн захирамжид холбогдох этгээд гомдол гаргах эрхтэй” гэжээ...	“холбогдох этгээд” гэдэгт хэн хамаарах вэ гэдэг нь ойлгомжгүй байна.	Холбогдох этгээд гэдгийг хэргийн оролцогч гэж өөрчилж найруулах
6.	14.1-д “...шаардах эрх бүхий үүрэг гүйцэтгүүлэгч, ...хүсэлтийг шүүхэд гаргах эрхтэй”, 14.2-т “...үүрэг гүйцэтгэгч,ажиллагаа эхлүүлэх хүсэлт гаргах үүрэгтэй”.	Үүрэг гүйцэтгүүлэгч гэдэг нь 4.1.2-т заасан нэхэмжлэгч, үүрэг гүйцэтгэгч гэдэг нь 4.1.3-т заасан хариуцагч, эсхүл 4.1.4-т заасан хүсэлт гаргагч, 5.1-д заасан хэргийн оролцогч мөн эсэх, хоорондоо ямар хамааралтай эсхүл ялгаатай болох нь ойлгомжгүй байна. Мөн энэ зохицуулалтад хуулийн төслийн 15.1, 16.1-д заасан үүрэг гүйцэтгүүлэгч, үүрэг гүйцэтгэгч нь хамаарч байгаа эсэх нь тодорхойгүй байна.	Иймд нэр томъёоны хэсэгт үүрэг гүйцэтгүүлэгч, үүрэг гүйцэтгэгч гэдгийг тодорхойлох Өөрөөр хэлбэл төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааны хэрэг хянан шийдвэрлэх аль үе шатанд үүрэг гүйцэтгэгч, үүрэг гүйцэтгүүлэгч гэж нэрлэх, аль үе шатанд нь нэхэмжлэгч, хариуцагч, хүсэлт гаргагч, хэргийн оролцогч гэж нэрлэхийг тодорхой цэгцтэй, нэг мөр ойлгомжтой заах.
7.	16.5 “энэ хуулийн 16.4-т заасан хохирлын хэмжээ үүрэг гүйцэтгэгч хүсэлт гаргаагүйн улмаас учирсан хохирлын хэмжээгээр хязгаарлагдана” гэжээ.	Бүхэлдээ ойлгомжгүй заалт байна	Уг заалтыг өөрчлөн найруулах шаардлагатай.
8.	18.1.4-т “...эсхүл талууд эвлэрсэн гэжээ”...	Энэ хэсэг ойлгомжгүй байна.	Үүнийг 10 дугаар бүлэгт зааснаар талууд эвлэрсэн гэж тодруулж заах. Мөн 10 дугаар бүлгийн Төлбөрийн чадваргүйдлийн өмнө үеийн эвлэрэл гэсэн зохицуулалтыг Төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаа эхлүүлэх гэсэн 3 дугаар бүлгийн өмнө нь оруулж өгвөл дарааллын хувьд тохиромжтой байна.

*Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийн төслийн
үр нөлөө тооцох судалгааны тайлан*

9.	20.2-т “Төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаа эхлүүлэх хүсэлтийг үүрэг гүйцэтгэгч гаргаж байгаа бол хүсэлтийн хувийг үүрэг гүйцэтгүүлэгч болон холбогдох эрх бүхий байгууллагад хүргүүлнэ” гэжээ.	Энэ хэсгийн “холбогдох эрх бүхий байгууллагад хүргүүлэх” гэсэн нь ойлгомжгүй байх бөгөөд ямар байгууллага байх юм бэ гэдэг нь тодорхойгүй.	Иймд холбогдох эрх бүхий байгууллага гэдгийг тодорхой заах.
10.	20.5-д “Хүсэлт гаргагч нь үүрэг гүйцэтгэгч биш бол үүрэг гүйцэтгэгч энэ хуулийн 20.1-д заасан мэдэгдлийг хүлээн авсан өдрөөс хойш 14 хоногийн дотор энэ хуулийн 16.2, 16.3-т заасан баримт бичиг болон бусад баримтыг гаргаж өгөх, хариу тайлбар гаргах үүрэгтэй” гэжээ.	Энэ заалтын “үүрэг гүйцэтгэгч биш бол үүрэг гүйцэтгэгч нь” гэдэг нь ойлгомжгүй байна.	Үүнийг “хүсэлт гаргагч нь нэхэмжлэгч байгаа бол хариуцагч нь гэж...” найруулбал ойлгомжтой болохоор харагдаж байна.
11.	24.1-д “Шүүгч хариуцагчийн хөрөнгө захиран зарцуулахгүй байхыг даалгасан захирамжаа хүчингүй болгосон бол энэ тухай нийтэд мэдээлнэ” гэжээ.	Энэ заалтын “...хүчингүй болгосон бол...” гэдэг нь ойлгомжгүй байна. Энэ заалт нь агуулгын хувьд ИХШХШТХ-ийн 124 дүгээр зүйлтэй адил байх бөгөөд ИХШХШТХ-д шүүгчийн захирамжийг хүчингүй болох үндэслэлийг тодорхой зохицуулсан байдаг. Харин хуулийн төслийн уг заалтын хүчингүй болгох үндэслэлийн талаар зохицуулалт байхгүй учраас тодорхойгүй харагдаж байна.	Иймд шүүгчийн захирамжийг хүчингүй болгох үндэслэлийг томъёолж заах.
12.	25.1-д “түр хэрэг гүйцэтгэгч үүрэг гүйцэтгэгчийг төлбөрийн чадваргүй болсон тухай дүгнэлт гаргасан бол шүүх төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааг эхлүүлэх захирамж гаргахын өмнө төлбөрийн чадваргүй болсон шалтгааныг тодруулах зорилгоор хүсэлт гаргагч болон үүрэг гүйцэтгэгчийг оролцуулан шүүх хурал хийж болно” гэжээ.	Энэ заалтын “шүүх төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааг эхлүүлэх захирамж гаргахын өмнө төлбөрийн чадваргүй болсон шалтгааныг тодруулах зорилгоор хурал хийнэ” гэдэг нь ойлгомжгүй байна. Шүүх хуралдаанаар шалтгааныг тодруулах шаардлагагүй. Түр хэрэг гүйцэтгэгчийн дүгнэлтийг хэргийн оролцогчдод танилцуулж, бичгээр тайлбар авч, хэрэгт хавсаргаснаар төлбөрийн чадваргүй	Иймд уг заалтыг “...түр хэрэг гүйцэтгэгчийн дүгнэлтийг хүсэлт гаргагч, үүрэг гүйцэтгэгч буюу хариуцагч, үүрэг гүйцэтгүүлэгч буюу нэхэмжлэгч нарт танилцуулж, дүгнэлтийн талаарх тэдний тайлбарыг бичгээр авч хэрэгт хавсаргах” гэж өөрчлөн найруулах боломжтой байна.

*Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийн төслийн
үр нөлөө тооцох судалгааны тайлан*

		болсон шалтгааныг тодруулах боломжтой гэж үзэж байна.	
13.	35.3-т “шүүхээс нэхэмжлэгчид тайлбар бэлтгэх боломжит хугацааг олгоно” гэжээ.	Энэ заалтын “боломжит хугацаа” гэдэг нь тодорхойгүй байгаа нь шүүх уг заалтыг хэрэгжүүлэхэд хүндрэлтэй гэж үзэхээр байна.	Тиймээс уг хугацааг 20.5-д заасан 14 хоногийн хугацаатай уялдуулж, хугацааг тодорхой болгон тусгах.
14.	45.1-д “хууль, гэрээний дагуу барьцааны эрхтэй үүрэг гүйцэтгүүлэгч шаардлагаа энэ хуулийн 81, 82 дугаар зүйлд заасны дагуу барьцааны зүйлээс тусад нь хангуулах эрхтэй” гэжээ.	Энэ зүйлийн “барьцааны зүйлээс тусдаа хангуулах эрхтэй” гэдэг нь ойлгомжгүй байна.	Энэ заалтыг тодорхой болгон найруулах.
15.	64.3-т “энэ хуулийн 64.1-т заасны дагуу үүргээ гүйцэтгээгүйн улмаас гаргах үүргийн шаардлагыг талуудын тохирсон үнэ, төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааг эхлүүлсэн хоногийн дараа хоногийн биржийн үнэ болон үүрэг гүйцэтгэх газрын зах зээлийн үнийн тэнцвэрт байдлыг харгалзан гэрээнд заасан хугацааны туршид тооцно” гэжээ.	Энэ заалтын “Төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааг эхлүүлсэн хоногийн дараа хоногийн биржийн үнэ” гэсэн хэсэг нь ойлгомжгүй байна.	Иймд “Төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаа эхлүүлсэн өдрийн биржийн үнэ...” гэж тодорхой болгон тусгах.
16.	50.1.10-т “хариуцагчийн үйл ажиллагаатай холбогдох асуудлаар шүүхэд хандах”, 72.2-т “хэрэг гүйцэтгэгч хүчин төгөлдөр бус хэлцлийг батлуулахаар шүүхэд хүсэлт гаргана”, 96.3-т “хүсэлтийн талаар нийтэд мэдээлснээс хойш 10 хоногийн дотор төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааны нэхэмжлэгчид хүсэлтийг эс зөвшөөрч шүүхэд хандаж болно”, 106.3-т “Барьцаат нэхэмжлэгчдийн эрх ашиг хөндөгдсөн эсэх асуудлаар маргаан гарвал шүүхэд гомдол гаргах эрхтэй” гэжээ.	Энэ заалтуудын “...шүүхэд хүсэлт гаргана...”, “...шүүхэд хандаж болно”, “...шүүхэд гомдол гаргах эрхтэй” гэсэн нь төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаа эхлүүлсэн шүүх, эсхүл өөр шүүхийн алин болох нь ойлгомжгүй байна.	Иймд энэ заалтуудыг тодорхой болгон найруулах.
17.	81.3-т “барьцааны зүйлийг худалдсанаас олсон орлогыг хуваарилахаас өмнө тус хөрөнгөөс төлөгдвөл зохих худалдах, эд хөрөнгө,	Энэ заалтын “... хөрөнгөөс төлөгдвөл зохих худалдах, эд хөрөнгө, шаардлагыг тодорхойлох зардлыг хэрэг гүйцэтгэгчид төлж...	Иймд уг заалтыг тодорхой болгон найруулах

*Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийн төслийн
үр нөлөө тооцох судалгааны тайлан*

	шаардлагыг тодорхойлох зардлыг хэрэг гүйцэтгэгчид төлж, үлдэх орлогоос тухайн эд хөрөнгийн хувьд барьцааны эрхтэй нэхэмжлэгчийн шаардлагыг хангана” гэжээ.	гэдэг” хэсэг юуг илэрхийлэх гэж байгаа нь ойлгомжгүй байна.	
18.	85.5-д “энэ хуулийн 85.4-т заасан гомдлыг хянан шийдвэрлэсэн шүүгчийн захирамжийг эс зөвшөөрвөл холбогдох этгээд энэ хуульд заасан журмын дагуу гомдол гаргах эрхтэй”. 88.4-т “эцсийн хуваарилалтыг зөвшөөрсөн шүүгчийн захирамжийг эс зөвшөөрвөл холбогдох этгээд нь энэ хуульд заасан журмын дагуу гомдол гаргах эрхтэй” гэжээ.	Энэ заалтуудын “...холбогдох этгээд...”, “энэ хуульд заасан журмын дагуу гомдол гаргах эрхтэй” гэдэг нь ойлгомжгүй байна. Өөрөөр хэлбэл холбогдох этгээд гэдэгт хэнийг ойлгох нь тодорхойгүй, хуульд тодорхойлсон хэргийн оролцогч мөн эсэх, түүнчлэн гомдлыг аль шүүхэд гаргах нь тодорхойгүй.	Иймд холбогдох этгээд гэдгийг “хэргийн оролцогч” гэж, гомдол гаргах эрхтэй гэдгийг “тухайн шүүхэд хуулийн төслийн 11.2-т заасан журмаар” гэж зааж оруулах.
19.	86.1-д “маргаантай шаардлагын нэхэмжлэгч нь хуульд заасан журмын дагуу хянан шийдвэрлүүлэх ажиллагааг түдгэлзүүлсэн, сэргээсэн, нэгтгэсэн талаарх нотолгоог энэ хуулийн 85.2-т заасны дагуу хуваарилалтын төлөвлөгөөг нийтэд мэдээлснээс хойш 7 хоногийн дотор хэрэг гүйцэтгэгчид гаргаж өгнө” гэжээ.	Энэ заалтын “маргаантай шаардлагын нэхэмжлэгч” гэдэг нь, “нийтэд мэдээлснээс хойш” гэдэг нь ойлгомжгүй байна. Учир нь аль шүүхэд байгаа маргаантай шаардлага вэ, нийтэд ямар журмаар, ямар хугацаанд, хэн мэдээлэх вэ гэдэг нь тодорхойгүй байна.	Иймд “өөр шүүхэд байгаа маргаантай шаардлагын нэхэмжлэгч гэж”, нийтэд мэдээлэх журмыг хуулийн төслийн “10.1-д заасан журмын дагуу” гэж тодруулж, найруулах нь зүйтэй.
20.	91.1-д “эцсийн хуваарилалт явагдаж дуусмагц шүүх төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаа дуусгавар болгох шийдвэр гаргана”. 91.2-т “энэ хуулийн 91.1-д заасан шийдвэрт төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаа дуусгавар болсон үндэслэлийг дурдаж, улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлэхийг хэрэг гүйцэтгэгчид даалгана”.	Энэ зүйлүүдэд заасан “шийдвэр” гэдэг нь хуулийн этгээдийн төлбөрийн чадваргүйд тооцож, татан буулгах эцсийн шийдвэр мөн эсэх нь ойлгомжгүй байна. Мөн хуулийн төслийн 110.7-д “шүүх төлөвлөгөөг батлаагүй бол хуулийн этгээдийг дампуурсанд тооцож, татан буулгах шийдвэр гаргана гэж заажээ. Дээрх заалтуудыг агуулгаар нь харвал хуулийн этгээдийг татан буулгаж, дампуурсанд тооцсон эцсийн шийдвэр байхаар ойлгогдож байна. Уг хоёр заалтын 91 дүгээр зүйлийн агуулга шийдвэр эцсийнх байхаар, 110	Иймд 91.1-т “...дуусгавар болгон, төлбөрийн чадваргүйд тооцож, татан буулгах шийдвэр гаргана” гэж нэмэх, 110.4, 110.6, 110.7-д заасан шийдвэр гэдгийг “шүүгчийн захирамж” болгон өөрчлөх, мөн 110.7-д “...төлөвлөгөөг батлаагүй бол захирамж гарган төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааг үргэлжлүүлэх” гэж нэмж оруулбал ойлгомжтой болохоор байна.

*Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийн төслийн
үр нөлөө тооцох судалгааны тайлан*

	91.3-т “энэ хуулийн 91.1-д заасан шийдвэрийн хувийг хуулийн этгээдийн улсын бүртгэлийн болон татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ”. 110.4-т “төлөвлөгөөг баталсан, эсхүл батлахаас татгалзсан шийдвэрийн талаар төлөвлөгөөг хэлэлцэж, санал өгөх хурал дээр шүүх танилцуулна”. 110.6-д “төлөвлөгөөг баталсан, эсхүл батлахаас татгалзсан шийдвэрт нэхэмжлэгч, хариуцагч энэ хуульд заасан журмаар гомдол гаргах эрхтэй” 97.1-д “энэ хуулийн 93, 94, 95 дугаар зүйлд заасны дагуу гарсан төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааг зогсоох тухай шүүхийн шийдвэр болон зогсоох болсон үндэслэлийн талаар нийтэд мэдээлнэ” гэжээ.	дугаар зүйл нь төлөвлөгөөг батлах, эсэхтэй холбоотой шийдвэр байх тул эцсийнх нь гэж үзэх боломжгүй, шүүгчийн захирамжаар асуудлыг шийдвэрлэхээр байна. Мөн шийдвэрийг хэн, ямар хугацаанд дурдсан байгууллагад хүргүүлэх нь тодорхойгүй байна.	Шүүхээс шүүгчийн захирамж гарснаас хойш ажлын 5 хоногт багтаан дурдсан байгууллагад хүргүүлэх гэж тодорхой болгон зохицуулах. Иймд энэ хэсгийг хуулийн төслийн 10.1-д заасан журмаар шүүгчийн захирамжийг нийтэд мэдээлэх гэж тодорхой болгох,
21.	110.5-д “Төлөвлөгөөг баталсан бол төлөвлөгөөний нэг хувь, үндсэн агуулгын хураангуйг шаардлага гаргасан нэхэмжлэгчдэд хүргүүлнэ” гэжээ.	Энэ заалтын “үндсэн агуулгын хураангуйг” гэдэг нь төлөвлөгөөний үндсэн агуулгыг хэлж байгаа эсэх нь ойлгомжгүй байна.	Иймд ойлгомжтой өөрчлөн найруулж, томъёолох
22.	93.2-т “төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааны урьдчилсан төлбөрийг төлсөн бол төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааг дуусгавар болгох захирамж гаргахгүй” гэжээ.	Энэ заалтын “дуусгавар болгох захирамж гаргахгүй” гэдэг нь ойлгомжгүй байна. Энэ нь 93.1-д заасан төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааг зогсоох гэсэнтэй нийцэхгүй байна.	Иймд “дуусгавар болгох” гэдгийг “зогсоох” гэж өөрчлөн найруулах

*Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийн төслийн
үр нөлөө тооцох судалгааны тайлан*

23.	98.4-т “төлөвлөгөөг энэ хуульд заасан журмын дагуу шүүхээс баталснаар дахин зохион байгуулах ажиллагаа эхэлсэн гэж үзнэ” гэжээ.	Энэ заалтын “...шүүхээс баталснаар...” гэдэг нь ойлгомжгүй байна. Шүүх төлөвлөгөөг батлаад ямар эрхийн акт гаргах вэ гэдэг нь тодорхойгүй.	Иймд “төлөвлөгөөг шүүхээс захирамж гарган баталснаар...” гэж тодруулах,
24.	99.3-т “бүлгийн бүх оролцогчтой ижил тэгш харилцах бөгөөд ялгаатай харилцах бол тухайн бүлгийн бусад оролцогчийн зөвшөөрлийг авна” гэжээ.	Энэ заалтын “...ялгаатай харилцах” гэдэг нь ойлгомжгүй байна.	Иймд үүнийг тодруулах,
25.	110.2-т “шүүх төлөвлөгөөг батлахаас өмнө хэрэг гүйцэтгэгч, нэхэмжлэгчдийн зөвлөл, хариуцагчийн тайлбар, саналыг сонсоно” гэжээ.	Эн заалтын “...тайлбар, саналыг сонсоно” гэдэг нь ойлгомжгүй байна. Учир нь шүүх хуралдаан хийх юм уу, эсхүл бичгээр тайлбар авах юм уу, эсхүл шүүх хуралдааны бус хэлбэрээр уулзалт зохион байгуулах юм уу гэдэг нь тодорхойгүй байна.	Иймд энэ байдлыг тодруулах, өөрөөр хэлбэл бичгээр тайлбар авах гэдэг хэлбэрээр хуульд тусгах нь ойлгомжтой байна.
26.	19.1-д “энэ хуулийн 18 дугаар зүйлд заасан татгалзах үндэслэл байхгүй, 15, 16 дугаар зүйлд заасан баримт бичиг бүрэн бол шүүх урьдчилсан төлбөр төлөхийг хүсэлт гаргагчид даалгана”, 93.1 “төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааг эхлүүлсний дараа хуваарилагдах хөрөнгө төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааны зардлыг төлөхөд хүрэлцэхгүй болох нь тогтоогдсон бол шүүх төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааг зогсооно”, 114.2-т “энэ хуулийн 112.4.2-т заасан санал бүхий тайлан, 114.1-д заасан хүсэлтийг хүлээн авсны дараа шүүх хариуцагч, нэхэмжлэгчин зөвлөлийн санал, тайлбарыг сонссоны үндсэн дээр нэхэмжлэгчдийн шаардлагыг төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааны журмаар хангахыг хэрэг гүйцэтгэгчид даалгана” гэжээ.	Энэ заалтуудын “...хүсэлт гаргагчид даалгана”, “шүүх төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааг зогсооно”, “...хэрэг гүйцэтгэгчид даалгана” гэж заасан байх боловч шүүхээс ямар эрхийн актаар шийдвэрлэх нь ойлгомжгүй байна.	Иймд шүүх, шүүгчээс гарах эрхийн актыг тодорхой болгох Мөн 19.1-д “...төлбөрийг 8.2, 8.3-т заасан хэмжээгээр төлөхийг хүсэлт гаргагчид даалгах” гэж найруулах Түүнчлэн 19.2-т байгаа 7 хоног гэдгийг “ажлын 7 хоног” гэж өөрчилж найруулах.

Түүнчлэн энэхүү шалгуурын дагуу хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан хууль тогтоомжийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага, 30 дугаар зүйлд заасан хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлагад нийцүүлэн боловсруулсан эсэхийг дараах байдлаар шалгалаа.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан Хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага	
Хууль тогтоомжийн тухай хуулийн зохицуулалт	Хуулийн төслийн зохицуулалтад үнэлгээ хийсэн байдал
29.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн, бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай уялдсан байх;	Шаардлагыг хангасан. Уялдсан гэж үзэж байна.
29.1.2.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгасан байх;	Шаардлага хангасан гэж үзэж байна.
29.1.3.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцааны хүрээнээс хальсан асуудлыг тусгахгүй байх;	Шаардлага хангасан.
29.1.4.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд үл хамаарах хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу хүчингүй болсонд тооцох тухай заалт тусгахгүй байх;	Шаардлага хангасан.
29.1.5.зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх;	Төслийн зарим зүйл, заалт хоорондоо зөрчилтэй гэж үзэж байгаа үндэслэл, саналаа шалгуур үзүүлэлт тус бүрт бичсэн байгаа.
29.1.6.хэм хэмжээ тогтоогоогүй, тунхагласан шинжтэй буюу нэг удаа хэрэгжүүлэх заалт тусгахгүй байх;	Шаардлага хангасан.
29.1.7.бусад хуулийн заалтыг давхардуулан заахгүйгээр шаардлагатай бол түүнийг эш татах, энэ тохиолдолд эшлэлийг тодорхой хийж, хуулийн нэр болон хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заасан байх;	Шаардлага хангасан
29.1.8.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаа, хуулийн үйлчлэх хүрээ, эрх зүйн харилцаанд оролцогч хүн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, зохицуулалтад удирдлага болгох, харгалзан үзэх нөхцөл байдал, нийтийн эрх зүйн этгээдийн чиг үүрэг, эрх хэмжээ, тэдгээрийг биелүүлэх журам;	Шаардлага хангасан
29.1.9.шаардлагатай тохиолдолд эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын төрөл, хэмжээ, хуулийн хүчин төгөлдөр болох хугацаа, хууль буцаан хэрэглэх тухай заалт, хуулийг дагаж мөрдөх журмын зохицуулалт, бусад хуулийн зүйл, заалтыг хүчингүй болсонд тооцох, хасах заалт;	Шаардлага хангасан
29.1.10.шаардлагатай тохиолдолд бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон хууль хүчингүй болсонд тооцох тухай дагалдах хуулийн төслийг боловсруулсан байх;	Боловсруулсан

29.1.11.хуулийн төсөл нь хуулийн зорилго гэсэн зүйлтэй байж болох бөгөөд зорилгод тус хуулиар хангахаар зорьж байгаа иргэний үндсэн эрх, бэхжүүлэх үндсэн зарчим, хүрэх үр дүнг тусгана.	Шаардлага хангасан
Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйлд заасан Хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлага	
30.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд хэрэглэсэн нэр томъёог хэрэглэх;	Шаардлага хангасан
30.1.2.нэг нэр томъёогоор өөр өөр ойлголтыг илэрхийлэхгүй байх;	Энэ талаарх санал, дүгнэлтээ шалгуур үзүүлэлтүүдэд тухай бүр тусгасан байгаа.
30.1.3.үг хэллэгийг монгол хэл бичгийн дүрэмд нийцүүлэн хоёрдмол утгагүй товч, тодорхой, ойлгоход хялбараар бичих;	Энэ талаарх санал, дүгнэлтээ шалгуур үзүүлэлтүүдэд тухай бүр тусгасан байгаа.
30.1.4.хүч оруулсан нэр томъёо хэрэглэхгүй байх;	Шаардлага хангасан
30.1.5.жинхэнэ нэрийг ганц тоон дээр хэрэглэх.	Шаардлага хангасан

2.3.Шалгуур үзүүлэлт: Практикт хэрэгжих боломж

“Практикт хэрэгжих боломж” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зохицуулалтыг дагаж мөрдөх болон хэрэгжих боломжтой эсэх гэсэн үндсэн асуудлыг хөндөхийг зорьж дараах дарааллын дагуу төслийг судлахыг зорилоо. Үүнд:

1. Төслийг хэрэгжүүлэх боломж хэр байна;
2. Хэрэгжүүлэх субъект байгаа эсэх;
3. Хэрэгжүүлэгч субъектэд тухайн хуулийн зохицуулалтыг хэрэгжүүлэх боломж, бололцоо /санхүү, хүний нөөц зэрэг/ байгаа эсэх зэрэг болно.

Энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд судалгааг гүйцэтгэхдээ уг хуулийн төслийн хэрэглэгч субъектүүдэд хандсан асуулга авах, бүлгийн ярилцлага хийх, тухайн хуулийн төсөлтэй холбоотой эх сурвалжийн судалгаа хийх зэргээр уг хуулийн төслийн зохицуулалтыг шүүх хэрэгжүүлэх боломжтой эсэх, иргэдийн эрх чөлөөг хязгаарлаж байгаа эсэх, хуулийн этгээдэд шинээр үүрэг хүлээлгэсэн эсэх, шүүхийн үйл ажиллагаанд ачаалал нэмэгдүүлж байгаа эсэхийг тодруулахыг зорьсон бөгөөд уг асуулга, бүлгийн ярилцлаганд ойролцоогоор 70 гаруй шүүгч, шүүхийн захиргааны ажилтнууд, өмгөөлөгч оролцсон болно.

2.3.1.Хуулийн төслийг хэрэгжүүлэх боломжтой эсэх:

Уг төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийн төслийг хэрэгжүүлэх боломж хир байгааг судлахдаа одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Дампуурлын тухай хуулийн хэрэгжилтийг жишиг болгон хуулийн төслийн практикт хэрэгжих боломжийн талаар судалж үзлээ.

Шүүхийн Ерөнхий зөвлөлөөс гаргадаг шүүн таслах ажиллагааны нэгдсэн дүн мэдээнээс харахад 2015-2018 оны хооронд Дампуурлын тухай хуулиар нийт 69

хэрэг шийдвэрлэсэн байх ба энэ нь нийт иргэний хэрэгт дунжаар 0.03 хувийг эзэлж байна⁵.

Дампуурлын хэрэг гүйцэтгэх ажиллагаа нь хэвшиж тогтсон үйл ажиллагаа хэдий ч дампуурлын ажиллагааг эхлүүлэх процесс, төлбөрийн чадваргүй хуулийн этгээдийн эд хөрөнгөтэй харилцах харилцаа, төлбөрийн чадваргүй этгээдийн нэгэнт байгуулчихсан хүчин төгөлдөр хэлцлүүдийг хэрхэн шийдвэрлэх, хүчин төгөлдөр бус байж болох гэрээ, хэлэлцээрийн талаар авах арга хэмжээ, үүргийг тооцож дуусгавар болгох зэрэг асуудлыг шийдвэрлэхэд тодорхой нарийвчилсан зохицуулалт байхгүйн улмаас хүндрэл гардаг байна. Өөрөөр хэлбэл дампуурлын хэрэг үүсгэх, шийдвэрлэх ажиллагааг хэт ерөнхий заасан, хэрэг гүйцэтгэгчийн тоо хангалтгүйн улмаас хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа удаашрах зэргээр чирэгдэл учирдаг байна. Дампуурлын хэрэг шийдвэрлэх ажиллагааг жишиг болгон судлахад дараах үе шаттай байдаг байна. Үүнд:

1. Хэрэг үүсгэх нэхэмжлэл, хүсэлт гаргана
2. Нэхэмжлэл, хүсэлтийг хүлээн авснаас хойш 5 хоногийн дотор дампуурлын хэрэг үүсгэх тухай захирамж гаргана
3. Дампуурлын хэрэг үүсгэснээс хойш 5 хоногийн дотор шүүх нэхэмжлэлийн хувийг хариуцагчид гардуулж, 30 хоногийн дотор хариуцагчийг төлбөрийн чадвартай эсэхийг тогтооно.
4. Хариуцагч төлбөрийн чадваргүй болох нь тогтоогдвол энэ тухай 7 хоногийн дотор хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлнэ.

Харин хуулийн төсөлд эдгээр ажиллагааг улам нарийсгаж төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаа эхлүүлэх хүртэл буюу өнөөгийн ойлголтоор төлбөрийн чадваргүйдлийн хэргийг үүсгэх хүртэлх хугацаанд гэхэд л дараах олон үе шатыг дамжихаар заажээ. Үүнд:

1. Хүсэлт гаргах
2. Шүүх хүсэлтийг 10 хоногийн дотор хянаж хүлээн авахаас татгалзах эсхүл татгалзах үндэслэл байхгүй бол урьдчилсан төлбөр төлөх болон хүсэлтийн бүрдүүлбэр дутуу бол бүрдүүлбэрийг хангахыг хүсэлт гаргагчид даалгах
3. Урьдчилсан төлбөр төлөгдсөнөөс хойш 7 хоногийн дотор түр хэрэг гүйцэтгэгч томилно
4. Шаардлагатай бол албадлагын арга хэмжээ авах
5. Түр хэрэг гүйцэтгэгч томилогдсоноосоо хойш 20 хоногийн дотор үүрэг гүйцэтгэгчийн төлбөрийн чадварын талаар дүгнэлт гаргана
6. Түр хэрэг гүйцэтгэгчийн дүгнэлтээс хамааран хэрэг үүсгэх болон хэрэг үүсгэхээс татгалзах шийдвэрийг гаргана. Шүүх төлбөрийн чадваргүй болсон шалтгааныг тодруулах зорилгоор хэрэг үүсгэхээс өмнө шүүх хуралд хийж болно.
7. Төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааг эхлүүлэх захирамж гаргана.

Энэ нь гагцхүү хэрэг үүсгэх хүртэлх шатанд хэрэгжих алхмууд бөгөөд хэргийг үүсгэх буюу төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаа эхлүүлснээр хэрэг гүйцэтгэгчийг томилох, нэхэмжлэл хүлээж авах, баталгаажуулах хурал хийж нэхэмжлэгчдийн саналын эрхийг тогтоох, хариуцагчийн хөрөнгийг хамгаалах, захиран зарцуулах эрхийг хэрэг гүйцэтгэгчид шилжүүлэх, дүгнэлтийн хурал хийх, хөрөнгийг худалдах,

⁵ Шүүхийн ерөнхий зөвлөл, Монгол Улсын шүүхийн шүүн таслах ажиллагааны тайлан, 2015, 2016, 2017, 2018

хуваарилах, төлбөрийн чадваргүй хуулийн этгээдийг татан буулгах, дахин зохион байгуулах зэрэг нарийвчилсан ажиллагаануудыг хийж гүйцэтгэнэ.

Төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааг эхлүүлэхэд ихээхэн чухал нэгэн заалт орсон нь шүүхэд хэрэг үүсгэж ажиллагаа эхлүүлэхийн тулд төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааны зардлыг нөхөхөд шаардлагатай урьдчилсан төлбөрийг тодорхой дансанд эхлэн байршуулах явдал байна. Энэ нь төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийг бодитой, жинхэнэ утгаараа ач холбогдолтой хэрэгжих ач холбогдол бүхий зохицуулалт болсон байх ба энэ ч агуулгаараа шүүхийн ачаалал тэр хэмжээгээр нэмэгдэх нөхцөл байдлыг бүрдүүлэх магадлалтай юм.

1. Хуулийн төслийн 10.1-д “Төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааны талаар нийтэд мэдээлэхээр энэ хуульд заасан мэдээллийг шүүхийн цахим хуудас болон өдөр тутмын хэвлэл, мэдээллийн хэрэгсэлд ажлын 2-оос доошгүй хоногийн хугацаанд нийтэлнэ” гэж заасан.

Түүнчлэн хуулийн төслийн 21.5, 24.1, 26.6, 92.6, 93.6, 97.1, 104., 114.3, 128.4 гэсэн зүйл, заалтуудад шүүхийн зүгээс хүсэлт, түүнийг шийдвэрлэсэн захирамж, шийдвэрийн талаар нийтэд мэдээлэхтэй холбоотой зохицуулалтууд тусгагдсан байх бөгөөд дээрх зохицуулалтуудад хугацаа тодорхойгүй байгаа нь уг заалтуудыг шүүх хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байна. Дээрх заалтуудын ерөнхий зохицуулалт нь хуулийн төслийн 10.1-д тусгагдсан гэж үзвэл “ажлын 2-оос доошгүй хоногийн хугацаанд нийтэд мэдээлэх” гэсэн нь хугацааны хувьд хэт богино, практикт хэрэгжих бодит боломжгүй байгаа нь санал асуулгын дүнгээс харагдаж байх бөгөөд энэ нь шүүхээс гаргаж байгаа эрхийн актыг боловсруулах, албажуулах, хүчин төгөлдөр үйлчлэх цаг хугацаатай хамааралтай байдаг. Иймд уг хугацааг хэрэгжүүлэх боломжтой байдлаар “ажлын 5 хоногийн дотор” гэж хуульд тусгах нь зүйтэй гэж үзлээ.

Мөн хуулийн төслийн 92.5, 92.6-д зааснаар нэмэлт хуваарилалт явуулах тухай хүсэлт, 96.1-д зааснаар төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааг зогсоох хүсэлт, 97.1-д зааснаар төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааг зогсоох тухай шүүгчийн захирамжаас гадна зогсоох болсон үндэслэлийн талаар шүүх нийтэд мэдээлэхээр тус тус зохицуулжээ.

Санал асуулгад оролцогчдын 65.2% нь дээрх зохицуулалт шаардлагагүй, шүүхэд илүү ачаалал үүсгэх магадлалтай, 34,8% нь хүсэлт, үндэслэлийг шийдвэрлэсэн шүүгчийн захирамжийг нийтэд мэдээлснээр хуулийн дээрх зохицуулалт хэрэгжих боломжтой гэж үзсэн байна. Эндээс дүгнэхэд хэргийн оролцогчийн гаргасан хүсэлт, үндэслэл бүрийг нийтэд мэдээлэх нь чухал биш, харин уг асуудлыг хэрхэн шийдвэрлэсэн шүүгчийн захирамжийг нийтэд мэдээлэхэд хангалттай байна.

2. Хуулийн төслийн 12.1-д “Хуулийн этгээд хууль, эсхүл гэрээнд заасан мөнгөн төлбөрийн үүргээ үргэлжилсэн 6 сараас дээш хугацаагаар биелүүлж чадахгүй байх, өр төлбөр нь хуулийн этгээдийн санхүүгийн тайланд тусгагдсан нийт хөрөнгийн үнэлгээний 50%-иас хэтэрсэн байх нь төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааг эхлүүлэх хүсэлт гаргах үндэслэл болно” гэжээ. Үүний “...үргэлжилсэн 6 сараас дээш” гэдэг хугацаа хэт богино гэж үзэхээр байна. Иймд хугацааг Иргэний хуулийн 75 дугаар зүйлд заасан хөөн хэлэлцэх хугацаатай уялдуулан өөрчлөх. Шүүхийн практикт гарч байгаа жишээнээс үзвэл үүрэг гүйцэтгэгч буюу хариуцагч

этгээд 2-3 жилийн турш үүргээ гүйцэтгээгүй зөрчил түгээмэл байдаг тул уг хугацааг үргэлжилсэн 1 жилээс дээш байхаар тусгаж өгөх нь зүйтэй.

3. Хуулийн төслийн 11.2-т “энэ хуульд өөрөөр заагаагүй бол шүүгчийн захирамжийг гардан авсан өдрөөс хойш ажлын 5 хоногийн дотор тухайн шатны шүүхэд гомдол гаргана” гэж заасан. Түүнчлэн хуулийн төслийн 18.3, 21.3, 26.7, 82.3, 32.4, 51.9, 62.6, 85.5, 88.4, 92.7, 102.2, 110.6, 128.3, 128.4 гэсэн зүйл, заалтуудад зааснаар шүүгчийн захирамжид гомдол гаргахтай холбоотой зохицуулалтууд тусгагдсан байх бөгөөд дээрх зохицуулалтуудад хугацаа тодорхойгүйн дээр аль шүүхэд гомдлыг гаргах нь нарийн тодорхой тусгагдаагүй. Өөрөөр хэлбэл энэ байдал тодорхойгүй байгаа нь шүүхээс уг заалтуудыг хэрэгжүүлэх боломжгүй нөхцөл байдлыг бий болгохоор байна. Харин уг хугацаа тодорхой болсноор хэргийн оролцогчдыг эрх, үүргээ хэрэгжүүлэхэд хариуцлагатай хандах хөшүүрэг болох, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг сунжруулахгүй байхад нөлөөтэй юм.

Иймд дээрх заалтуудын ерөнхий зохицуулалт нь хуулийн төслийн 11.1, 11.2-т тусгагдсан гэж үзвэл дурдсан зохицуулалтад тодорхойгүй байгаа гомдол гаргах хугацааг уг заалттай нийцүүлэх нь хуулийг хэрэгжүүлэх субъектэд ойлгомжтой болно.

4. Хуулийн төслийн 20.2, 21.7, 25.3, 26.4, 26.5, 51.8, 41.5, 91.3, 92.6, 98.2, 104.3, 110.5-д зааснаар шүүхээс хэргийн оролцогчдын гаргасан хүсэлт, нэхэмжлэгчдийн хурлаас баталсан дахин зохион байгуулах төлөвлөгөө, шүүхэд дуудсан мэдэгдлүүд, шүүгчийн захирамжуудыг хүсэлт гаргагч, хариуцагч, үүрэг гүйцэтгүүлэгч, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, Татварын байгууллага, хариуцагчийн болон түүний толгой компанийн байрлаж байгаа Улсын бүртгэлийн байгууллага, холбогдох бусад байгууллагад хүргүүлэхээр, Хуулийн төслийн 20.1, 21.5, 34.3, 93.6, 114.3-т зааснаар шүүхээс хүсэлт, шүүгчийн захирамжууд, хуваарилах хөрөнгө хүрэлцээгүй байгаа тухай мэдэгдэл, хэрэг гүйцэтгэгчийн ажлын хөлсийг олгох талаарх шүүгчийн захирамж, хөрөнгийг захиран зарцуулахгүй байх, түр хэрэг гүйцэтгэгчийг томилох, дахин зохион байгуулах ажиллагаа дуусгавар болсон захирамжуудыг хэрэг гүйцэтгэгч, нэхэмжлэгчдийн зөвлөл, үүрэг гүйцэтгүүлэгч, түр хэрэг гүйцэтгэгч, үүрэг гүйцэтгэгч, түүнд өртэй этгээд, нэхэмжлэгч, үүрэг гүйцэтгүүлэгч, эрх бүхий байгууллагад гардуулахаар, мөн хуулийн төслийн 1104.-т шүүхээс санал өгөх нэхэмжлэгчдийн хуралд төлөвлөгөөг баталсан, эсхүл татгалзсан талаарх шүүхийн шийдвэрийн талаар танилцуулахаар тус тус зохицуулжээ.

Санал асуулгад оролцогчдын 39% нь шүүхээс гардуулах, хүргүүлэх ажиллагааг гүйцэтгэх нь шүүхийн ачаалалд нөлөөлнө гэж үзсэн, 26.2% нь шүүхээс эрхийн актууд болон мэдэгдлийг танилцуулах ажиллагааг явуулах нь зүйтэй гэж үзсэн байна. Үүнээс үзвэл шүүх хэргийн оролцогчдод эрх зүйн үр дагавар үүсгэх зайлшгүй гардуулах, хүргүүлэх шүүхийн шийдвэр, шүүх хуралдааны мэдэгдэх хуудас буюу мэдэгдлээс бусад эрхийн актууд буюу шүүгчийн захирамж, хүсэлт, мэдэгдлүүдийг хэргийн оролцогчдод танилцуулах нь шүүхийн ачаалалд нөлөөлөхгүй, хэргийн оролцогчдын эрх, ашгийг хөндөгдөхгүй байхаар харагдаж байна.

2.3.2.Хэрэгжүүлэх субъект байгаа эсэх:

Төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааг хэрэгжүүлэгч гол субъект нь шүүхээс гадна хэрэг гүйцэтгэгч байна. 2019 оны 9 сарын байдлаар Монгол улсад хэрэг гүйцэтгэгчээр ажиллаж буй хуулийн этгээд байхгүй, харин 5 хэрэг гүйцэтгэгч 2-30

хэрэгт оролцсон байна. Тиймээс эдгээр 5 хэрэг гүйцэтгэгчээс төлөөлөл болгож 3 хэрэг гүйцэтгэгчээс судалгаа авлаа. Энэхүү судалгааг чөлөөт ярилцлагын аргаар авсан бөгөөд Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийн төслийн заалтуудыг хүлээн зөвшөөрч байна уу гэсэн ерөнхий асуулт асууж, хүлээн зөвшөөрөхгүй байгаа тохиолдолд үндэслэл болон уг зохицуулалтыг боловсронгуй болгох саналаа өгөхийг хүссэн. Судалгаанд оролцсон хэрэг гүйцэтгэгч нар⁶ 100 хувь хуулийн зохицуулалтыг дэмжиж байсан.

Хуулийг хэрэгжүүлэх үндсэн 2 субъектын нэг болох хэрэг гүйцэтгэгчтэй холбоотой дараах асуудлууд хөндөгдөж байна. Үүнд:

1. Хүчин төгөлдөр үйлчилж буй Дампуурлын тухай хуулийг хэрэгжүүлэх явцад тулгардаг дараахь хүндрэлүүдийн талаар санал нэгтэй дурдаж байсан. Үүнд:

- a) Хэрэг гүйцэтгэгчийн тоо цөөн, урамшууллын систем байхгүйн улмаас хэрэг гүйцэтгэгчээр ажиллах сонирхол бага.
- b) Хэрэг гүйцэтгэгчийн мэдлэг, ур чадвар хангалтгүйн улмаас үүрэг гүйцэтгэгчийн төлбөрийн чадвар болон санхүүгийн талаар хуульд заасан хугацаанд дүгнэлт гаргадаггүй. Үүний улмаас хэрэг гүйцэтгэгчээс татгалзах, өөр хэрэг гүйцэтгэгч томилох зэргээр хэрэг сунжирдаг.
- c) Хэрэг гүйцэтгэгчийн урамшуулал тодорхойгүй.
- d) Тэмдэгтийн хураамжийн талаар шүүхийн нэгдсэн практик байхгүй, шүүгч бүр тэмдэгтийн хураамжийг янз бүрээр төлүүлдэг.
- e) Өдөр тутмын сонинд дампуурлын хэрэг үүсгэсэн талаар зар тавьдаг боловч, тухайн зарыг олж харахгүй байх, зарим тохиолдолд нэг ч нэхэмжлэгч ирдэггүй зэрэг хүндрэлүүдийг дурдаж байв.

Эдгээр хүндрэлийг залруулах, бий болгохгүй байх талаар хуулийн төсөлд тодорхой арга хэмжээ авснаас дэрдвал хэрэг гүйцэтгэгчид тавигдах шаардлага, тэдгээрийг томилох, эрх олгох механизмыг тодорхой болгож практикт хэрэгжих боломжийг бүрдүүлжээ. Түүнчлэн дээр дурдсанчлан тэдгээрийн урамшууллын системийг хэрхэн бий болгохыг зааж, хариуцлагыг чангатгаж өгсөн нь төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаа чанартай хэрэгжих гол хөшүүргийн нэг гэж үзэж байна. Хуулийн төслийн 27 дугаар зүйлд хэрэг гүйцэтгэгчийн эрх зүйн байдлыг тусгасан байна. Хэрэг гүйцэтгэгч нь хууль, санхүү, эдийн засаг, нягтлан бодох бүртгэл, аудит, эсхүл бизнесийн удирдлагын чиглэлээр мэргэжил эзэмшсэн, мэргэжлээрээ 3-аас доошгүй жил ажилласан; хэрэг гүйцэтгэгчийг бэлтгэх сургалтад хамрагдсан; эрх зүйн чадамжтай; ял шийтгэлгүй болон хуульд заасан журмын дагуу хэрэг гүйцэтгэгчээр ажиллах эрх авсан байх шаардлагыг тусгасан нь одоо хүчин төгөлдөр үйлчилж буй Дампуурлын тухай хуулийн зохицуулалтыг тодорхой болгож, нэмэлт шаардлага тусгажээ.

Хуулийн төслийн 20 дугаар зүйлийн 22.1 дэх хэсэг, 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсэгт зааснаас харахад хэрэг гүйцэтгэгч нь хариуцагчийн санхүүгийн болон төлбөрийн чадвартай эсэхэд дүгнэлт гаргах, тооцоо хийх, хөрөнгө хуваарилах төлөвлөгөө гаргах зэргээр санхүүгийн болон хуулийн мэдлэг шаардсан үүргийг гүйцэтгэдэг болох нь тодорхой байна. Иймд хэрэг гүйцэтгэгч нь хууль болон санхүүгийн мэргэжлийг давхар эзэмшсэн байх гэж шалгуурыг тодорхой болгох нь зүйтэй юм.

⁶ Судалгаанд хэрэг гүйцэтгэгч А.Энхболд, Т.Энхжаргал болон Ш.Буянжаргал нар хамрагдаж, хуулийн төсөл практикт хэрэгжих боломжтой гэж 100 хувь дүгнэснээс гадна, практикт тулгардаг хүндрэл бэрхшээлийн талаарх тэдний санал давхцаж байсан тул тусгайлан нэр дурдалгүйгээр тэдний саналыг тоймлон тусгасан болно.

Хуулийн төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.10 дахь хэсэгт "...хэрэг гүйцэтгэгч гэж энэ хуулийн 27 дугаар зүйлд заасан хувь хүн, хуулийн этгээдийг хэлнэ.." хэмээн заажээ. Хэрэг гүйцэтгэгчээр ажиллах хувь хүнд тавигдах шаардлагыг тус хуулийн төслийн 27 дугаар зүйлд тодорхой заасан ба харин хуулийн этгээдийн хувьд хэрэг гүйцэтгэгчийн үйл ажиллагаа эрхлэх эрх авсан байхыг шаардлагыг тусгасан байна. Харин хэрэг гүйцэтгэгчийн үйл ажиллагаа эрхлэх эрх олгох, сонгон шалгаруулах журмыг Засгийн газар батлахаар тусгажээ.

Өнөөдрийн байдлаар хэрэг гүйцэтгэгчийн үйл ажиллагаа эрхэлж буй хуулийн этгээд байхгүй байна. Иймд хуулийн этгээдэд хэрэг гүйцэтгэгчээр ажиллах эрх олгох журам батлах нь хуулийн этгээд хэрэг гүйцэтгэгчээр ажиллах заалтыг хэрэгжүүлэх үндэслэл болно.

Судалгаанд оролцсон хэрэг гүйцэтгэгчдийн онцлон тэмдэглэсэн хэрэг гүйцэтгэгчийн урамшууллын системтэй холбоотой нарийвчилсан зохицуулалт хуулийн төсөлд тусгагдсан нь сайшаалтай байна. Тухайлбал, Хуулийн төслийн 34 дүгээр зүйлд хэрэг гүйцэтгэгчийн ажлын хөлс, зардлын талаар, 9 дүгээр зүйл тэмдэгтийн хураамжийн талаар дэлгэрэнгүй зохицуулалт тусгасан байна.

2. Хуулийн төслийн 29 дүгээр зүйлд хэрэг гүйцэтгэгчийн үйл ажиллагаа эрхлэх эрх олгох асуудлыг Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Засгийн газрын баталсан журмын дагуу зохион байгуулж, эрх авсан хэрэг гүйцэтгэгч нарын нэрсийн жагсаалтыг өөрийн байгууллагын цахим сан болон шүүхийн цахим санд байршуулахаар зохицуулжээ. Энэ зохицуулалтаар Хууль зүйн яам болон шүүхэд нэмэлт үүрэг бий болгож байх бөгөөд энэ заалт хэрэгжих боломжтой байгаа нь санал асуулга, бүлгийн ярилцагаас харагдаж байна. Түүнчлэн шүүх хэрэг гүйцэтгэгчийн нэрсийн жагсаалтыг цахим сандаа байршуулснаар хуулийн төслийн 30.1, 30.2-т зааснаар хэрэг гүйцэтгэгчийг цахим хэлбэрээр, тохиолдлын журмаар сонгож томилох боломжтой байна. Үүнтэй холбоотойгоор шүүхэд шинэ үүрэг бий болгож байх тул бэлтгэл ажиллагаа шаардлагатай. Өөрөөр хэлбэл шүүхэд уг ажлыг гүйцэтгэх техникийн болон боловсон хүчний нөөц байгаа бөгөөд уг ажлыг шүүхийн тамгын газар нь Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хууль болон Шүүхийн ерөнхий зөвлөлөөс баталсан журмын дагуу шүүх хуралдаанд томилогдон оролцож байгаа иргэдийн төлөөлөгчийг тохиолдлын журмаар сонгож байгаа жишгийн адил хэрэгжүүлэх боломжтой гэж үзлээ.

3. Хуулийн төслийн 30.3-т төлбөрийн чадваргүйдлийн тухайн хэрэгт хэрэг гүйцэтгэгчээр ажиллах үнэмлэхийг шүүх олгох бөгөөд хянан шийдвэрлэх ажиллагаа дуусмагц хэрэг гүйцэтгэгч үнэмлэхийг шүүхэд буцаан өгөхөөр зохицуулсан. Энэ нь мөн шүүхэд шинэ үүрэг, ажиллагааг нэмэгдүүлж байх бөгөөд санал асуулгад оролцогчдын 60% нь уг зохицуулалтыг шаардлагагүй, 40% нь шаардлагатай гэж үзжээ. Энэ нь шүүхээс түр хэрэг гүйцэтгэгч, хэрэг гүйцэтгэгчийг хуулийн төслийн 21, 27 дугаар зүйлд зааснаар захирамж гарган томилж, 32.1-д зааснаар чөлөөлөх зохицуулалттай холбоотой байна. Иймд шүүхээс хэрэг гүйцэтгэгчид заавал үнэмлэх олгож, буцаан авах шаардлагагүй байгаа нь харагдаж байна.

Худалдааны төрөлжсөн шүүх

Манай улстай адил эх газрын эрх зүйн системтэй улсуудын төлбөрийн чадваргүйдлийн харилцааг зохицуулж буй эрх зүйн зохицуулалтыг судлан үзэхэд дийлэнх улсуудын хувьд бие даасан Худалдааны хуулийг батлах замаар төлбөрийн чадваргүйдлийн харилцааг ялгамжтай зохицуулж, төрөлжсөн худалдааны шүүхийн

хүрээнд дампуурлын хэргийг харьяалан шийдвэрлэж байгаа тул манай улсын хувьд ч одоогийн эрх зүйн зохицуулалтын хүрээнд төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааг ялгамжтайгаар зохицуулах шаардлага үүсэж байна.

Худалдааны төрөлжсөн хууль болон шүүхтэй улсын жишээнд ОХУ, ХБНГУ, Япон, Франц зэрэг олон орныг нэрлэж болно. Эдгээр улсуудаас ОХУ-ын худалдааны шүүхийн тогтолцоо, худалдааны шүүхийн үүсэл хөгжил нь урт удаан хугацааны баялаг уламжлал бүхий салбар болох нь харагддаг. ОХУ нь Иргэний болон худалдааны процессын эрх зүйн хувьд дуалист буюу хоёрдмол систем хөгжсөн хэдий ч материаллаг эрх зүйн хувьд иргэний болон худалдааны эрх зүйн нэгдмэл зохицуулалтыг эрхэмлэж ирсэн байна. ОХУ-ын Худалдааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 33 дугаар зүйлд худалдааны шүүхээр шийдвэрлэгдэх хэргийн төрлийг тогтоосон байна. Үүнд:

1. Дампуурлын хэрэг маргаан
2. Байгууллагыг үүсгэн байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгахтай холбоотой маргаан
3. Хувиараа аж ахуй эрхлэгч, хуулийн этгээдийг бүртгэхээс татгалзсантай холбоотой маргаан
4. Хувьцаа эзэмшигч болон хувьцаат компанийн хооронд үүссэн маргаан, худалдааны буюу бизнес эрхлэгч компани, нөхөрлөл болон тэдгээрийн гишүүдийн хооронд үүссэн компани болон нөхөрлөлийн үйл ажиллагаатай холбоотой хөдөлмөрийн эрх зүйн шинжтэйгээс бусад маргаан
5. Ажил хэргийн нэр хүндийг хамгаалахтай холбоотой маргаан
6. Аж ахуйн үйл ажиллагаа эрхлэн явуулахтай холбоотой үүссэн болон Холбооны хуульд заасан эдийн засгийн шинжтэй үйл ажиллагаанаас үүссэн маргаан

Эдгээр төрлийн маргаан ямар этгээдийн хооронд үүссэнээс үл хамааран худалдааны шүүхийн бүрэн эрхэд хамаарах юм. Судлаачдын үзэж байгаагаар энэ нь шүүхийн харьяалалтай холбоотой ойлгомжгүй, тодорхойгүй байдлыг нэг мөр болгоход ихээхэн дөхөм болжээ. Тодруулбал маргаанд оролцогч субъектийн байдлаас үл шалтгаалан дээр дурдсан төрлийн хэрэг маргаан гарсан тохиолдолд ОХУ-ын хувьд энэ нь худалдааны шүүхийн онцгой харьяалалд хамаарах юм. Франц, Япон зэрэг бусад худалдааны шүүхтэй улс орнуудын хувьд төлбөрийн чадваргүйдлийн харилцааг төрөлжсөн шүүхээр шийдвэрлэдэг байна. Энэ нь төлбөрийн чадваргүйдлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанаас зарчим, хугацаа, хэргийн оролцогчдын эрх зүйн байдал зэрэг олон зүйлээр ялгаатай байдагтай холбоотой.

2.3.3.Хэрэгжүүлэгч субъектэд тухайн хуулийн зохицуулалтыг хэрэгжүүлэх боломж, бололцоо /санхүү, хүний нөөц зэрэг/ байгаа эсэх:

Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийн зохицуулалтыг хэрэгжүүлэгч нарт санхүү, хүний нөөц байгаа эсэхэд судалгаа хийж үзвэл:

Шүүхийн хувьд одоогийн хүчин төгөлдөр үйлчилж буй Дампуурлын тухай хууль болон Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дагуу төлбөрийн чадваргүйдлийн хэргийг шийдвэрлэдэг тул нэмэлт ачаалал ихээхэн хэмжээгээр үүсэх магадлалтай. Гэвч нөгөө талаас хуулийн төсөлд төлбөрийн чадваргүйдлийн хэрэг үүсгэхээс өмнө төлбөрийн чадваргүйдлийг тогтоох дүгнэлт гаргах үүргийг түр хэрэг гүйцэтгэгчид, зардал төлөхийг үүрэг гүйцэтгэгчид ногдуулсан нь төлбөрийн

чадваргүйдлийн маргаан болон шүүхийн ачааллыг бага ч атугай хувиар бууруулах сайн талтай юм.

Шүүхийн ачаалал

Дампуурлын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны төрөлд хамаарах боловч, дамбуурлын хэргийн онцлог шинжээс хамааран иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны ердийн журмаас нэлээд ялгаатай зохицуулалт үйлчилдэг байна. Тодруулбал, дамбуурлын хэргийг үүсгэх, хариуцагч байгууллагыг дахин зохион байгуулах ажиллагаа, хариуцагчийн хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлж, бизнесийн үйл ажиллагааг зогсоож, мөнгөн бус хөрөнгийг худалдан борлуулах замаар нэхэмжлэгчдийн шаардлагыг хангах, зарим өрийг цайруулах зэрэг ажиллагаа нь хийгдэж байна. Өнөөгийн практикт шүүх дамбуурлын хэргийг хянан шийдвэрлэх явцад олон тооны нэхэмжлэлийн шаардлагыг хамтатган шийдвэрлэж байна.

Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийн төслийн зохицуулалтаас харахад дамбуурлын хэргийн нэхэмжлэлийн шаардлагыг ерөнхийд нь

- маргаангүй буюу баталсан шаардлага;
- маргаантай шаардлага гэж ангилсан байна.

Хуулийн төслийн 40 дүгээр зүйлийн 40.1 дэх хэсэгт зааснаар маргаантай шаардлага нь нэхэмжлэлийн шаардлагыг хэрэг гүйцэтгэгч, эсхүл бусад нэхэмжлэгч нар зөвшөөрөөгүйн улмаас шаардлага батлагдаагүй байдлыг ойлгоно. Нэхэмжлэгч маргаантай шаардлагын талаар Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны журмаар шийдвэрлүүлэх эрхтэй байна. Энэхүү зохицуулалтын улмаас маргаантай шаардлага тус бүрээр иргэний хэрэг үүсэж, шүүхийн ачаалал нэмэгдэхээр байна.

Улсын Их Хурлын 2016 оны 42 дугаар тогтоолоор анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгчийн орон тоог 699 байхаар тогтоосон хэдий ч өнөөдрийн байдлаар анхан шатны шүүхэд 369, давж заалдах шатны шүүхэд 110 нийт 479 шүүгч ажиллаж байна.

2018 онд улсын хэмжээнд 48155 иргэний хэрэг шийдвэрлэсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 6.5 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Иргэний хэргийн анхан шатны шүүхүүдээс нийслэлийн 6 дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх тайлант хугацаанд нийт 25105 хэрэг шийдвэрлэсэн нь нийт иргэний хэргийн 52.1 хувийг эзэлж байна⁷.

Дээрх судалгаанаас харахад шүүхээр шийдвэрлэж байгаа хэрэг, маргаан, үйлчлүүлэгчийн тоо жил бүр өсөж байна. Төлбөрийн чадваргүйдлийн тухай хууль батлагдсанаар энэ төрлийн хэрэг маргаан өсөх, улмаар батлагдаагүй буюу маргаантай нэхэмжлэлтэй холбоотой хэргийн тоо нэмэгдэх зэргээр шүүхийн ачаалал өсөх хандлагатай байна. Иймд Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийг практикт хэрэгжүүлэхэд Иргэний хэргийн шүүхийн шүүгчийн орон тоо, ачааллыг харгалзан үзэж УИХ-аас батлагдсан орон тоогоор шүүгч ажиллуулах зайлшгүй шаардлагатай юм.

⁷ Шүүхийн ерөнхий зөвлөл, шүүн таслах ажиллганы тайлан, 2018

Төлбөрийн чадваргүйдлийн хэргийг шийдвэрлэх ажиллагаанд оролцогчдын
мэдлэг, ур чадварын хувьд:

Ихэнх улс орнууд хэрэг гүйцэтгэгч болон шүүгчид тавигдах шаардлагыг харьцангуй өндөр байхыг шаарддаг. Хэрэг гүйцэтгэгчийн үндсэн чиг үүрэг нь хариуцагчийн хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэх, хөрөнгө хуримтлуулах, хамгаалалтдаа авах, хариуцагчийн хөрөнгийн үнэ цэнийг нэмэгдүүлэх, хамгийн үр ашигтай байдлаар ашиглах зэрэг болно. Хэрэг гүйцэтгэгчээс эдгээр үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд олон төрлийн мэдлэг, ур чадвар шаардагдах нь тодорхой юм. Тухайлбал, хэрэг гүйцэтгэгч санхүү, эрх зүйгээр мэргэшсэн байхын зэрэгцээ мэргэжлийн ёс зүйтэй, үнэнч шударга, удирдан зохион байгуулах чадвартай, хэргийн оролцогч нартай ашиг сонирхлын зөрчилгүй байх ёстой юм. Учир нь хэрэг гүйцэтгэгч нь төлбөрийн чадваргүй аж ахуйн нэгжийг төлөөлөх, хөрөнгийг худалдах, борлуулах, хуваарилах, хамгаалахтай холбоотой бүх арга хэмжээг авах үүрэгтэй юм. Түүнчлэн шаардлагатай бол хариуцагчийг дахин зохион байгуулах, хөрөнгөжүүлэх ажиллагааны төлөвлөгөө гаргаж, түүнийг зохион байгуулахад санхүүгийн болон ёс зүйн өндөр ур чадвар шаардлагатай нь тодорхой. Хэрэг гүйцэтгэгчийн гүйцэтгэсэн дээрх үйл ажиллагааг бүхэлд нь хянаж, төлбөрийн чадваргүйдлийн хэргийг шийдвэрлэх чиг үүрэг бүхий шүүгчийн мэдлэг, ур чадвар ч өндөр байх шаардлагатай.

Гэтэл өнөөгийн практикт дампуурлын хэргийг шийдвэрлэж буй шүүгч болон хэрэг гүйцэтгэгчийн тоо бага, санхүүгийн мэдлэг болон бусад ур чадвар хангалтгүй байгаа нь нууц биш. Тиймээс Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийн төсөл батлагдвал хэрэг гүйцэтгэгч болон шүүгч нарыг давтан сургах, хөтөлбөрийн дагуу тодорхой давтамжтай, ахисан шатны сургалтад хамруулах шаардлагатай байна.

Шүүхийн цахим систем

Иргэний хэргийн анхан болон давж заалдах, хяналтын шатны шүүхийн нэгдсэн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны “Иргэн 2014” нэгдсэн систем ажилладаг. Энэхүү системийн дагуу иргэний хэрэг үүсгэх, хэрэг нэгтгэх, тусгаарлах, шүүх хурал хойшлох, шүүгчийн захирамж, шүүхийн шийдвэр гаргах, шийдвэрийг цахим санд илгээх зэрэг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бүхий л үе шат, үйлдлүүд хийгддэг. Иймд иргэний хэргийн шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанаас өөр зарчим, процессын дагуу шийдвэрлэгдэх төлбөрийн чадваргүйдлийн хэргийг энэхүү системийн дагуу хянах боломжгүй юм. Тиймээс дампуурлын хэргийг хянах цахим мэдээллийн систем бий болгох шаардлагатай байна.

Дампуурлын хэргийг хянах цахим мэдээллийн систем бий болгох, түүний бүртгэлийг хөтлөх, лавлагаа, мэдээлэл авах журмыг боловсруулах ажлыг хуулийн төсөлтэй нэгэн зэрэг гүйцэтгэх нь зүйтэй юм. Одоогийн ачааллаа даахгүй шахам ажиллаж байгаа шүүхийн тогтолцоо, цахим системийг өөрчлөхгүйгээр томоохон хэмжээний нэмэлт үүрэг оноох нь төлбөрийн чадваргүйдлийн хэрэг хялбар, маргаангүй үүсэх, нээлттэй хийгээд түргэн шуурхай байх төслийн үндсэн зорилготой нийцэхгүй нь тодорхой

Хэрэг гүйцэтгэгчийн хувьд хүний нөөц хомс, хязгаарлагдмал байгаа талаар өмнөх хэсэгт дурдсан билээ. Хуулийн төсөл батлагдсанаар төлбөрийн чадваргүйдлийн маргаан ихсэх магадлалтай тул хэрэг гүйцэтгэгчээр ажиллах хүний нөөцийг нэмэгдүүлэх шаардлагатай. Хэдийгээр төлбөрийн чадваргүйдлийн хэрэг

цөөн тоогоор гардаг боловч хүний нөөцийг нэмэгдүүлэхгүй байх нь нэг хэрэг гүйцэтгэгчид ногдох ачааллыг нэмэгдүүлж, улмаар хуульд заасан хугацаанд хариуцагчийн санхүүгийн байдлын талаар дүгнэлт гаргаагүйн улмаас хэрэг сунжрах үндэслэл болдог байна. Хэрэг гүйцэтгэгч хуульд заасан хугацаанд дүгнэлт гаргаагүй тохиолдолд авах арга хэмжээ болон хариуцлагын асуудал тодорхойгүй байна.

Өөрөөр хэлбэл, Хуулийн төслийн 36 дугаар зүйлийн 36.1-д Хэрэг гүйцэтгэгчийн санаатай, илтэд болгоомжгүй үйлдэл, эс үйлдэхүйн улмаас төлбөрийн чадваргүйдлийн хэргийн оролцогчид хохирол учирсан бол хохирлыг хэрэг гүйцэтгэгч хувийн хөрөнгөөрөө хариуцна, 36.2-д Энэ хуулийн 36.1-д заасан үр дагавар үүсээгүй боловч үүргээ зохих ёсоор биелүүлээгүй нь хэрэг гүйцэтгэгчийг үүрэгт ажлаас нь чөлөөлөх үндэслэл болно гэж хэрэг гүйцэтгэгчид ногдуулах хариуцлагыг тусгасан нь практикт тулгарч буй хүндрэлийг шийдвэрлэхэд ач холбогдолтой байж чадахааргүй байна.

2.4. Шалгуур үзүүлэлт: Зардал

Хуулийн төслийн үр нөлөө тооцох судалгааны зардлын тооцооллын шалгуур үзүүлэлтийг бүтэц, томъёоллын онцлогоос нь шалтгаалан тус ажлын хавсралт хэлбэрээр хийсэн болно. Зардлын тооцооллыг хавсралт 1-ээс харна уу.

2.5. Шалгуур үзүүлэлт: Харилцан уялдаа

Энэ шалгуур үзүүлэлтийн хүрээнд дараах хоёр дэд ангиллаар хууль тогтоомжийн харилцан уялдааг судлах нь зүйтэй гэж үзлээ. Үүнд:

- 2.5.1. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуультай харилцан уялдсан байдал
- 2.5.2. Бусад хууль тогтоомжтой харилцан уялдсан байдал
- 2.5.3. Олон улсын эрх зүйн хүрээнд харилцан уялдсан байдал буюу Үндэстэн дамнасан төлбөрийн чадваргүйдлийн загвар хууль

2.5.1. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуультай харилцан уялдсан байдал.

Энэ шалгуур үзүүлэлтийн хүрээнд уг хуулийн төслийн зүйл, заалт өөр хоорондоо болон Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуультай нийцсэн, зохицуулалт давхардсан эсэхийг судалж, дараах хүснэгтээр харуулахыг зорилоо.

	Шалгах асуултууд	Тайлбар, санал
1	Хуулийн төслийн зохицуулалт тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх?	Нийцэж байна.
2	Хуулийн төслийн “хууль тогтоомж” гэсэн хэсэгт заасан хуулиудын нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх?	Хамаарч байна.
3	Хуулийн төсөлд тодорхойлсон нэр томъёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томъёотой нийцэж байгаа эсэх?	Хуулийн төслийн 4.1.2, 5.1, 8.4, 26.1.5, 26.8, 35.3, 37.2.1 гэх мэт 39 зүйл, заалтад “нэхэмжлэгч”,

*Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийн төслийн
үр нөлөө тооцох судалгааны тайлан*

	4.1.3, 5.1, 6., 7, 8.1 гэх мэт 84 зүйл, заалтад “хариуцагч”, 14.2, 16.1, 20.1, 20.2 гэх мэт 34 зүйл, заалтад “үүрэг гүйцэтгэгч”, 14.1, 15.1, 20.1, 20.2 гэх мэт 29 зүйл, заалтад “үүрэг гүйцэтгүүлэгч”, 4.1.4, 8.2, 8.4, 9.1, 9.2, 18.1.1, 18.1.4, 18.3, 19.1, 19.2, 19.4, 20.5, 21.7, 25.3, 25.4, 25.6, 26.1.4, 26.4, 26.5, 26.7, 84.1.4, 84.3, 96.4 гэсэн зүйл, заалтуудад “хүсэлт гаргагч”, 10.4, 38.5, 39.4, 76.6, 78.2, 85.1 гэсэн зүйл, заалтад “хэргийн оролцогч”, 11.1, 20.3, 76.5, 85.5, 88.4 гэсэн зүйл, заалтад “холбогдох этгээд” 8.4, 120.2.1, 126.4.2, 126.4.3, 127.1, 127.2, 128.2.1, 128.4 гэсэн зүйл, заалтад “гуравдагч этгээд”, 86 дугаар зүйл, 95.2 гэсэн зүйл, заалтад “маргаантай шаардлагын нэхэмжлэгч”, 23.3-т “сонирхогч бусад этгээд”, 38.2, 49.1, 99.1.2, 106.1 гэсэн зүйл, заалтад “энгийн нэхэмжлэгч”, 38.2, 49.2, 49.3, 55.4, 80.2, 80.7, 95.2, 99.1.1, 100.2, 100.3, 104.7, 104.8, 106.2, 106.3, 106.4 гэсэн зүйл, заалтад “барьцаат нэхэмжлэгч”, 38.2, 49.4, 55.3, 83.4, 84.2, 99.1.3, 100.4, 100.5, 108.1 гэсэн зүйл, заалтад “доод эрэмбийн нэхэмжлэгч”, 49.3 гэсэн зүйлд “саналын эрхтэй бусад нэхэмжлэгч” гэсэн нэр томъёонууд тусгагджээ. Дурдсан нэр томъёонууд нь төлбөрийн чадваргүйдлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад холилдсон, давхардсан, ойлгомжгүй байдлаар тусгагдсан гэж үзэхээр байна. Жишээ нь: 18 дугаар зүйлд заасан хүсэлт гаргагч нь 14.1, 14.3-т заасан үүрэг гүйцэтгүүлэгч, үүрэг гүйцэтгэгчийн хэн аль нь байхаар ойлгогдож байна. Гэтэл 18.1.6, 18.1.7-д “хариуцагч” гэж заасан нь нэр томъёоны хувьд тодорхойгүй байдлыг үүсгэжээ. Мөн 26 дугаар зүйлд зааснаар шүүхээс төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаа эхлүүлэх захирамж гаргаж, нийтэд мэдээлсний дараа 37 дугаар зүйлд зааснаар төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаанд нэхэмжлэл гарган орж ирж байгаа үүрэг гүйцэтгүүлэгч нь 4.1.2-т заасан нэхэмжлэгч мөн эсэх, эсхүл тусдаа нэр томъёо хэрэглэгдэх эсэх. Хэрвээ үүрэг гүйцэтгүүлэгч 14.1-д зааснаар төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаа
--	--

		эхлүүлэх хүсэлт гаргасан бол тэр үүрэг гүйцэтгүүлэгчийг нэхэмжлэгч гэх үү. Хэрвээ 14.2-т зааснаар үүрэг гүйцэтгэгч төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаа эхлүүлэх хүсэлт гаргасан бол түүнийг хариуцагч гэх үү, нэхэмжлэгч гэх үү, хүсэлт гаргагч гэх үү. Мөн “холбогдох этгээд”, “холбогдох байгууллага”, “сонирхогч бусад этгээд”, “гуравдагч этгээд” гэдэгт ямар субъект, хэн байх вэ гэх мэтээр ойлгомжгүй, тодорхойгүй, хэрэглэхэд хүндрэлтэй байдлыг бий болгож байна. Иймд зөрүүтэй ойлгогдож байгаа нэр томъёо буюу үүргийн гүйцэтгэлийг шаардах эрх бүхий этгээд /үүрэг гүйцэтгэх этгээд/ нь төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааны аль үе шатанд үүрэг гүйцэтгүүлэгч /үүрэг гүйцэтгэгч/, аль үе шатанд нэхэмжлэгч /хариуцагч/, аль үе шатанд хүсэлт гаргагч, аль үе шатанд хэргийн оролцогч гэсэн нэршилтэй байхыг 4.1-д заасан нэр томъёоны тодорхойлолтын хэсэгт тус бүр нарийвчлан ялган зааглаж тодорхойлон ойлголтын зөрүүг арилгах. Ингэснээр хуулийг хэрэгжүүлэх, хэрэглэх субъектэд дурдсан нэр томъёонууд ойлгомжтой, нэг мөр хэрэгжих боломжтой болно. 15.2.2-т хүсэлт гаргагч, 16.2.2-т хуулийн этгээд гэж томъёолсон нь зөрүүтэй гэж харагдахаар байх тул “хуулийн этгээд” гэдгийг “хүсэлт гаргагч” гэж өөрчлөх нь нэр томъёог нэг мөр ойлгоход ач холбогдолтой. Өөрөөр хэлбэл төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаа эхлүүлэх хүсэлтийг үүрэг гүйцэтгүүлэгч, үүрэг гүйцэтгэгчийн хэн алин нь гаргахаар хуулийн төслийн 15, 16 дугаар зүйлд заасан байхад 16.2.2-т “хуулийн этгээдийн” гэж заасан нь ойлгомжгүй байна. 46.3-д ... шүүхээс дампуурлын ажиллагааг эхлүүлээгүй бол ...ердийн журмаар гэрээгээр тохиролцсоны дагуу хүү тооцно, 46.7-д ...дампуурлын ажиллагааг зогсоох..., 50.1.3-т хариуцагчийн дампуурлыг зарлах..., 110.7-д ...хуулийн этгээдийг дампуурсанд тооцож, татан буулгах шийдвэр гаргана, 114.1-д ...дампуурлын ажиллагаанд шилжих хүсэлтийг шүүхэд гаргана гэжээ.
--	--	---

*Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийн төслийн
үр нөлөө тооцох судалгааны тайлан*

		Эдгээр заалтын “дампуурлын ажиллагаа эхлүүлээгүй”, “дампуурлын ажиллагааг зогсоох”, “дампуурлыг зарлах”, “дампуурсанд тооцож”, “дампуурлын ажиллагаанд шилжих...” гэдэг нэр томъёонууд нь төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаа эхлүүлэх, зогсоох, зарлах, “төлбөрийн чадваргүйд тооцох, төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаанд шилжих” гэдэг нэр томъёо болон хуулийн зорилттой зөрчилдөж байгаа учир нэр томъёог хооронд нийцүүлж зөвтгөх. 49.2-т ...ХГ-ийн... гэсэн товчилсон үсэг байх бөгөөд энэ нь хэрэг гүйцэтгэгч гэсэн нэр томъёотой нийцэхгүй байна. Иймд товчилсон нэрийг бүтэн үгээр зөвтгөх. 57 дугаар зүйлд заасан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд эрх залгамжлах гэсэн нэр томъёо нь хуулийн төслийн 28.1.3-т заасан хэрэг гүйцэтгэгчийн эрх, үүрэгтэй нийцэхгүй байна. Учир нь хэрэг гүйцэтгэгч нь хариуцагчийг эрх залгамжлах бус харин бүрэн төлөөлж байгаа ойлголт байна. Иймд “эрх залгамжлах” гэсэн нэр томъёог “төлөөлөх” гэж өөрчлөх нь зүйтэй байна. Хуулийн төслийн 10 дугаар бүлгийн 1 дүгээр дэд бүлгийн гарчигт “дахин зохион байгуулах төлөвлөгөө, түүнийг боловсруулах” гэсэн байхад 2 дугаар дэд бүлгийн гарчигт “дахин хөрөнгөжүүлэлтийн төлөвлөгөөг батлах” гэж нэр томъёоны хувьд зөрүүтэй зохицуулжээ. Иймд нэр томъёог зөвтгөн нэг мөр болгох.
4	Хуулийн төслийн зүйл заалт тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх?	Хуулийн төслийн 18.1.6, 18.1.7 нь 16.3.7-той уялдах шаардлагатай бөгөөд 16.3.7-д 18.1.7-д заасан мөрдөн шалгах ажиллагаа явуулж байгаа байгууллагыг гэж нэмж тусгах ёстойг орхигдуулжээ. Хуулийн төслийн 20 дугаар зүйлийг 21 дүгээр зүйл, 21 дүгээр зүйлийг 20 дугаар зүйл болгон өөрчилж зохицуулбал логикийн хувьд дэс дараалалтай болохоор байна. Жишээ нь: 20 дугаар зүйл түр хэрэг гүйцэтгэгчээр хүсэлтийг гардуулах ажиллагаа хийлгэх, 21 дүгээр зүйлд нь түр хэрэг гүйцэтгэгчийг томилох зохицуулалт тусгагдсан. Өөрөөр хэлбэл түр хэрэг гүйцэтгэгч томилогдоогүй байхад түүгээр хүсэлт гардуулах ажиллагаа хийлгэх нь дарааллын хувьд зөрчилтэй гэж харагдахаар байна. Үүрэг гүйцэтгүүлэгч, үүрэг гүйцэтгэгч нарын хэн аль нь хүсэлтийг гаргах эрхтэй бөгөөд гаргасан хүсэлтийг нь шүүх хэн алинд нь

*Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийн төслийн
үр нөлөө тооцох судалгааны тайлан*

		гардуулах ажиллагаа явуулах нь талуудын зарчимд нийцнэ. Гэтэл дээрх заалтуудад үүрэг гүйцэтгэгчид гардуулаад, үүрэг гүйцэтгүүлэгчид хүргүүлэхээр ялгаатай заасан нь учир дутагдалтай болжээ. Эсхүл 20.1, 20.2-т заасан хүсэлтүүдийг хэрэг гүйцэтгэгч хэн алинд нь гардуулах ажиллагаа явуулж, шүүх түүнд хяналт тавихаар 20.3 дахь заалтыг өөрчлөн найруулж, 20.4 дүгээр заалтыг хасах нь зүйтэй.
5	Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан эсэх?	72.1, 72.5 агуулгын хувьд давхцаж байх тул нэгтгэн нэг заалт болгох боломжтой байна. Өөрөөр хэлбэл уг хоёр заалтаар төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаа эхлүүлсэн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаа хоёр зэрэгцэн явагдах боломжтойг харуулж байна. 18.1.7, 23.3, 32.2, 10 дугаар бүлэг тус бүр давхардан дугаарлагдсан байгааг засах 26.1.4-т шүүх төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаа эхлүүлэх захирамжиндаа хэрэг гүйцэтгэгчийн нэрийг тодорхой заахаар тусгасан ба, 26.3, 30.1-д зааснаар хэрэг гүйцэтгэгчийг томилохоор зохицуулжээ. Энэ нь хоорондоо давхардсан агуулгатай харагдаж байх тул 26.1.4-т хэрэг гүйцэтгэгчийг томилж, нэр заах гэсэн агуулгаар өөрчлөн найруулах. 21.7, 26.4 дэх заалтууд агуулгын хувьд давхардсан байна. Өөрөөр хэлбэл төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаа эхлүүлэх хүсэлтийг шийдвэрлэсэн шүүгчийн захирамжийг 21.7-д хүсэлт гаргагч, хариуцагчид хүргүүлнэ гэж, харин 26.4-д мөн хүсэлт гаргагч, хариуцагч, бусад этгээдэд хүргүүлнэ гэжээ. Тиймээс уг хоёр заалтыг нэгтгэн найруулж өөрчлөх. 36.2-т хэрэг гүйцэтгэгч үүргээ зохих ёсоор биелүүлээгүй нь, 32.1.2-т хэрэг гүйцэтгэгч үүргээ ноцтой зөрчсөн нь түүнийг үүрэгт ажлаас нь чөлөөлөх үндэслэл болохоор заасан нь агуулгын хувьд давхардаж байгаа учир нэг мөр болгон өөрчлөн найруулах. Хуулийн төслийн 102.2-т төлөвлөгөөг хүргүүлсэн этгээд төлөвлөгөөг батлахаас татгалзсан тухай шүүгчийн захирамжинд гомдол гаргах эрхтэй гэсэн нь 110.6-д заасан

	төлөвлөгөөг баталсан, эсхүл батлахаас татгалзсан шийдвэрт нэхэмжлэгч, хариуцагч энэ хуульд заасан журмаар гомдол гаргах эрхтэй гэсэн заалттай агуулгын хувьд давхардсан харагдаж байна. Өөрөөр хэлбэл төлөвлөгөөг батлахаас татгалзсан гэсэн ойлголт нь давхцсан буюу 102.2-т заасан төлөвлөгөөг батлахаас татгалзсан тухай шүүгчийн захирамж, 110.6-д заасан төлөвлөгөөг батлахаас татгалзсан шийдвэр нь ялгаатай эсэх нь тодорхойгүй байх тул дээрх 2 заалтыг харьцуулан өөрчилж найруулан заах, Хуулийн төслийн 104.3-т төлөвлөгөөг хэлэлцэх хурлын зар, төлөвлөгөөний хувь, хураангуйг хүргүүлнэ гэж заасан байхад 110.5-д төлөвлөгөөг баталсан бол төлөвлөгөөний нэг хувь, үндсэн агуулгын хураангуйг шаардлага гаргасан нэхэмжлэгчид хүргүүлнэ гэж заасан зохицуулалтууд нь хоорондоо ялгаатай эсэх нь тодорхойгүй, давхардсан агуулгатай харагдаж байна. Иймд өөрчлөн найруулах. Хуулийн төсөл болон Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль (цаашид ИХШХШТХ гэж товчилно) - ийг хороонд нь харьцуулбал: 1. Хуулийн төслийн 4.1.6-д заасан төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааны зардал нь ИХШХШТХ-ийн 52.1-д заасан шүүхийн зардалтай, 2. Хуулийн төслийн 7.2-т заасан хариуцагчийн мөнгөн төлбөрийн үүргийг тодорхойлох, 43 дугаар зүйлд заасан шаардлагын дүнг тодорхойлох нь ИХШХШТХ-ийн 63 дугаар зүйлд заасан нэхэмжлэлийн үнийг тодорхойлохтой, 3. Хуулийн төслийн 9.1-д заасан Улсын тэмдэгтийн хураамж төлөх нь ИХШХШТХ-ийн 57 дугаар зүйлд заасан улсын тэмдэгтийн хураамжтай, 4. Хуулийн төслийн 11 дүгээр зүйлд заасан төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаанд гомдол гаргах нь ИХШХШТХ-ийн 170 дугаар зүйлд заасан шүүхийн тогтоол, шүүгчийн захирамж, шийтгэвэрт гомдол гаргах, 171 дүгээр зүйлд заасан гаргасан гомдлыг хянан шийдвэрлэхтэй, 5. Хуулийн төслийн 13 дугаар зүйлд заасан төлбөрийн чадваргүйдлийн хэргийг хянан шийдвэрлэх шүүхийн харьяалал нь ИХШХШТХ-ийн 14.2-т
--	--

*Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийн төслийн
үр нөлөө тооцох судалгааны тайлан*

		заасан нэхэмжлэлийг хариуцагчийн оршин суугаа (оршин байгаа) нутаг дэвсгэрийн харьяаллаар гаргахтай, 6. Хуулийн төслийн 15 дугаар зүйлд заасан үүрэг гүйцэтгүүлэгчийн хүсэлтийн хэлбэр, агуулга, 16 дугаар зүйлд заасан үүрэг гүйцэтгэгчийн хүсэлтийн хэлбэр, агуулга нь ИХШХШТХ-ийн 61 дүгээр зүйлд заасан нэхэмжлэлийн хэлбэр, 62 дугаар зүйлд заасан нэхэмжлэлийн бүрдүүлбэртэй, 7. Хуулийн төслийн 18 дугаар зүйлд заасан шүүх хүсэлтийг хүлээн авахаас татгалзах нь ИХШХШТХ-ийн 65 дугаар зүйлд заасан нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзахтай, 8. Хуулийн төслийн 21.2-т заасан албадлагын арга хэмжээ нь ИХШХШТХ-ийн 69 дүгээр зүйлд заасан шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээ авахтай, 9. Хуулийн төслийн 23 дугаар зүйлд заасан төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааны зардлын талаарх дүгнэлтийн улмаас үүсэх үр дагавар гэсэн хэсгийн 23.1-т “...хэргийг хэрэгсэхгүй болгоно”, 113 дугаар зүйлд заасан дахин зохион байгуулах ажиллагааг дуусгавар болгох гэсэн хэсгийн 113.2-т “...хэргийг хэрэгсэхгүй болгоно” гэдэг нь ИХШХШТХ-ийн 117 дугаар зүйлд заасан хэргийг хэрэгсэхгүй болгох зохицуулалттай тус тус агуулгын хувьд давхардсан буюу ижил төстэй байна. Дээрхээс үзвэл дурдсан заалтууд хоорондоо агуулгын хувьд давхардсан, ижил төстэй байх боловч хуулийн төслийн 11.5, 18.4, 21.4-д ИХШХШТХ хамаарахгүй гэж заасан нь төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаа иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас өөр, тусдаа бие даасан ажиллагаа гэж ойлгогдож байна. Иймд ИХШХШТХ-ийн 133.1.10-т заасан хуулийн этгээдийг дампуурсан тооцох хүсэлтийг шүүх онцгой ажиллагааны журмаар шийдвэрлэх тухай, 155¹ дугаар зүйлд заасан хуулийн этгээдийг дампуурсанд тооцох тухай хүсэлт гаргах, түүнийг хянан шийдвэрлэх тухай зүйл, заалтуудыг тус хуулиас хасах шаардлага бий болж байна. ИХШХШТХ-ийн дээрх заалтаар дампуурлын хэргийг онцгой ажиллагааны журмаар
--	--	---

*Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийн төслийн
үр нөлөө тооцох судалгааны тайлан*

		шийдвэрлэж байсан бол шинэ хуулийн төслөөр хэрэг хянан шийдвэрлэх ердийн болон онцгой ажиллагааны журам зэрэгцэн хэрэгжих байдалтай байх боловч төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаа нь нарийвчилсан, онцлог, тусгай, бие даасан журмаар хэрэгжих зайлшгүй шаардлагатай байгаа нь харагдлаа. Түүнчлэн төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааг хянан шийдвэрлэх хугацаа байхгүй, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэх үндэслэл байхгүй байгаа зэрэг нь ИХШХША-наас ялгаатай журам хэрэгжинэ гэж ойлгогдож байна.
6	Хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх?	Хэрэг гүйцэтгэгч, шүүх гэдгийг тодорхой тусгасан байх боловч зарим заалтад хэн хэрэгжүүлэх нь харагдахгүй байна. Жишээ нь: 10.1-д нийтэд хэн мэдээлэх вэ, 20.2-т хүсэлтийг хэн хүргүүлэх вэ, 24.2-т захирамжийг хэн хүчингүй болгох вэ, 34.3-т хэрэг гүйцэтгэгчид ажлын хөлс олгосон шүүгчийн захирамжийг хэн хэргийн оролцогчдод гардуулах нь ойлгомжгүй, 35.1-д хэрэг гүйцэтгэгч хэнтэй тооцоо нийлэх вэ, 36.2-т хэрэг гүйцэтгэгчийг хэн чөлөөлөх вэ, 40.2-т хэрэг гүйцэтгэгч мэдэгдлийг хэнд хүргүүлэх нь тодорхойгүй, 41.5-д баталгаажуулах хурлыг хэн зарлан хуралдуулж, ажиллагаа хийх нь тодорхойгүй, 58.2-т ажиллагааг хэн түдгэлзүүлэх вэ, 97.1-д шийдвэрийн талаар хэн нийтэд мэдээлэх вэ, 104.3-т хурлын тов, төлөвлөгөөг хэнд хүргүүлэх, түүнчлэн төлөвлөгөөний гол агуулгын хураангуйг хэн хийх нь тодорхойгүй, 106.3-т заасан гомдлыг хэн гаргах вэ гэх мэт...
7	Хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх?	Хуулийн төслийн 15.3.4-т үүрэг гүйцэтгүүлэгчээс гаргаж байгаа хүсэлтийн бүрдүүлбэрт улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт, эсхүл уг хураамжаас чөлөөлүүлэх, хөнгөлүүлэх, хэсэгчлэн төлөх, төлөх хугацааг хойшлуулах хүсэлтийг хавсаргахаар заасан атлаа 16 дугаар зүйлд заасан үүрэг гүйцэтгэгчээс гаргасан хүсэлтийн бүрдүүлбэрт уг заалт орхигдсон байна. Түүнчлэн шүүх ямар үндэслэлээр улсын тэмдэгтийн хураамжаас чөлөөлөх, хөнгөлөх хэсэгчлэн төлүүлэх, хойшлуулах үндэслэл тодорхойгүй, энэ талаарх зохицуулалт орхигджээ. 16.3.7, 21.2.3-т ..."мөрдөн шалгах байгууллага" гэж нэмж оруулах. Тодруулбал эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх журмаар шалгагдаж байгаа хэргийн талаарх мэдээлэл хамаарна.

	18.3, 21.3, 26.7, 32.3 (32.4), 32.4 (32.5), 39.7, 50.1.9, 51.9, 62.6, 85.4 (..шүүхэд гаргана гэснийг тухайн шүүгчид гэж тодруулах), 85.5, 86.1, 88.4, 92.7, 97.3, 102.2, 106.3, 110.6 /шийдвэрт гэдгийг шүүгчийн захирамж гэж өөрчлөх/, 128.3, 128.4 гэсэн зүйл, заалтуудад заасан шүүгчийн захирамж болон хэрэг гүйцэтгэгчийн үйл ажиллагаанд гомдол гаргах эрхтэй гэж заасан байх боловч ямар хугацаанд, хаана гомдол гаргах нь тодорхойгүй, орхигдсон байна. Тиймээс уг зүйл, заалтуудыг 11.2-т заасан журмаар гомдол гаргах гэж тодруулж найруулах, 21.5 /гардуулах гэдгийг танилцуулах гэж өөрчлөх/, 24.1, 26.6, 83.8, 85.2, 86.1, 92.6, 93.6 (...гардуулна гэдгийг танилцуулна гэж өөрчлөх), 96.1, 97.1, 104.1, 114.3, 128.4 гэсэн зүйл, заалтуудад ямар хугацаанд, ямар журмаар нийтэд мэдээлэх нь тодорхойгүй байх тул 10.1-д заасан журмаар нийтэд мэдээлнэ гэж нэмж оруулах, 18 дугаар зүйлд зааснаар хүсэлтийг хүлээн авахаас татгалзсан, 23.1, 25.6, 113.2-д зааснаар хэргийг хэрэгсэхгүй болгон шүүх шийдвэрлэсэн үед улсын тэмдэгтийн хураамжийг хэрхэн шийдвэрлэх зохицуулалт орхигдсон. Өөрөөр хэлбэл улсын тэмдэгтийн хураамж нь төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаа эхлүүлэх хүсэлт гаргахад бүрдүүлэх баримтын нэг байгаа бөгөөд уг заалтаар урьдчилсан төлбөрийг буцаан олгохоор заасантай адилаар улсын тэмдэгтийн хураамжийн асуудлыг ч мөн адил зохицуулах шаардлагатай. 27.4-т зааснаар хэрэг гүйцэтгэгчид ашиг сонирхлын зөрчил үүссэн тохиолдолд ажиллагаанаас өөрөө татгалзан гарах, эсхүл хэргийн оролцогч татгалзан гаргах эрх, мөн үүнийг хэрхэн, хэн шийдвэрлэх зохицуулалт, түүнчлэн хэрэг гүйцэтгэгч нь хуулийн 28 дугаар зүйлд заасан эрх, үүргээ хэрэгжүүлэхдээ ямар эрхийн акт гаргах нь тодорхойгүй, орхигдсон байх тул энэ талаар нэмж оруулах, Жишээлбэл, хэрэг гүйцэтгэгчийн томилсон шинжээчийн дүгнэлтийн талаар хэргийн оролцогч гомдол гаргах тохиолдолд хэрхэн, хаана, ямар журмаар гаргах, хэн шийдвэрлэх талаар зохицуулалт байхгүй байна. Мөн 28.3-т ИХШХШТХ-ийн 47.1 хамаарахгүй гэж нэмэх. Өөрөөр хэлбэл хэрэг гүйцэтгэгч
--	---

*Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийн төслийн
үр нөлөө тооцох судалгааны тайлан*

		тухайн чиглэлээр мэргэшсэн шинжээч ажиллуулах ажиллагаанд шүүхээс ямар нэгэн ажиллагаа явуулахгүй гэж ойлгоно. Хуулийн 5.1-д заасан хэрэг гүйцэтгэгчээс бусад хэргийн оролцогч болох нэхэмжлэгч, хариуцагч, үүрэг гүйцэтгүүлэгч, үүрэг гүйцэтгэгч, хүсэлт гаргагч, гуравдагч этгээдийн эрх, үүргийг хуулийн 28 дугаар зүйлд заасан хэрэг гүйцэтгэгчийн эрх, үүргийн нэгэн адил тусгайлсан зүйл, заалтаар тодорхойлж заах шаардлагатай. Жишээлбэл, төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааны явцад дээрх субъектүүд ямар эрхийг эдэлж, үүргийг хэрэгжүүлэх нь тодорхойгүй. Өөрөөр хэлбэл зарим зүйл, заалтад эрх, үүрэг тусгагдсан байх боловч хэргийн оролцогч нь хэргийн материал танилцах, шүүхэд санал, хүсэлт гаргах, өмгөөлөгч авах, давж заалдах, шүүхийн дуудсанаар хүрэлцэн ирэх, шүүхийн тавьсан шаардлагыг биелүүлэх, шүүхэд үнэн зөв тайлбар гаргах гэх мэт ИХШХШТХ-д хэргийн оролцогчдын эрх, үүргийг заасантай адил байдлаар хуульд нэрлэн заах нь тухайн хуулийн төслийг хэрэгжүүлж, хэрэглэхэд ач холбогдолтой байна. 37.2-т заасан нэхэмжлэлийн шаардлагын хэлбэр, агуулгын талаар тодорхой заагаагүй, уг нэхэмжлэлтэй холбоотой шүүх ямар ажиллагаа хийх, хүлээн авсан нэхэмжлэлийн шаардлагыг хариуцагчид ямар хугацаанд гардуулах, эсэх талаарх зохицуулалт орхигдсон. Мөн уг нэхэмжлэлийн шаардлага бүрдүүлбэр хангаагүй бол шүүх ямар хугацаанд хэрхэн шийдвэрлэх нь тодорхойгүй үлджээ. 120.2.2-т заасан мэргэжилтнээс хараат бус аудиторыг томилон ажиллуулах хүсэлтийг хэнд гаргах, хэрхэн шийдвэрлэх, шийдвэрлэсэн эрхийн актад гомдол гаргах эсэх нь тодорхойгүй, орхигдсон байна. Хуулийн төслийн 13 дугаар зүйлд шүүхийн харьяаллыг тодорхойлж, хүсэлтийг хариуцагчийн оршин байгаа газрын шүүх шийдвэрлэнэ гэсэн. Хуулийн төслийн 15 дугаар зүйлд үүрэг гүйцэтгүүлэгч буюу нэхэмжлэгч нь хүсэлтийг гаргахдаа хариуцагчийн оршин байгаа газрыг тодорхой заахыг хүсэлтийн бүрдүүлбэр болгон зохицуулсан. Энэ байдлаас үзвэл хүсэлт гаргагчийн тодорхойлсон хариуцагчийн хаяг
--	--	--

*Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийн төслийн
үр нөлөө тооцох судалгааны тайлан*

		тухайн шүүхэд хамаарахгүй байх тохиолдол үүсвэл энэ тохиолдолд шүүх хэргийг харьяаллын дагуу шилжүүлэх зохицуулалт байхгүй, орхигдсон байна. Иймд энэ талаарх зохицуулалт шаардлагатай байна гэж үзлээ. - Хуулийн төсөлд төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаанд хэргийн оролцогчийг төлөөлөх, уг ажиллагаанд орчуулагч, хэлмэрч, гэрч, шинжээч зэрэг бусад оролцогч хэрхэн оролцох зохицуулалт мөн орхигдсон байна. - Шүүх хуралдаан даргалагчийн эрх, үүрэг, шүүх хуралдааны нийтлэг журам, шүүгчийг татгалзан гаргах, түүний үр дагавар, шүүх хуралдааны тэмдэглэл хөтлөх, шүүхийн шийдвэр, түүний агуулга ямар байх зохицуулалт орхигджээ. - Шүүхийн шийдвэрийг хэргийн оролцогчдод гардуулах хугацаа тодорхойгүй, үүнтэй холбоотой шүүхийн шийдвэрт давж заалдах болон хяналтын журмаар гомдол гаргах, улсын тэмдэгтийн хураамж, шүүхийн зардлыг хэрхэн хуваарилах зохицуулалт орхигдсон байна. - Төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааны хэргийн нотлох баримт, түүнд тавигдах шаардлага, нотлох баримт гаргах, бүрдүүлэх, цуглуулах, үнэлэх журмын талаар хуулийн төсөлд тусгайлан заагаагүй орхигдуулсан харагдаж байна. - Хуулийн төслийн 110.7-д зааснаар хэргийг эцэслэн шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрт хэргийн оролцогчид шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг дахин хянуулах хүсэлт гаргах эрхийг зохицуулах нь зүйтэй. Иймд дээрх орхигдсон зүйлсийг нэмж оруулах,
8	Хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх?	Чиг үүрэг давхардуулсан зүйл байхгүй
9	Төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх боломжтой эсэх	Боломжгүй
10	Татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх	Албан татвар, хураамж, төлбөр тогтоосон зүйл байхгүй.
11	Тухайн хуулийн төсөлд тусгасан тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалтыг аж ахуйн үйл	27, 29 дүгээр зүйлд зааснаар хэрэг гүйцэтгэгчийн үйл ажиллагаа эрхлэх эрхийг хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас олгоно. Энэ

*Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийн төслийн
үр нөлөө тооцох судалгааны тайлан*

	ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд тусгасан эсэх?	талаар Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15 дугаар зүйлд тусгаагүй тул уг хуульд нэмж оруулах
12	Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгасан эсэх?	62.1-д шүүх хариуцагчийн үйл ажиллагааг хянах, нэхэмжлэгчид ашиггүй хэлцэл байгуулахаас урьдчилан сэргийлэх зорилгоор хэрэг гүйцэтгэгчийн хүсэлтээр, эсхүл өөрийн санаачилгаар хариуцагчийн зарим, эсхүл бүх захидал, цахим шууданг хэрэг гүйцэтгэгч хүлээн авч байх тухай захирамж гаргаж болно гэжээ. Энэ заалт Монгол улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 13, Хувь хүний нууцын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1.1, 2.1, 5 дугаар зүйл, Байгууллагын нууцын тухай хуулийн 2, 4 дүгээр зүйлд заасантай нийцэхгүй байна гэж үзлээ. Өөрөөр хэлбэл бусдын хуулиар хамгаалагдсан захидал, харилцааны нууцыг хэрэг гүйцэтгэгч мэдэж, захидлыг хүлээн авч байх бололмжгүй, хүний эрхийг хязгаарласан заалт байна гэж үзлээ.
13	Хуулийн төслийн зүйл, заалт жендэрийн эрх тэгш байдлыг хангасан эсэх?	Байхгүй.
14	Хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх?	Байхгүй.
15	Хуулийн төсөлд авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх?	Байхгүй.
16	Хуулийн төсөлд тусгасан хориглосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх?	Хуулийн төслийн 36 дугаар зүйлд хэрэг гүйцэтгэгчийн хариуцлага, 130 дугаар зүйлд хууль зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага гэсэн хоёр зүйлээр хариуцлагыг зохицуулжээ. Гэхдээ энэ зохицуулалт нь хангалттай гэж үзэх боломжгүй байна. Учир нь 130 дугаар зүйл хэт ерөнхий байх бөгөөд Зөрчлийн тухай хууль болон Эрүүгийн хуулийн ямар зүйл, ангиар ямар хариуцлагыг хэн тооцох нь тодорхойгүй байна.

2.5.2.Бусад хууль тогтоомжтой харилцан уялдсан байдал

Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийн төслийн зохицуулалттай харилцан нягт уялдаатай хэрэглэгдэх хууль тогтоомжид эн тэргүүнд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, Иргэний хууль, Компанийн тухай хуулиуд нэрлэгдэнэ. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуультай холбоотой хэрэглэгдэх дараах зохицуулалтууд Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийн төсөлд тусгагдсаныг дараах байдлаар хүснэгтээр үзүүлээ.

А. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуультай харилцан уялдсан байдал

*Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийн төслийн
үр нөлөө тооцох судалгааны тайлан*

д/д	Төслийн зохицуулалт	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль	Тайлбар санал
1.	21 дүгээр зүйл. Төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаа эхлүүлэх хүсэлтийг хүлээн авсан шүүгчийн ажиллагаа 21.2.Шүүгч үүрэг гүйцэтгэгчийн санхүүгийн байдлыг дордуулахаас урьдчилан сэргийлэх зорилгоор төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааг эхлүүлэх хүртэл хугацаанд дараахь албадлагын арга хэмжээг авах эрхтэй: 21.2.4.шүүхийн шийдвэр гүйцэтгэлийг түдгэлзүүлэхийг шийдвэр гүйцэтгэлийн байгууллагад даалгах;	27 дугаар зүйл. Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааг түдгэлзүүлэх 27.1.Шүүгч иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааг бүхэлд нь эсхүл хэсэгчлэн дараах үнэдслэл, хугацаагаар түдгэлзүүлж болно: 27.1.1. төлбөр төлөгч хуулийн этгээдэд дампуурлын хэрэг үүсгэсэн ... бол шүүхийн шийдвэр гарч хуулийн хүчин төгөлдөр болтол	Нэр томьёог жигдлэх, түдгэлзүүлэх хугацааг тодорхой болгон хуулийн төсөлтэй нийцүүлэх шаардлагатай байна.
	59 дугаар зүйл.Шийдвэрийг албадан гүйцэтгэхгүй байх 59.1.Төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааны явцад хариуцагчийн хуваарилагдах хөрөнгө, бусад хөрөнгөөр энэ хуулийн 22.2.1-д заасан бусдын амь нас, эрүүл мэнд, байгаль орчинд гэм хор, хохирол учруулсны төлбөр, ажилчдын цалин төлөхөөс бусад шаардлагыг хангуулахаар албадан гүйцэтгэх ажиллагаа хийж болохгүй. 59.2.Энэ хуулийн 59.1 дэх хэсэг нэхэмжлэгч болон нэхэмжлэл гаргаагүй үүрэг гүйцэтгүүлэгчид нэгэн адил хамаарна.	27 дугаар зүйл. Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааг түдгэлзүүлэх 27.1.Шүүгч иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааг бүхэлд нь эсхүл хэсэгчлэн дараах үнэдслэл, хугацаагаар түдгэлзүүлж болно: 27.1.1. төлбөр төлөгч хуулийн этгээдэд дампуурлын хэрэг үүсгэсэн ... бол шүүхийн шийдвэр гарч хуулийн хүчин төгөлдөр болтол	Төслийн 59 дүгээр зүйлд заасан тохиолдолд шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа түдгэлзэх боломжгүй болохыг тодорхой тусгах

2.	72 дугаар зүйл. Хүчин төгөлдөр бус хэлцлийг хянан шийдвэрлэх 72.1.Энэ хуулийн 71.1-д заасан хэлцлийн талаарх нэхэмжлэлийг хэрэг гүйцэтгэгчийн хүсэлтээр Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журмын дагуу шийдвэрлэнэ. 72.2.Хэрэг гүйцэтгэгч хүчин төгөлдөр бус хэлцлийг батлуулахаар шүүхэд хүсэлт гаргана. 72.3.Хүсэлтийг хүлээн авсан шүүх хэлцэл тус бүрээр холбогдох этгээдийг тайлбарыг авч 14 хоногийн дотор батлах эсэх талаар захирамж гаргана. 72.4.Энэ хуулийн 72.3-т заасан захирамж нь хэлцлийг хүчин төгөлдөр бус гэж батлах, эсхүл хүчинтэй гэж үзэх хэлбэртэй байна. 72.5.Хэлцлийг хүчин төгөлдөр бус гэж үзсэн шүүгчийн захирамжийг эс зөвшөөрсөн этгээд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны журмаар захирамжийг гардаж авснаас хойш 20 хоногийн дотор харьяалах шүүхэд нэхэмжлэл гарган ердийн журмаар шийдвэрлүүлнэ. 72.6.Энэ хуулийн 72.5-д заасан журмаар нэхэмжлэл гаргаагүй бол хэлцлийг хүчингүй гэж үзсэн захирамж ийнхүү нэхэмжлэл гаргах хугацаа дууссанаар, хэлцлийг хүчинтэй болохыг баталсан	5 дугаар зүйл. Шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх үндэслэл. 5.1. Шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх үндэслэл нь хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэр, хуульд заасан тохиолдолд бусад байгууллага, албан тушаалтны шүүхээр баталгаажуулсан шийдвэр байна.	Хуулийн төслийн дагуу төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааны явцад хариуцагчийн байгуулсан хэлцлийг хүчин төгөлдөр бус гэж үзэж үр дагаврыг арилгуулах хэргийг хянан шийдвэрлэх зэрэгцээ ажиллагаа үүсэж болно. Энэ ажиллагаа хэрэг гүйцэтгэгчийн хүсэлтээр үүсэх бөгөөд төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийг хянан шийдвэрлэж байгаа шүүгч хүсэлтийг захирамжаар шийдвэрлэж, тус захирамжийг эс зөвшөөрсөн этгээд шүүхэд ердийн журмаар шийдвэрлүүлэхээр нэхэмжлэл гаргахаар зохицуулсан байна. Энэ тохиолдолд хэрэв захирамжийг талууд зөвшөөрч цааш үргэлжлүүлэн маргаагүй үед захирамж хүчин төгөлдөр болох бөгөөд энэ тохиолдолд хүчин төгөлдөр шүүгчийн захирамжийг албадан гүйцэтгэх эсэх, уг ажиллагаанд шийдвэр гүйцэтгэгч оролцох эсэх асуудлыг дэлгэрүүлэн зохицуулах шаардлагатай байна.
-----------	---	---	---

*Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийн төслийн
үр нөлөө тооцох судалгааны тайлан*

	захирамж нь гарсан өдрөөсөө хүчинтэй байна.		
3.	91 дүгээр зүйл. Төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааг дуусгавар болгох, түүний үр дагавар 91.1.Эцсийн хуваарилалт явагдаж дуусмагц шүүх төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааг дуусгавар болгох шийдвэр гаргана. 91.6.Баталсан шаардлагын бүртгэлийг үндэслэн уг шаардлагад шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулж болно. 91.7.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хуудас гаргуулах хүсэлтийг баталсан шаардлагын бүртгэл, энэ хуулийн 91.1-д заасан шүүхийн шийдвэрийг үндэслэн төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаа дуусгавар болсны дараа гаргана.	5 дугаар зүйл. Шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх үндэслэл. Шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх үндэслэл нь хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэр, хуульд заасан тохиолдолд бусад байгууллага, албан тушаалтны шүүхээр баталгаажуулсан шийдвэр байна	Хуулийн төслийн дагуу эцсийн хуваарилалтыг хийж дууссанаар Төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаа дуусгавар болж байх бөгөөд энэ цаг мөчөөс эхлэн нэгэнт хуваарилах хөрөнгө байхгүй тул батлагдсан шаардлагыг хангах асуудалд хэрэг гүйцэтгэгчийн оролцоо байхгүй болох ерөнхий дүр зураг ажиглагдаж байна. Гэвч батлагдсан шаардлагын дүнгээр шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа эхлүүлэхээр төсөлд суулгасан нь нилээд олон зөрчлийг дагуулж байна. Тухайлбал, төлбөрийн чадваргүй хуулийн этгээд татан буугдсан бол төлбөр төлөгчөөр хэнийг бүртгэх, улмаар ямар этгээдэд холбогдуулан шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааг эхлүүлэх хэзээ ямар үндэслэлээр тус ажиллагааг дуусгавар болгох учиртай нь ойлгомжгүй болжээ.
4.	Энэ талаар тусгайлсан зохицуулалт төсөлд суугаагүй байна.	98 дугаар зүйл.Төлбөр төлөгч-Хуулийн этгээдийн үйл ажиллагаа дуусгавар болох үед төлбөр гаргуулах 98.1.Төлбөр төлөгч-хуулийн этгээд татан буугдсан, дампуурсан зэргээр үйл ажиллагааг нь зогсоосон тохиолдолд шийдвэр гүйцэтгэх ажиллагааг түдгэлзүүлж гүйцэтгэх баримт бичгийг татан буулгах комисс, дампуурлын хэрэг гүйцэтгэгчид шилжүүлнэ.	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд дампуурал гэсэн нэр томъёог хэрэглэсэн байх бөгөөд аливаа хугацааг тоолж эхлэх цаг моментыг тодорхойлохдоо дампуурсан, татан буугдсан гэх зэргээр илэрхийлж байгааг төсөлд анхаарч нийцүүлэх шаардлагатай байна. Тухайлбал төсөлд төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаа эхлүүлсэн, дахин зохион байгуулах ажиллагаа эхлэх, төлбөрийн

*Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийн төслийн
үр нөлөө тооцох судалгааны тайлан*

			чадваргүйдлийн ажиллагаа дуусгавар болсон, зогссон гэх мэт байдлаар цаг хугацааны мөчлөгийг тодорхойлж байгааг анхаарах
5.	Хуулийн төслийн хуваарилагдах хөрөнгийн цар хүрээ, шийдвэр гүйцэтгэх ажиллагаа төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааны хүсэлт гаргасан үеэс эхлэн түдгэлзэх боломжтой талаарх төслийн зохицуулалтууд бий	98.2.Төлбөр төлөгч-хуулийн этгээдэд холбогдуулан дампуурлын хэрэг үүсгэсэн тохиолдолд шийдвэр гүйцэтгэгч гүйцэтгэх баримт бичгийн шаардлагаас илүү гарсан хэмжээгээр хөрөнгийг битүүмжилсэн, барьцаалсан, хураан авсан шийдвэрийг хүчингүй болгож, энэ талаар дампуурлын хэрэг гүйцэтгэгчид мэдэгдэнэ. 98.3.Шийдвэр гүйцэтгэгч битүүмжилсэн, барьцаалсан, хураан авсан хөрөнгийн үнэ нь гүйцэтгэх баримт бичигт заасан шаардлагын хэмжээнээс илүүгүй тохиолдолд гүйцэтгэх баримт бичгийн шаардлагыг хангах зорилгоор албадан борлуулах, эсхүл төлбөрт суутган шилжүүлэх тухай шийдвэр гаргана. 98.4.Шаардлагыг нь хангасан гүйцэтгэх баримт бичгийг дампуурлын хэрэг гүйцэтгэгч, эсхүл татан буулгах комисст хүргүүлнэ.	Төслийн үндсэн утга агуулгатай нийцэхгүй байна. Төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааг эхлүүлэх тухай хүсэлт гарснаар шүүхээс шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааг түдгэлзүүлэх бөгөөд улмаар ажиллагааг эхлүүлсэн бол хариуцагчийн хуваарилагдах хөрөнгийг төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаанаас өөр процессоор захиран зарцуулахгүй. Эдгээр хөрөнгө нь шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааны дагуу өөр төлбөрт хураагдсан, барьцаалагдсан нь хамааралгүй юм. Иймд 98.3-т заасан тохиолдолд ч эдгээр хөрөнгүүдэд холбогдох шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааг түдгэлзүүлэх учиртай.
6.	59 дүгээр зүйл.Шийдвэрийг албадан гүйцэтгэхгүй байх 59.1.Төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааны явцад хариуцагчийн хуваарилагдах хөрөнгө, бусад хөрөнгөөр энэ хуулийн 22.2.1-д заасан бусдын амь нас, эрүүл	98.5.Төлбөр төлөгч-хуулийн этгээдэд дампуурлын хэрэг үүсгэснээс хойш энэ хуулийн 44.2-т заасан аливаа арга хэмжээг гүйцэтгэхгүй. Төлбөр төлөгч-хуулийн этгээдэд холбогдуулан татан буулгах ажиллагаа эхлүүлсэн, эсхүл дампуурлын хэрэг үүсгэснээс хойш гүйцэтгэх	Хуулийн төсөлд дампуурлын хэрэг үүсгэх гэдэг ойлголт, үе шат байхгүй. Төслийн төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаа эхлүүлэх тухай зохицуулалт нь дампуурлын хэрэг үүсгэхээс ялгаатай. Түүнчлэн төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаа эхлүүлснээс

*Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийн төслийн
үр нөлөө тооцох судалгааны тайлан*

	мэнд, байгаль орчинд гэм хор, хохирол учруулсны төлбөр, ажилчдын цалин төлөхөөс бусад шаардлагыг хангуулахаар албадан гүйцэтгэх ажиллагаа хийж болохгүй. 59.2.Энэ хуулийн 59.1 дэх хэсэг нэхэмжлэгч болон нэхэмжлэл гаргаагүй үүрэг гүйцэтгүүлэгчид нэгэн адил хамаарна.	баримт бичиг олгосон, эсхүл ирүүлсэн баримт бичгийн дагуу шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулаагүй тохиолдолд гүйцэтгэх баримт бичгийг татан буулгах комисс, дампуурлын хэрэг гүйцэтгэгчид шилжүүлнэ.	хойш шийдвэр гүйцэтгэх ажиллагаа эхлүүлэхийг хориглосон.
7.	Төсөлд нэхэмжлэлийн шаардлагыг хангах, хөрөнгийг худалдах, борлуулах, хуваарилах талаар тусгайлсан зохицуулалт маш дэлгэрэнгүй зохицуулсан	98.6.Татан буулгах комисс, дампуурлын хэрэг гүйцэтгэгч гүйцэтгэх баримт бичгийг хүлээн авмагц Иргэний хууль, Дампуурлын тухай хуульд заасан журмын дагуу төлбөр авагчид, эсхүл гүйцэтгэх баримт бичиг ирүүлсэн шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын дансанд төлбөрийг шилжүүлнэ.	Төслийн зарчим, үндсэн агуулгатай нийцүүлэн өөрчлөх нь зүйтэй.
8.	Төсөлд энэ талаар нарийвчилсан зохицуулалт байхгүй	98.7.Төлбөр төлөгч-хуулийн этгээдэд дампуурлын хэрэг үүсгэн дахин хөрөнгөжүүлэх төлөвлөгөө хэрэгжүүлснээр үйл ажиллагаа нь сэргэж төлбөрийн чадвартай болсон боловч төлөвлөгөөний хугацаа дуусахад төлбөрийг барагдуулж дуусаагүй тохиолдолд дампуурлын хэрэг гүйцэтгэгч гүйцэтгэх баримт бичгийг шийдвэр гүйцэтгэх албанд шилжүүлнэ.	Төслийн үндсэн агуулгатай нийцэж байна. Төслийн холбогдох хэсэгт энэ талаар тодруулан оруулах боломжтой.
9.	Төсөлд энэ талаар нарийвчилсан зохицуулалт байхгүй	98.8.Төлбөр авагчийн хүсэлтээр шийдвэр гүйцэтгэгч өөрийн шилжүүлсэн гүйцэтгэх баримт бичгийн шаардлагыг хангах талаар татан буулгах комисс, дампуурлын хэрэг	Төслийг тус заалттай нийцүүлж болно.

*Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийн төслийн
үр нөлөө тооцох судалгааны тайлан*

	гүйцэтгэгчийн авч хэрэгжүүлсэн арга хэмжээ хуульд нийцсэн эсэхийг шалгаж болно.	
--	--	--

Дээр дурдсан асуудлуудаас гадна хуулийн төслийг хүчин төгөлдөр үйлчилж байгаа Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуультай харьцуулах үед хэрэг гүйцэтгэгчид тодорхой тохиолдлуудад шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны давуу талуудаас ашиглах боломжийг олгох нь зүйтэй мэт санагдав. Тодруулбал, өнөөгийн манай нөхцөл байдлаас шалтгаалан хуваарилагдах хөрөнгийг худалдах, нэхэмжлэгчдийн хурлыг зарлах зэрэг олон хүмүүсийг хамарсан өргөн хүрээний арга хэмжээг зохион байгуулах бол хурлын танхим, зарим төрлийн эд хөрөнгийг худалдах тусгай зориулалтын байр талбай дутмаг зэрэг нөхцөл байдлуудыг харгалзаж энэ талаар хэрэг гүйцэтгэгч шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тусламжийг авах боломжийг олгох байдлаар төсөл болон дагалдах хуулийн нэмэлт, өөрчлөлтийг боловсруулах нь зүйтэй байна.

Б. Иргэний хуультай харилцан уялдсан байдал

Д/д	Төслийн зохицуулалт	Иргэний хуулийн зохицуулалт	Тайлбар, санал
1.	44 дүгээр зүйл.Хугацаа нь болоогүй үүргийн дагуу үүсэх шаардлага 44.4.Төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаа эхлүүлснээр дуусах хугацаа нь болоогүй байсан үүргийн хугацаа дуусна.	208 дугаар зүйл. Үүрэг гүйцэтгэх хугацаа 208.6.Үүрэг гүйцэтгэгч төлбөрийн чадваргүй болсон буюу үүргийн гүйцэтгэлийг хангах эд хөрөнгийн хэмжээ багассан, эсхүл эд хөрөнгөгүй болсон бол үүрэг гүйцэтгүүлэгч нь энэ хуулийн 208.4-т заасан хугацаанаас өмнө үүргээ нэн даруй гүйцэтгэхийг түүнээс шаардах эрхтэй.	Үндсэн санаа нэг агуулгыг илэрхийлсэн заалтууд байх хэдий ч төслийн томъёолол боловсронгуй биш болжээ. Иймд Иргэний хуулийн томъёоллын дагуу сайжруулах нь зүйтэй.
2.	46 дугаар зүйл. Хүүгийн шаардлага 46.1.Төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааг эхлүүлсэн үеэс эхлэн гэрээний дагуу өр төлбөр, хүүг тооцох боловч хүү төлөхийг зогсооно.	222 дугаар зүйл. Үүрэг гүйцэтгэгч хугацаа хэтрүүлэх 222.5.Мөнгөн төлбөрийн үүргээ хугацаанд нь гүйцэтгээгүй бол үүрэг гүйцэтгэгч хэтрүүлсэн хугацаанд тохирсон хүү төлөх үүрэгтэй.	Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийн төслийн хүүгийн шаардлагад холбогдох хэсгийн томъёолол өөр хоорондоо болон бусад хууль тогтоомжтой зөрчилтэй болжээ. Олон улсын туршлагаас үзвэл төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаа эхлүүлснээр гэрээнд тохирсон хүүг тооцохоо зогсож

*Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийн төслийн
үр нөлөө тооцох судалгааны тайлан*

			харин хуулиар тогтсон хүүгийн хэмжээнд шилжих зохицуулалт байна. Манай Иргэний хуулийн 222.5 дахь хэсгийн дагуу тооцох хүүг хуулиар тогтоосон хүү гэж тайлбарладаг. Энэ ч агуулгаар төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааны хүүгийн шаардлагын хэмжээ тодорхойлогдох нь зүйтэй.
3.	57 дугаар зүйл.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд эрх залгамжлах 57.1.Төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаа эхлүүлсэн өдрийн байдлаар хариуцагчийн нэхэмжлэл гарган оролцож байсан аливаа ажиллагаанд хэрэг гүйцэтгэгч түүний эрх, үүргийг залгамжлан оролцож болно.	62 дугаар зүйл. Хэлцэлд төлөөлөх 62.3. Төлөөлөгчийн бүрэн эрх хуулийн дагуу буюу итгэмжлэлийн үндсэн дээр үүснэ	Иргэний эрх зүйн үүднээс эрх залгамжлалын ойлголт нь төлөөлөл гэсэн ойлголт эсхүл өв залгамжлалын ойлголттой холбоотой яригдах онцлогтой. Иймд төслийн энэхүү зохицуулалтыг чухам аль үндэслэлээр ойлгож хуулийн төсөлд суулгасныг дахин нягтлах шарадлагатай байна. Учир нь хэрэг гүйцэтгэгчийн татан буугдсан, байхгүй болсон аль нэг этгээдийн эрх үүргийг үргэлжлүүлж байгаа хэрэг бус үйл ажиллагаагаа явуулж байгаа, хараахан татан буугдаагүй хуулийн этгээдийг төлөөлж байгаа гэж ойлгогдох учиртай.
4.	84 дугаар зүйл. Нэхэмжлэлийн шаардлага хангах дараалал 84.1.Хуваарилагдах хөрөнгөөс нэхэмжлэлийн шаардлагыг дараахь дарааллаар хангана:	32 дугаар зүйл. Хуулийн этгээдийг татан буулгах 32.5.Хуульд өөрөөр заагаагүй бол татан буугдаж байгаа хуулийн этгээдэд холбогдох шаардлагыг дараахь дарааллаар хангана:	Иргэний хуульд дампуурлын ажиллагааны явцад шийдвэрлэсэн нэхэмжлэлийн шаардлагыг хангах дарааллыг тогтоосон нь тусгайлсан хууль тогтоомжоор

*Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийн төслийн
үр нөлөө тооцох судалгааны тайлан*

	84.1.1.бусдын амь нас, эрүүл мэндэд учруулсан гэм хорыг арилгах төлбөр; 84.1.2.төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааны зардал; 84.1.3.ажилтнуудын цалин, олговор, нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгал болон бусад хөдөлмөрийн болон хамтын гэрээгээр хүлээсэн өр төлбөр; 84.1.4.хариуцагчийг дахин зохион байгуулах зорилгоор төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааг эхлүүлснээс хойш бий болсон өр төлбөр; 84.1.5.нэхэмжлэлийн шаардлагын бүртгэлд орсон нэхэмжлэгчдийн барьцаагаар хангагдаагүй өр төлбөр, барьцаа хөрөнгийн үнэлгээний зөрүүгээр төлөгдөөгүй үлдсэн өр төлбөр.	32.5.1.бусдын амь нас, эрүүл мэндэд учруулсан гэм хорыг арилгуулах болон шүүхийн шийдвэрээр гаргуулах бусад төлбөр; 32.5.2.хэрэг гүйцэтгэгч буюу татан буулгах комисс, тэдгээртэй адилтгах бусад этгээдийн эрх, үүргийнхээ хүрээнд гүйцэтгэсэн үйл ажиллагааны зардал; 32.5.3.дампуурлын үед хариуцагчийг дахин хөрөнгөжүүлэх явцад байгуулсан гэрээ, хэлцлийн дагуу гаргасан шаардлага; 32.5.4.хадгаламжийн албан журмын даатгалын нөхөн төлбөр; 32.5.5.хадгаламж эзэмшигчийн мөнгөн хөрөнгө; 32.5.6.хөдөлмөрийн гэрээгээр ажиллагсдад төлөх хөдөлмөрийн хөлс; 32.5.7.хууль тогтоомжид заасны дагуу бусад этгээдтэй хийх тооцоо.	зохицуулагдвал зохих харилцаа гэж үзэх үндэстэй байна. Иймд тус зохицуулалтыг Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийн төсөлтэй нийцүүлэн өөрчлөх нь зүйтэй.
5.	91 дүгээр зүйл. Төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааг дуусгавар болгох, түүний үр дагавар 91.1.Эцсийн хуваарилалт явагдаж дуусмагц шүүх төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааг дуусгавар болгох шийдвэр гаргана. 91.2.Энэ хуулийн 91.1-д заасан шийдвэрт төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаа дуусгавар болсон үндэслэлийг дурдаж, улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлэхийг хэрэг гүйцэтгэгчид даалгана. 91.3.Энэ хуулийн 91.1-д заасан шийдвэрийн хувийг хуулийн	32 дугаар зүйл. Хуулийн этгээдийг татан буулгах 32.1.2. Дампуурсанд тооцсон, ... үндэслэлээр татан буулгах тухай шүүхийн шийдвэр гарсан	Төслийн 91 дүгээр зүйлээр хариуцагчийн эд хөрөнгийг худалдан хуваарилалтын ажиллагаа журмын дагуу явагдсанаар татан дампуурлын ажиллагаа дуусгавар болох үндэслэлийг зохицуулсан байна. Харин энэ үндэслэлээр татан буулгаж байгаа атлаа хуулийн этгээдийн дампуурлыг зарлах болон татан буулгах эсэх асуудлыг тусгаагүй нь зөрчилтэй, ойлгомжгүй болжээ.

*Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийн төслийн
үр нөлөө тооцох судалгааны тайлан*

	этгээдийн улсын бүртгэлийн болон татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.		Түүнчлэн бүртгэлийн байгууллага, татварын албанд дампуурлын ажиллагаа дуусгавар болсон тухай мэдээллийг хүргүүлэхээр заасан зорилго ойлгомжгүй, энэ нь татан буугдсаныг бүртгэх, тус тусын бүртгэлдээ энэ талаар тусгуулах үр дагавартай эсэх нь тодорхойгүй байна.
6.	93 дугаар зүйл.Хуваарилагдах хөрөнгө хүрэлцээгүйн улмаас төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааг зогсоох 93.1.Төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааг эхлүүлсний дараа хуваарилагдах хөрөнгө төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааны зардлыг төлөхөд хүрэлцэхгүй болох нь тогтоогдсон бол шүүх төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааг зогсооно.	32 дугаар зүйл. Хуулийн этгээдийг татан буулгах 32.1.2. Дампуурсанд тооцсон, ... үндэслэлээр татан буулгах тухай шүүхийн шийдвэр гарсан	Төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааны зардлыг нэхэж чадахгүй нь тогтоогдсоны улмаас ажиллагаа зогсох тохиолдолд Иргэний хуулийн 32.1.2 дахь хэсэг үйлчлэх эсэх, хуулийн этгээдийн хувь заяа хэрхэх нь тодорхойгүй үлджээ. Нэгэнт хөрөнгө хүрэлцээгүй учир дахин зохион байгуулах ажиллагаанд шилжихгүйн зэрэгцээ хөрөнгө худалдан мөнгөн хөрөнгийг хуваарилах ажиллагаа хийгдэхгүй. Иймд энэ үндэслэлээр ажиллагаа зогссоны дараах үр дагавар хэрхэх нь ойлгомжгүй үлджээ.
7.	111 дүгээр зүйл.Төлөвлөгөөг хэрэгжүүлэх 111.2.Төлөвлөгөөг хэрэгжүүлж эхэлсэн нь хариуцагчтай хамтран үүрэг хүлээгч, баталгаа гаргагчийн эсрэг шаардлага гаргах нэхэмжлэгчийн эрхэд нөлөөлөхгүй.	242 дугаар зүйл.Хамтран үүрэг гүйцэтгэгчид 242.13.Хамтран үүрэг гүйцэтгэгчдийн хэн нэг нь төлбөрийн чадваргүй бол үүргийн түүнд оногдох хэсгийг төлбөрийн чадвартай бусад үүрэг	Иргэний хуульд заасан энэхүү зарчим төслийн бүхий л үе шатанд үйлчлэх учиртай. Өөрөөр хэлбэл төсөлд гагцхүү дахин зохион байгуулалтын төлөвлөгөөний үед

*Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийн төслийн
үр нөлөө тооцох судалгааны тайлан*

		гүйцэтгэгчид тэнцүү хуваарилна. 396 дугаар зүйл. Дамжуулан гүйцэтгэх тээвэрлэлт 396.7.Хэрэв тээвэрлэгчдийн хэн нэг нь төлбөрийн чадваргүй бол түүний төлөх ёстой байсан төлбөрийг бусад тээвэрлэгчид авсан хөлстэйгээ хувь тэнцүүлэн хариуцна.	хэрэгжихээр тусгасан нь учир дутагдалтай байна.
8.	Төсөлд энэ талаар тусгайлсан зохицуулалтгүй	52 дугаар зүйл. Зөвшөөрлийг буцааж хэрэглэхгүй байх нөхцөл 52.1.Хэлцлийг зөвшөөрөл олгох эрх бүхий этгээдийн шийдвэрээр хожим дэмжин зөвшөөрөхөөс өмнө буюу албадан биелүүлэх журмаар, эсхүл дампуурлын хэрэг гүйцэтгэгчээс эд хөрөнгийг захиран зарцуулахтай холбоотой хийсэн үйл ажиллагаа нь энэ хуулийн 42.1-42.3-т зааснаас үл хамааран хүчин төгөлдөр байна.	Иргэний хуулийн энэхүү заалт нь хэлцлийг хожим дэмжин зөвшөөрөхөөс өмнө хэрэг гүйцэтгэгчийн хийсэн үйлдлийг зөвшөөрөл өгсний дараа ч хүчинтэй хэвээр байхыг дурдаж хэрэг гүйцэтгэгчтэй харилцсан гуравдагч этгээдийн эрх ашгийг хамгаалахад чиглэсэн заалт юм. Төсөлд энэ талаар тухайлсан нарийвчилсан зохицуулалт байхгүй хэдий ч ИХ-иар тогтоосон энэ зарчмыг үгүйсгээгүй байна.
9.	Энэ талаар төсөлд тусгайлсан өөр зохицуулалт байхгүй.	434 дүгээр зүйл. Даатгалын гэрээ дуусгавар болох үндэслэл 434.2.2.даатгагч, даатгуулагчийн аль нэг дампуурсан, татан буугдсан;	Төсөлд анхаарч үзэх шаардлагатай. Иргэний хуулийн энэхүү байр суурь хэвээр байх эсэхийг тодруулах нь зүйтэй байна. учир нь даатгуулагчийг төлбөрийн чадваргүй болохтой холбоотой эрсдлээс хамгаалж даатгалын гэрээ байгуулсан бол энэ үндэслэлээр гэрээ дуусгавар болох эсэхийг судлах, түүнчлэн төлбөрийн чадваргүйдлийн

*Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийн төслийн
үр нөлөө тооцох судалгааны тайлан*

			ажиллагааны үе шатны хувьд дампуурсан гэдгийг чухам хэзээ гэж ойлгохыг тодруулах нь зүйтэй байна.
10.	74 дүгээр зүйл.Төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааны хуваарилагдах хөрөнгө 74.1.Дараахь хөрөнгийг төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааны хуваарилагдах хөрөнгө /цаашид “хуваарилагдах хөрөнгө” гэх/-д тооцно: 74.1.1.төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаа эхлүүлэх үед хариуцагчийн өмчлөлд байсан эдийн ба эдийн бус хөрөнгө; 74.1.2.төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаа эхлүүлснээс хойш хариуцагчийн өмчлөлд шилжиж ирсэн эдийн ба эдийн бус хөрөнгө; 74.1.3.барьцаагаар хангагдсан шаардлагаас илүү гарсан барьцааны зүйлийн үнэ; 74.1.4.хүчин төгөлдөр бус болон хүчин төгөлдөр бус гэж тооцогдсон хэлцлийн үр дагаварт буцаан авсан эд хөрөнгө; 74.1.5.хуульд заасан бусад.	443 дугаар зүйл. Гэм хорын даатгал 443.19. ... Даатгуулагч дампуурсантай холбоотойгоор даатгалын гэрээ цуцлагдсан нөхцөлд даатгалын нөхөн төлбөр авах эрх бүхий этгээд нь даатгагчаас шаардвал зохих мөнгөний хэмжээгээр дампуурлын үед даатгуулагчийн бусдад хуваарилагдах хөрөнгийг бүрдүүлэхэд оролцох үүрэгтэй.	Төсөлд даатгуулсан хуулийн этгээд дампуурах тохиолдолд түүний гуравдагч этгээдэд ашигтайгаар байгуулсан даатгалын гэрээний дагуух шаардлагыг хэрхэх талаар тусгайлан анхаарч зохицуулаагүй байна. иймд энэ асуудлаар гагцхүү Иргэний хууль хэрэглэгдэхээр байна.

Хуулийн төслийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль болон Иргэний хуультай харьцуулан судлах үед ердийн үед эдгээр хууль тогтоомжийн үйлчлэлд хамаарвал зохих олон төрлийн харилцааг хамтатган зохицуулах шинжтэй материаллаг ба процессын эрх зүйн аль аль шинжийг агуулсан өвөрмөц бүтэцтэй хууль болох нь анзаарагдаж байна. Энэ ч агуулгаар үндсэн нэр томьёог, тухайлбал төлбөрийн чадваргүй болсон этгээдийг хариуцагч, үүрэг гүйцэтгэгч гэж, шаардах эрх бүхий этгээдийг үүрэг гүйцэтгүүлэгч, нэхэмжлэгч гэж нэрлэн, холимог байдлаар төсөлд хэрэглэжээ. Энэ нь оновчтой биш бөгөөд холбогдох нэр томьёог тодорхой үндэслэл шалтгаангүйгээр холимог байдлаар хэрэглэлгүй олон улсын жишиг, зохицуулах харилцааны бие даасан шинж байдлаас шалтгаалан нэг мөр нэршлийг

ашиглан шаардах эрх бүхий этгээдийг үүрэг гүйцэтгүүлэгч, төлбөрийн чадваргүй болсон этгээдийг үүрэг гүйцэтгэгч гэж нэрлэх нь зүйтэй байна.

2.5.3.Олон улсын эрх зүйн хүрээнд харилцан уялдсан байдал буюу Үндэстэн дамнасан төлбөрийн чадваргүйдлийн загвар хууль

НҮБ-ийн худалдааны хууль тогтоомжийн хороо (цаашид UNCITRAL гэх) 1997 онд Үндэстэн дамнасан төлбөрийн чадваргүйдлийн загвар хуулийг батлан гаргасан байна.

Төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааны үүрэг гүйцэтгэгчийн хөрөнгө нь хэд хэдэн улсад байршдаг, зарим нэхэмжлэгч нар нь төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааг эхлүүлсэн улсаас өөр улсын иргэн байгаа тохиолдолд үндэстэн дамнасан төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаа хийгдэх шаардлага тулгардаг. 1990 оноос хойш үндэстэн дамнасан төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаа бага багаар нэмэгдсэн боловч дотоодын хууль тогтоомжоор энэ асуудлыг шийдвэрлэх эрх зүйн зохицуулалт байхгүй, хамтын ажиллагаа хангалтгүй байсны улмаас, иргэдийн хууль ёсны эрх, ашиг хамгаалалтгүй үлдэх зэргээр зөрчил үүсч эхэлсэн.

Иймээс улс, орнуудын хамтын ажиллагааг дэмжих, нэгдсэн удирдлагаар хангах зорилгоор UNCITRAL-аас Үндэстэн дамнасан төлбөрийн чадваргүйдлийн загвар хуулийг батлан гаргасан байна. Энэ загвар хууль нь хөгжингүй болон хөгжиж буй улс орнуудад дампуурлын хууль тогтоомж, тэр дундаа хил дамнасан төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааны талаар зохицуулалт хийхэд суурь болгон ашиглах тулгуур баримт бичиг юм

Загвар хууль нь эрх зүйн ялгаатай дэглэм бүхий улсуудын хууль тогтоомжийг нэгтгэх, ижилтгэх гэхээсээ илүүтэй улс орнуудын хамтын ажиллагааг дэмжиж, удирдлагаар хангах зорилгыг тавьсан байна. Энэхүү зорилгодоо хүрэхийн тулд дараахь дөрвөн үндсэн асуудалд анхаарлаа хандуулсан байна. Тухайлбал,

1. Гадаадын үүрэг гүйцэтгүүлэгч болон нэхэмжлэгч нарыг төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаанд биечлэн болон итгэмжлэгдсэн төлөөлөгчөөрөө дамжуулан оролцох эрх олгох
2. Үүрэг гүйцэтгэгчийн гадаад улсад байгаа хөрөнгө болон гадаадын үүрэг гүйцэтгэгч болон үүрэг гүйцэтгүүлэгч, нэхэмжлэгч нарыг тодорхойлох
3. Төлбөр төлөх дараалал тогтоох болон бусад ажиллагаанд гадаадын нэхэмжлэгч нарыг оролцуулах
4. Үүрэг гүйцэтгэгчийн хөрөнгө байгаа газрын болон эсвэл нэхэмжлэгч нарын байгаа газрын шүүхүүдийн хамтын ажиллагааг дэмжих.

Энэхүү загвар хуулийг Австрали, Канад, Чили, Колумби, Япон, Мексик, БНСУ, АНУ, Өмнөд Африк, Уганда зэрэг 40 гаруй улс баталсан байна. Загвар хууль нь энэ хуулийг баталсан эдгээр 40 гаруй улсад хүчинтэй үйлчилж, эдгээр орнуудын шүүхүүд үндэстэн дамнасан төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааг шийдвэрлэхдээ харилцан дэмжлэг үзүүлж, ажилладаг байна.

Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийн төсөлд үндэстэн дамнасан төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааны талаар тусгаагүй байна. Техник, технологи хөгжилтэй зэрэгцэн хууль, эдийн засаг глобалчлагдаж буй өнөө үед үндэстэн дамнасан төлбөрийн чадваргүйдлийн харилцааг зохицуулалтгүй үлдээх нь гадаадын болон өөрийн орны иргэдийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалалтад авах боломжгүй сөрөг үр дагавар авчрах эрсдэлтэй юм. Тиймээс

хуулийн төсөлд үндэстэн дамнасан төлбөрийн чадваргүйдлийн харилцааг нэмж тусгах эсвэл UNCITRAL-ийн Үндэстэн дамнасан төлбөрийн чадваргүйдлийн загвар хуулийг батлах хэрэгтэй гэж үзэж байна.

Гурав. Үр дүнг үнэлж, зөвлөмж өгөх

3.1 Шалгах хэрэгслийг хэрэглэсэн үр дүнг баримтжуулах

Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийн төслийг боловсруулах ажил Засгийн газрын түвшинд эхлээд 10-аад жилийн нүүр үзжээ. Төсөл боловсруулах ажлын явцад дотоодын олон судлаач, судалгааны байгууллагууд хуулийн этгээд болон хувь хүний дампуурал, дахин зохион байгуулах ажиллагааны талаар судалгаа шинжилгээний ажил хийж гүйцэтгэсэн байна. Энэхүү судалгаа нь эдгээр судалгаанаас зорилго, хэрэгцээ шаардлага, ач холбогдлын хувьд ихээхэн ялгаатай бөгөөд тодорхой түвшинд эцэслэгдсэн гэж тооцож буй хуулийн төсөл нь хэрэгжих бодит боломжтой эсэх, дотоодын эрх зүйн зохицуулалтын нэгэн эд эс болон орших боломжтой эсэхийг шалган үнэлэх зорилготой судалгаа юм. Хуулийн төслийн энэхүү хувилбарын үзэл баримтлалыг Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2019 оны 2 дугаар сард баталсан байх ба тус үзэл баримтлалын дагуу судалгааны ажлыг хийж гүйцэтгэлээ.

Хуулийн төсөл нь зорилгоо биелүүлсэн эсэх, ойлгомжтой бөгөөд практикт хэрэгжих боломжтой эсэх, бусад хуулиудтай уялдсан эсэх, хуулийн төсөл батлагдсанаар бий болох эдийн засгийн үр дагавар, зардал тооцоо зэргийг судлахдаа холбогдох хуулиудаас гадна дараахь нэмэлт баримт бичиг, материалыг ашигласан болно. Үүнд:

1. Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газраас хийж гүйцэтгэсэн Дампуурлын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ, 2018 он
2. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Олон улсын худалдааны эрх зүйн комиссоос гаргасан Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийн төслийг боловсруулах тухай зөвлөмж, 2005 он
3. Европын холбооны улс орнуудын тайлан илтгэл 2016 он
4. Төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааны үр дүнтэй систем ба үүрэг гүйцэтгүүлэгч/үүрэг гүйцэтгэгчийн эрхийн зарчмууд-Дэлхийн банк 2015
5. Хууль зүйн үндэсний хүрээлэн, Д.Зүмбэрэллхам, Л.Банзрагч, Б.Ундрах, Ж.Алтансүх, Аж ахуйн нэгжийн дампуурал ба дахин хөрөнгөжүүлэх ажиллагаа, харьцуулсан судалгаа, 2015 он
6. Н.Баярмаа, Д.Эрдэнэчимэг, Дампуурлын эрх зүйн зохицуулалтын харьцуулсан судалгаа
7. Хуулийн төсөлтэй холбогдуулан төрийн болон төрийн бус байгууллагаас ирүүлсэн санал
8. Хэрэг гүйцэтгэгч нараас хуулийн төслийн хэрэгжилттэй холбогдуулан тусгайлан өгсөн санал
9. Монгол Улсын Иргэний хуулийн тайлбар, бусад эрдэм шинжилгээний ном, сурах бичиг, гарын авлага, өгүүлэл, нийтлэлүүд /ашигласан материалын жагсаалтаас үзнэ үү/

Эдгээр баримт бичиг, материалыг тус судалгааны тайланд хавсаргах бөгөөд интернэтээс авсан мэдээллийн хувьд судалгааны ажлын холбогдох хэсэгт зохих журмын дагуу ишлэл авсан байгаагаас дэлг

эрүүлэн харж болно.

3.2 Судалгааны үр дүнг үнэлэх нь

Шалгах хэрэгслийг хэрэглэсэн үр дүнг баримтжуулах шатанд цуглуулсан мэдээ, мэдээлэл, үр нөлөөг тооцох ажиллагааны явц, тэдгээрийн үр дүнг үнэлсэний үндсэн дээр хуулийн төслийн үр нөлөөг тооцоход Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийн төсөл батлагдсанаар бий болох үр нөлөө, үр дагаврын талаар илэрхий болсон санал бодлоо судалгааны ажлын энэ хэсэгт нэгтгэн дүгнэх болно.

3.2.1. Зорилгод хүрэх байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлэх нь

Зорилгод хүрэх байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн үзэл баримтлалд дүн шинжилгээ хийсний үр дүнд олон улсын жишиг, дотоодын хэрэгцээ шаардлагад нийцсэн цогц зохицуулалтыг бий болгосноор санхүүгийн хүндрэлд орсон хуулийн этгээдийг эрт үед илрүүлэн дахин зохион байгуулах, үйл ажиллагааг нь сэргээх, сэргэх, сайжрах боломжгүй болсон хуулийн этгээдийг хөрөнгийг шударга бөгөөд үр ашигтай хуваарилж, нэхэмжлэгчдийн эрх ашгийг тэгш хангах ингэснээр эдийн засаг, нийгмийн салбарыг эрүүлжүүлэх, бизнес, худалдааны зах зээлийн хэвийн тогтвортой хөгжлийг хангахад хуулийн төслийн үндсэн зорилго оршино гэсэн дүгнэлт хийж уг зорилгоо хэрхэн биелүүлсэн талаар энд хураангуйлан авч үзье.

Төлбөрийн чадваргүйдлийн тухай бие даасан хуулийн төсөл боловсруулахдаа шийдвэрлэхийг зорьсон гол асуудлын нэг нь өнөөгийн хүчин төгөлдөр үйлчилж буй дампуурлын тухай хуулийн боловсронгуй биш байдал, өнөөгийн худалдааны эрх зүй, нийгэм эдийн засгийн хэрэгцээ шаардлагыг хангаж чадахгүй болсонтой холбогдоно. Өөрөөр хэлбэл Дампуурлын тухай хууль бүхэлдээ хэрэг хянан шийдвэрлэх процесс ажиллагааны дүрэм журам дутагдалтайгаас Дампуурлын тухай хуулийг шүүхээс хэрэгжүүлэхдээ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийг баримталдаг нь огтоос тохиромжгүй байдлыг үүсгэж улмаар хүний эрх зөрчигдөх, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогчдын хувьд шударга бус байдал үүсэх нөхцөл болдог. Иймд төлбөрийн чадваргүйдлийн хэргийг хянан шийдвэрлэх процесс ажиллагааг зохицуулалттай болгохыг зорьсон нь хуулийн төслийн гол зорилгын нэг байж, улмаар энэ зорилгодоо харьцангуй сайн хүрсэн гэж дүгнэхээр байна.

Гэвч хуулийн төслийн давуу талыг бодит биеллээ олоход нэн шаардлагатай дараагийн алхам нь шүүгч, хэрэг бүртгэгчдийг сургах, мэргэшүүлэх асуудал болох нь судалгааны ажлын бусад хэсгээс тодорхой харагдаж байна. Өнөөдрийг хүртэл баримталж, хэрэглэж ирсэн Дампуурлын тухай хуулийн хоцрогдол, боловсронгуй бус байдал энэ хуулийг хэрэглэгч этгээдийн мэдлэг, туршлага, мэргэшлийн түвшинд ч нөлөөлсөн гэдгийг анзаарахгүй орхиж болохгүй.

Хуулийн төслийн дараагийн чухал зорилт нь олон улсын жишигт нийцсэн энэ талаар дэлхий нийтээр баримтлахыг зорьж буй стандартыг бий болгосон худалдааны эрх зүйн эх сурвалжийг бүтээх явдал байсан.

Эдгээр нь хөрөнгийн үнэ цэнийг нэмэгдүүлэх, дампуурсанд тооцож татан буулгах ажиллагаа болон дахин зохион байгуулах ажиллагааны тэнцвэрт байдлыг хангах, адил төстэй нөхцөлд байгаа үүрэг гүйцэтгүүлэгчдтэй тэгш харилцах,

төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааны явцад үр дүнтэй, ялгаварлалгүй шийдвэрийг цаг алдалгүй гаргах, хуваарилагдах хөрөнгийг үүрэг гүйцэтгүүлэгчдэд тэнцүү хуваарилах, мэдээлэл олж авах, үнэлэх, тараах боломжтой, ойлгомжтой, ил тод, үр дагаврыг таамаглах боломжтой зохицуулалтыг бий болгох, нэхэмжлэлийн шаардлагын дарааллын зарчим тодорхой байх, үүрэг гүйцэтгүүлэгчдийн эрхийн хүрээг зөв тодорхойлох, хил дамнасан дампуурлын харилцааг зохицуулсан хэм хэмжээг бий болгох зорилтууд байв.

Хуулийн төсөл эдгээр зорилгын ихэнх хэсэгт боломжит түвшинд хүрсэн гэж дүгнэхээр байх боловч сайшаалтай, магтах зүйлээс илүүтэй анхаарал татсан орхигдуулсан харилцааг энд эцэслэн тэмдэглэхийг зүйтэй. Тодруулбал, төсөлд дэлгэрүүлсэн, нарийвчилсан зохицуулалт олон байх хэдий ч төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааг нэгэнт эхлүүлсний дараа дахин хөрөнгө оруулалт хийж, санхүүжүүлж байгаа хөрөнгө оруулагч, зээлүүдэгчдийн эрх ашгийг хамгаалах зохицуулалт илт дутагдалтай байгаагаас дахин зохион байгуулалтын төлөвлөгөө амжилттай хэрэглэх боломж ихээхэн хэмжээгээр буурч байгааг анхаарах, ингэснээр хуулийн төсөл үндсэн зорилгодоо хүрч чадахгүй болохыг үгүйсгэхгүй.

Түүнчлэн төсөлд хөдөлмөрийн харилцааг тусгайлан зохицуулаагүйгээс ажил эрхлэлтийг хамгаалах, төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааны явцад хамгийн их хохирдог ажил эрхлэгчдийг хамгаалах механизм дутагдсан гэх дүгнэлт хийхээр байна.

Зорилгод хэрхэн хүрсэн талаар анхаарвал зохих дараагийн асуудал нь хил дамнасан дампуурлын харилцааг зохицуулсан хэм хэмжээг төсөл огтоос хөндөөгүй явдал юм. Энэ нь гадаадын хуулийн этгээд дампуурах тохиолдолд Монгол Улсын нутаг дэвсгэрт буй хөрөнгийг хэрхэх, түүнчлэн Монгол Улсын хуулийн этгээд дампуурах үед гадны улсад байгаа хөрөнгийг хэрхэх, эдгээр асуудлаар хил дамнасан хамтран ажиллах боломжийг олгодгоороо гадаадын хөрөнгө оруулагчдын сонирхлыг ихээхэн татдаг зохицуулалт юм. Магадгүй, өргөн хүрээний цогц шийдэл бүхий томоохон төслийг хууль санаачлагч танилцуулахдаа үе шаттай байх нь хуулийг зөв хэрэглэж зурших, анхнаасаа зөв практик тогтох боломжтой гэж үзсэн байх талтай.

Иймд төслийг цаашид боловсронгуй болгох, засан сайжруулахад дээр дурдсан асуудлуудыг анхаарах нь хуулийн төсөл үндсэн зорилгоо биелүүлэхэд ихээхэн дөхөм болохыг тэмдэглэж байна.

3.2.2. Ойлгомжтой байдал ба практикт хэрэгжих боломж шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлэх нь

Хуулийн төслийн хэллэг, нэр томьёо, найруулгыг тодорхой төвшинд сайжруулах шаардлагатай байгааг ойлгомжтой байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд дүгнэсэн байна. Олон улсын худалдааны харилцаа стандартчлагдаж, дэлхий нийтээр санхүүгийн болоод худалдааны нэгдсэн хэллэг ашиглах нь түгээмэл болсон өнөө үед энэ салбарын томоохон эх сурвалжийн нэг болсон төлбөрийн чадваргүйдлийн харилцаанд нийтлэг хэрэглэгдэх хэллэг, томьёоллыг ашиглахыг үгүйсгэхгүй. Гэсэн хэдий ч хуулийн төсөл энэ талаар гадаадын нэр томьёо хэрэглэхийг зайлсхийж, өнөөдрийг хүртэл Монголын практикт тогтсон ихэнх нэр томьёог үргэлжлүүлэн хэрэглэхээр эрмэлзсэн нь сайшаалтай.

Төсөл нэршлийн хувьд “Дампуурал” гэх нэр томъёог бус “Төлбөрийн чадваргүйдэл” гэх шинэлэг нэр томъёог хэрэглэснийг буруутгах үндэслэлгүй, харин ч төслийн үндсэн зорилго нь хуулийн этгээдийг гагцхүү дампууруулах бус үйл ажиллагааг нь сэргээх, сайжруулах, хэвийн байдалд буцаан оруулах явдал болохыг илтгэх юм. Төслөөр хүчин төгөлдөр үйлчилж буй Дампуурлын тухай хуулийн хэт ерөнхий, тодорхойгүй зохицуулалтыг нарийвчлан, хэрэг үүсгэх, хянан шийдвэрлэх ажиллагаа тодорхой болгосноороо практикт тулгардаг хүндрэлтэй асуудлыг шийдвэрлэхэд ач холбогдолтой болжээ.

Практикт хэрэглэгдэх боломж шалгуур үзүүлэлтийн хүрээнд төслийг бодитойгоор хэрэгжүүлэх бүрэн боломжтой гэсэн дүгнэлт гарсан байх ба анхаарах чухал асуудлуудад шүүгч ба хэрэг гүйцэтгэгчдийг боловсруулах, мэргэшүүлэх, шүүхийн ачааллыг анхаарч төрийн бодлогын төвшинд дэмжлэг үзүүлэх нь ихээхэн чухал хүчин зүйл болохыг дурджээ.

Хуулийн төсөлд хүний нөөцийн хувьд хангалтгүй байгаа хэрэг гүйцэтгэгчид тавигдах шаардлагыг тодорхой болгож, тусгай зөвшөөрөл олгохоор заасан байна. Гэхдээ хуулийн төслийг амжилттай хэрэгжүүлэхийн тулд хэрэг гүйцэтгэгчийн тоог нэмэгдүүлэхээс гадна, хэрэг гүйцэтгэгч нарт ногдуулах хариуцлагыг мөн нэмэгдүүлэх, түүнчлэн хэрэг гүйцэтгэгч хуулийн этгээд бус хувь хүн байх зарчмаар төслийг боловсруулах нь зүйтэй гэсэн дүгнэлт гарчээ.

Гэхдээ хуулийн төсөлд тусгагдсан хэрэг гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах, эрх олгох ажиллагааг зохион байгуулахтай холбоотой зохицуулалт нь нарийвчилсан журам батлагдсанаар хэрэгжихээр байна. Зарим төрлийн харилцааг журмаар зохицуулахаар хуульд тусгасан боловч тухайн журмыг эрх бүхий байгууллага нь батлахгүй байх нь хуулийн хэрэгжилтэд сөргөөр нөлөөлдөг тул хуулийн төсөл батлагдсанаар нэмэлт ажиллах хүч, санхүүгийн нөөц, шинэ сургалтын хөтөлбөрийг шаардах нь зайлшгүй байна.

Түүнчлэн төлбөрийн чадваргүйдлийн хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны хүрээнд зайлшгүй шаардлагатай нэгэн алхам нь шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулах цахим орчныг бий болгох явдал байна.

Өнөөдөр шүүхэд эрүү, иргэн, захиргааны хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаа бүхэлдээ цахим хэлбэрээр явагддаг бөгөөд эдгээр ажиллагаа тус бүрт тохирсон программ хангамжийг нилээд хэдэн хувилбараар боловсруулан эцэслэж сүүлийн 10 орчим жилийн турш хэрэглэж байна. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаа бүхэлдээ Иргэн 2014 гэсэн програмын тусламжтай хэрэгжиж, гагцхүү 2002 онд батлагдсан Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нийцэн хийгдэж байгаа билээ. Монгол Улс даяар гагцхүү тус программыг хэрэглэж байна. Харин хуулийн төслөөр бий болсон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа тус програмд нийцэхгүй байх тул энэ төрлийн хэргийг хянан шийдвэрлэхэд шаардлагатай програмыг бүтээх шаардлага зүй ёсоор гарч байна. Энэ нь шинэ төслийг практикт хэрэгжих бодит боломжтой болгохыг анхаарах нь зөв.

3.2.3. Зардал тооцох шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлэх нь

Зардал тооцох судалгааны үр дүнд хуулийн хэрэгжилтийн талаар үүрэг хүлээх байгууллагуудын ачаалал нэмэгдэж болохыг дүгнэсэн байна.

“Зарцуулах хугацаа ба тоон өгөгдөхүүн, гарах зардлуудыг урьдчилан тооцоолох, нийт дүнг тооцоолж гаргах ба илэрхийлэх” хэсэгт төрийн байгууллагын зүгээс үзүүлэх үүрэг нэг бүрээс үүдэн гарах ачааллыг тооцоолоход шүүхэд 0.3 орон тоо шинээр нэмэх шаардлагатай гэсэн дүн гарсан.

Гэвч тус зардлын тооцоолол нь жинхэнэ утгаараа дампуурлын ажиллагаа хэргжиж байгаагүй гэж үзэхэд төдийлөн буруудахгүй өнгөрсөн хугацааны мэдээлэлд суурилсан гэдгийг анхаарвал зохино. Тодруулбал өнгөрсөн хугацаанд хийгдсэн 165 орчим дампуурлын хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд дахин хөрөнгөжүүлэх ажиллагаа хийгдэж байсан тохиолдол нь 1 хувьд ч хүрэхгүйн зэрэгцээ дампуурсан ихэнх хуулийн этгээд нь хуваарилагдах ямар ч хөрөнгөгүй, сүүлийн жилүүдэд үйл ажиллагаагаа хэрэгжүүлж байгаагүй хуулийн этгээдүүд тул дампуурлын хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаа мөн чанарын хувьд жинхэнэ утгаараа хэрэгжиж байсан тохиолдол бараг байхгүйтэй адил юм.

Иймд төсөл батлагдсанаас хойш жинхэнэ утгаараа хэрэгжих дампуурлын хэргийн тоо хэр хэмжээгээр нэмэгдэх, эндээс хэд нь дахин зохион байгуулагдах, эсхүл шууд татан буугдах ажиллагааны зарчмаар шийдвэрлэгдэхийг урьдчилан таамаглах боломжгүй байна. Иймд зардлын тооцооллоор шүүхийн болон төрийн бусад байгууллагын ачааллын тоо харьцангуй бага хэмжээгээр нэмэгдэхээр дүгнэлт гарч байна. Энэ ч шалтгаанаар зардлын тооцоололд суурилсан шаардлагатай орон тоог нэмэгдүүлэх боломжгүй бол тухайн байгууллагад ажиллаж байгаа хүмүүсийн ачаалал огцом нэмэгдэх нь дамжиггүй.

Хуулийн төслийг боловсруулахдаа суурь болгосон, судалсан гадаад орнуудын хувьд төлбөрийн чадваргүйдлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг бие даасан худалдааны буюу дагнасан шүүх хэрэгжүүлж байсныг дурдах нь зүйтэй байна.

3.2.4. Харилцан уялдаа шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлэх нь

Хуулийн төслийг харилцан уялдаа шалгуур үзүүлэлтийн дагуу Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, Иргэний хууль болон дотоодын, олон улсын бусад эрх зүйн зохицуулалтуудтай харьцуулсан үнэлсэн байна.

Эдгээр хууль тогтоомжтой харьцуулалт хийн судлахад тухайлсан нарийвчилсан дүгнэлтээс гадна дараах нийтлэг дүгнэлт өгөх боломжтой байна.

Хуулийн төсөл нь бүхэлдээ тусгайлсан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг бий болгож байгаа тул нэр томьёо, хэллэг, ажиллагааны үе шат дарааллыг бусад хууль тогтоомжтой нийцүүлэх шаардлага зүй ёсоор гарч байна. Тодруулбал, өнөөдрийг хүртэл тогтсон дампуурлын хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааны зарчим, практик, тогтсон нэр томьёо, дараалал нь шинэ төсөлд хэрэглэсэн нэр томьёо, хэллэг, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зарчим, дараалал, системтэй нийцэхгүй болжээ.

Төсөлд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг ерөнхийд нь төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаа гэж нэрлэн liquidation буюу татан буулгах ажиллагаа, reorganization буюу дахин зохион байгуулах ажиллагаа гэсэн үндсэн хоёр хэсэгт хуваасан байна. Харин бусад хууль тогтоомжуудад “дампуурлын хэргийг хянан

шийдвэрлэх” гэх ерөнхий нэр томъёог хэрэглэж байна. Төсөлд зохицуулснаар дампуурлын хэргийг үүсгэх, нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах гэх зэрэг ойлголтууд хэрэглэгдээгүй, харин төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааг эхлүүлэх гэх үе шат байх ба энэ нь иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд хэрэглэгддэг дампуурлын хэрэг үүсгэхээс агуулга, үр дагаврын хувьд эрс өөр ойлголт юм. Иймд бүхэлдээ 1997 онд батлагдсан Дампуурлын тухай хуультай нийцүүлэн боловсруулсан бусад хуулиудад өөрчлөлт оруулах үндсэн шалтгаан болж байна.

Харьцуулан судалгаа хийсэн бусад хууль тогтоомжийн хүрээнд гаргасан үнэлгээний дүгнэлтийг хураангуйлан энэ хэсэгт авч үзье.

А. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дагуу иргэний хэргийг үүсгэж, дараах дүгнэлт гарсан байна. Үүнд:

1. Төлбөрийн чадваргүйдлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ердийн болон онцгой ажиллагаанаас ялгаатай, онцлог ажиллагаа болохынхоо хувьд хуулиар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ерөнхий хугацааг тогтоогоогүй, шүүхийн хяналтан доорх хэрэг гүйцэтгэгчийн эрх, үүрэг, хариуцлага өргөн цар хүрээтэй, шүүх, шүүгчээс явуулах ажиллагаа нь Дампуурлын тухай хуульд зааснаас эрс нэмэгдэн, татан буулгах болон дахин зохион байгуулах ажиллагаа нь нарийвчлан зохицуулагдсан, хуулийн төслийн 11.5, 18.4, 21.4 дэх зүйл, заалтад тусгагдсанаар энэ ажиллагаанд ИХШХШТХ ихэнх тохиолдолд хамаарахгүй байгаагаас үзвэл тус ажиллагаа нь бие даасан процесс ажиллагаа болох нь харагдаж байна.

Өнөөдрийн шүүхийн практикт энэ хэргийг ИХШХША-ны журмаар шийдвэрлэж байгаа бөгөөд хүчин төгөлдөр үйлчилж байгаа Дампуурлын тухай хуулийн зохицуулалт хязгаарлагдмал, тодорхойгүйн улмаас шүүх хуулийг хэрэгжүүлэхэд хүндрэл учирдаг.

Харин хуулийн төслөөр шүүхийн практикт тулгарч байгаа төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаан дахь зарим хүндрэлтэй харилцаануудыг шийдвэрлэх арга замыг тодорхойлсон, шинэлэг зохицуулалт бүхий томоохон процесс ажиллагааг зохицуулсан хэм хэмжээг тогтоож байгаагаараа ач холбогдолтой төдийгүй, цаашдаа төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаа нь ИХШХША-ны журамд хамаарахгүй болж, тус ажиллагаатай зэрэгцэн явагдах бие даасан ажиллагаа болохыг харуулж байна. Энэ ч агуулгаар энэ төрлийн хэргийг хянан шийдвэрлэх зарчмыг /талуудын болон ex officio зарчим/ хуулийн төслийн нийтлэг зохицуулалтын хэсэгт тодорхой тусгах нь зүйтэй.

2. Хуулийн төсөлд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны шүүх хуралдааны дэгийн талаар нэмж тусгах шаардлагатай байна. Учир нь дампуурлын хэргийг хянан шийдвэрлэх шүүх хуралдаан хэрхэн болох нь ойлгомжгүй байна. Энэ харилцаанд оролцогчдын онцлог байдлаас шалтгаалан Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан шүүх хуралдааны дэгийг баримтлах боломжгүй мэт анзаарагдаж байна.

3. Төлбөрийн чадваргүйдлийн харилцаанд тусгайлан өөрөөр заагаагүй бол уг харилцаанд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийг баримтлахаар заасан боловч тухайлан өөрөөр заавал зохистой зарим харилцааг орхигдуулсан байж болзошгүй байна. Тухайлбал төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааг шүүхэд

хянан шийдвэрлэх явцад гуравдагч этгээд оролцох боломжгүй гэж дүгнэхээр байх тул энэ талаар төсөл дэх хэргийн оролцогчийн хэсэгт нарийвчлан заах нь зүйтэй байна.

4. Төлбөрийн чадваргүйдлийн хэргийг эцэслэн шийдвэрлэх талаар төслийн 91 дүгээр зүйлээс зохицуулсан байх боловч энэ тохиолдолд гарах шийдвэр ямар хэлбэртэй байх нь ойлгомжгүй байна. Төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааг дуусгавар болгох ба зогсоох гэсэн хоёр үндэслэл байх бөгөөд эдгээр тус бүрт тохирсон шүүхээс гарах эрхийн актын төрлийг тодорхойлох шаардлага зүй ёсоор үүсэж байна. шүүхийн шийдвэрийг хэргийн оролцогчдод хэрхэн, ямар хугацаанд гардуулах, түүнд ямар хугацаанд давж заалдах болон хяналтын журмаар гомдол гаргах гэх мэт.

5. Хуулийн төсөлд урьдчилсан төлбөрийн хэмжээг тооцох журмыг батлах, хэрэг гүйцэтгэгчийн үйл ажиллагааны эрх олгох сонгон шалгаруулах журмыг батлах, хэрэг гүйцэтгэгчийн нэрсийн жагсаалтыг цахим санд байршуулах зэрэг асуудлыг Хууль зүйн болон Санхүү төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлэх, шүүх хэрэг гүйцэтгэгчийг цахим хэлбэрээр тохиолдлын журмаар сонгох, шүүх хэрэг гүйцэтгэгчид үнэмлэх олгох, буцаан авах гэх мэтээр нэмэлт үүргүүд бий болжээ.

Шүүхэд нэмэлт үүрэг бий болгосон байдлаас гадна, шүүх төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааны бүх үе шатанд хяналт тавьж, шийдвэр гаргахаар зохицуулсан ажиллагаанууд нь шүүхийн ачаалалд ихээхэн нөлөөлөхөөр байгааг анхаарч зарим тодорхой ажиллагаануудыг хэрэг гүйцэтгэгчээр гүйцэтгүүлж, шийдвэрлүүлэхээр шүүхээс даалгах боломжтой байдлаар зохицуулах нь зүйтэй байна.

Б. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуультай төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийн төслийг харьцуулахад дараах асуудлыг нийцүүлэх шаардлага байгаа талаарх дүгнэлтээс дурдвал:

Нэгдүгээрт, хуулийн төсөлд шүүхийн шийдвэр нэгэнт гарсан нэхэмжлэлийг ч мөн нэгэн адил шүүхэд дахин гаргаж, аливаа маргаангүйгээр батлагдсан шаардлагад багтахаар зохицуулсан бөгөөд энэ ч агуулгаар хэрэг гүйцэтгэгч хуваарилагдах хөрөнгөөс энэ төрлийн шаардлагыг шууд хангахаар заажээ. Гэтэл Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиар энэ төрлийн шаардлагатай холбогдуулан хөрөнгийг хураасан битүүмжилсэн бол энэ нь төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаа эхэлсэн эсэхээс үл хамааран хүчинтэй байхаар заасныг нийцүүлэх нь зүйтэй байна.

Хоёрдугаарт, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд тус хуулийн дагуу нэгэнт эхэлсэн ажиллагааны гүйцэтгэх баримт бичгийг хэрэг гүйцэтгэгчид шилжүүлэх, ийнхүү шилжүүлсэн гүйцэтгэх ажиллагаанд шалгалт хийх, хяналт тавих боломжтой байхаар зохицуулсныг зарчмын хувьд дэмжин төсөлд илүү тодорхой байдлаар суулгаж өгөх нь зүйтэй байна.

Гуравдугаарт, холбогдох шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг хүчин төгөлдөр үйлчилж байгаа Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуультай харьцуулах үед хэрэг гүйцэтгэгчид тодорхой тохиолдлуудад шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны давуу талуудаас ашиглах боломжийг олгох нь зүйтэй гэж үзжээ. Тодруулбал, өнөөгийн манай нөхцөл байдлаас шалтгаалан хуваарилагдах

хөрөнгийг худалдах, нэхэмжлэгчдийн хурлыг зарлах зэрэг олон хүмүүсийг хамарсан өргөн хүрээний арга хэмжээг зохион байгуулах бол хурлын танхим, зарим төрлийн эд хөрөнгийг худалдах тусгай зориулалтын байр талбай дутмаг зэрэг нөхцөл байдлуудыг харгалзаж энэ талаар хэрэг гүйцэтгэгч шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тусламжийг авах боломжийг олгох байдлаар төсөл болон дагалдах хуулийн нэмэлт, өөрчлөлтийг боловсруулах нь зүйтэй байна.

В. Хуулийн төслийг Иргэний хуультай харьцуулахад Иргэний хуулийн хүрээнд төслийн зүйл заалтуудыг Иргэний хуулийн зарчимд нийцүүлэн өөрчлөхөөс гадна төсөлд орсон нарийвчилсан зохицуулалтаас шалтгаалан Иргэний хуулийн заалтыг өөрчлөх, эсхүл хасах шаардлага байна. Үүнд:

Нэгдүгээрт, Иргэний хуульд төлбөрийн чадваргүйдлийн хэргийг хянан шийдвэрлэх явцад нэхэмжлэлийн шаардлагыг хангах дарааллыг тогтоосон байх боловч энэ нь төсөлд туссан үндсэн зарчимтай нийцэхгүй байгааг төсөлд нийцүүлэн өөрчлөх шаардлага байна.

Хоёрдугаарт, Иргэний хуулиар нэгэнт зарчмыг тогтоосон материаллаг хэм хэмжээтэй төслийн зүйл заалтуудыг нийцүүлэх шаардлага байна. Тодруулбал, төлөөллийн харилцаа ба хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд эрх залгамжлан авах, хүүгийн шаардлагыг тодорхойлох, хангах, хамтран үүрэг гүйцэтгэх зарчим, ойлголтуудыг Иргэний хуулийн үндсэн зарчимтай нийцүүлж төслийн заалтыг боловсронгуй болгох нь зүйтэй байна.

3.3. Үнэлгээний үндсэн дээр зөвлөмж гаргах нь

Төслийн үр нөлөө тооцох судалгааны ажлын хүрээнд гарсан дээр дурдсан дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг гаргаж байна. Үүнд:

1. Төслийг найруулгын хувьд улам сайжруулах шаардлагатай байна. Хэдийгээр Дампуурлын бие даасан хууль батлагдаж хэрэглэгдээд 20 гаруй жилийг ардаа орхисон байх боловч шинэ төсөл нь зарчмын томоохон өөрчлөлтийг санал болгож, шинэлэг олон хэллэг, ойлголтыг төлбөрийн чадваргүйдлийн харилцаанд бий болгожээ. Иймд төслийг шууд хэрэглэхэд хүндрэлтэй, ойлгохгүй байх тохиолдол гарахаас аль болох сэргийлэх үүднээс хамгийн боломжит байдлаар энгийн тодорхой байдлаар найруулахыг эрмэлзэх нь зүйтэй.
2. Төсөл нь иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ердийн болон онцгой ажиллагааны аль ч төрөлд шууд хамаарах боломжгүй бие даасан онцлог төрлийн ажиллагаа байх тул шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд баримтлах зарчмыг хуулийн төсөлд тусгах зайлшгүй шаардлагатай байна.
3. Төслийн зорилго олон улсын жишигт нийцсэн Төлбөрийн чадваргүйдлийн харилцааг зохицуулсан хэм хэмжээг бүтээх явдал байх тул үндэстэн дамнасан төлбөрийн чадваргүйдлийн харилцааны анхан шатны хийгээд зарчмын хэм хэмжээг тусгах, нэмэх нь зүйтэй. Төсөл эдийн засгийн тогтвортой өсөлтийг дэмжих, нийгмийн бодлого, ажилгүйдлийг бууруулахад тус дөхөм болох үүднээс дахин зохион байгуулалтын ажиллагааг амжилттай болох түлхүүр хүчин зүйл дахин санхүүжилтийн асуудлыг одоо байгаагаас дэлгэрүүлэх, төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаан дахь хөдөлмөрийн эрх зүйн нарийвчилсан зохицуулалтыг нэмж зохицуулах нь чухал байна.
4. Төслийг хэрэгжүүлэх үндсэн хоёр субъект болох шүүх, хэрэг гүйцэтгэгчийн чадавхийг дээшлүүлэх, шаардлагатай хүний нөөцөөр хангаж, ажлын ачааллыг

бууруулах үүднээс төсөл хэрэгжиж эхлэхээс өмнө ба хойно үргэлжлүүлэн авах арга хэмжээг холбогдох төрийн байгууллага цаг алдалгүй төлөвлөх, энэ чиглэлээр шаардлагатай бэлтгэл ажлыг эхлүүлж байх нь зүйтэй. Хэрэг гүйцэтгэх ажиллагааг хуулийн этгээд хэрэгжүүлэх нь ойлгомжгүй бөгөөд сөрөг үр дагавартай байх тул энэ үзэл баримтлалаас зайлсхийх, мөн төлбөрийн чадваргүйдлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлэх шүүхийн төрөлжсөн байх шаардлага ирээдүйд гарч болзошгүйг ч анхаарах нь зүйтэй байна.

5. Төслийн бусад хууль тогтоомжтой уялдаа холбоог дахин сайтар анхаарч судалгаанд хөндсөн чиглэлүүдээр төслийг сайжруулах шаардлагатай байна. Судалгаанд голлон авч үзсэн Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх тухай хууль, Иргэний хуулиудтай төслийн харилцан уялдааг хангахдаа дан ганц эдгээр хуультай төслийг нийцүүлэх бодлогыг баримтлах бус зарим тохиолдолд эдгээр хуулиудыг төсөлтэй нийцүүлэх ч шаардлага байгааг анхаарах нь чухал байна.
6. Төслийг практикт бодитой хэрэгжих, үндсэн зорилгоо хангахад шаардлагатай төрийн албан хаагчдын орон тоог нэмэх, сургах, мэргэшүүлэх, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны цахим ажиллагааг хангахад төрөөс тодорхой зардлууд гарахаар байгааг анхаарч энэ чиглэлээр бэлтгэл ажлыг хангах шаардлагатай байна.

---oooOOooo---

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

I.Олон улсын баримт бичиг

1. Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газраас хийж гүйцэтгэсэн Дампуурлын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ, 2018 он
2. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Олон улсын худалдааны эрх зүйн комиссоос гаргасан Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийн төслийг боловсруулах тухай зөвлөмж, 2005 он
3. Европын холбооны улс орнуудын тайлан илтгэл 2016 он
4. Төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааны үр дүнтэй систем ба үүрэг гүйцэтгүүлэгч/үүрэг гүйцэтгэгчийн эрхийн зарчмууд-Дэлхийн банк 2015

II.Монгол болон гадаад хэлээр бичигдсэн ном, гарын авлага, өгүүлэл

5. Хууль зүйн үндэсний хүрээлэн, Д.Зүмбэрэллхам, Л.Банзрагч, Б.Ундрах, Ж.Алтансүх, Аж ахуйн нэгжийн дампуурал ба дахин хөрөнгөжүүлэх ажиллагаа, харьцуулсан судалгаа, 2015 он
6. Н.Баярмаа, Д.Эрдэнэчимэг, Дампуурлын эрх зүйн зохицуулалтын харьцуулсан судалгаа
7. Хуулийн төсөлтэй холбогдуулан төрийн болон төрийн бус байгууллагаас ирүүлсэн санал
8. Хэрэг гүйцэтгэгч нараас хуулийн төслийн хэрэгжилттэй холбогдуулан тусгайлан өгсөн санал
9. Janis P.Sarra, Ronald B.Davis, Director & Officer Liability in Corporate Insolvency, 2nd edition, LexisNexis, 2010
10. Jay Lawrence Westbrook, Charles D.Booth, Christoph G Paulus & Harry Rajak, A Global view of Business insolvency systems, The Worldbank, Washington DC, 2010
11. Philip Smart, Charles D Booth, Stephen Briscoe Hong Kong Corporate Insolvency Manual, 2002
12. Ko Haksoo, Korea's newly enacted bankruptcy act5 The role of new act in facilitating the transfer of corporate control, Pacific Basin law journal, 2017

III.Интернет эх сурвалж

13. <https://ilawyersince1991.files.wordpress.com/2014/10/ecb184ebacb4ec9e90-ed9a8cec839d-ebb08f-ed8c8cec82b0ec9790-eab480ed959c-ebb295eba5a0-ec9881ebacb8-ebb295eca084.pdf>